



ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

Мөрдөгч, прокуроруудад зориулсан гарын авлага



2024 он
Улаанбаатар хот



ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

Мөрдөгч, прокуроруудад зориулсан гарын авлага

2024 он
Улаанбаатар хот

Тус гарын авлагыг Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар, Төрийн Департаментын дэргэдэх Олон улсын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчооны санхүүжилтээр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын хэрэгжүүлж буй “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” (2021-2024) төслийн хүрээнд бүтээв.

ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН:

Л. Мөнхцэцэг	Төслийн зөвлөх
Л. Мандваа	Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүйн хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн
У. Эрдэнэтуяа	Гадаад харилцаа эрх зүйн туслалцааны хэлтсийн хяналтын прокурор

ГАРЫН АВЛАГА ХЯНАСАН:

Ч. Хосбаяр	Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн
Б. Батцэрэн	Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч
Ц. Насанбат	Улсын ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга
Ч. Хандаамаа	Бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн хяналтын прокурор
Ч. Жаргалбаатар	Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга, ахлах комиссар
Б. Эрдэнэбаяр	Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа
Н. Одонтуяа	ОУЭЗХБ-ын Хөтөлбөрийн менежер

Зохиогчийн эрх©2024. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)
Энэхүү гарын авлагын агуулга, үзэл бодлыг зохиогчид бие даан боловсруулсан бөгөөд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, түүний гишүүд, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй болно.

Зохиогчийн эрхийн дагуу хамгаалагдсан. Энэхүү гарын авлагыг сургалтын зорилгоор ашиглах бол албан ёсны зөвшөөрөл авч, эх сурвалжийг дурдсаны үндсэн дээр үнэ төлбөргүй ашиглаж болно. Үүнээс өөр шалтгаанаар олшруулах, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээхийг хориглоно. Дахин хэвлэх бол Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авна.

Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж,
Бодь цамхаг, 603 тоот
Улаанбаатар 15160, Монгол Улс
 www.idlo.int  @IDLOnews

ӨМНӨХ ҮГ

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын хамтын ажиллагааны чухал хэлбэр нь эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа юм. Энэхүү ажиллагаа нь үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд үр нөлөөтэй арга хэрэгсэл болж байна.

Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт “Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцааны гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг хоёр дахин нэмэгдүүлэх болон дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна” гэж заасан. Гарын авлагын нэгдүгээр бүлэгт “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа”-ны тухай тусгасан ба ялангуяа эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах, хэрэглэх асуудлыг илүү анхаарч дурдсан.

Түүнчлэн авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд нэн тэргүүнд хийх алхам нь олон улсын түвшинд зохион байгуулагддаг хөрөнгө буцаан авах ажиллагаа болохыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод тодорхойлсон. Авлига, албан тушаалын болон татвар төлөхөөс зайлсхийх зэрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол нь тухайн улс орны хувьд нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөхүйц байгаа өнөөгийн нөхцөлд олон улсад хөрөнгө буцаах ажиллагааг зохион байгуулахад онцгойлон анхаарах шаардлагатай байна. Гарын авлагын хоёрдугаар бүлэгт хөрөнгө буцаан олгох ажиллагааны талаар тодорхой тусгасан.

Мөн шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжихийн хирээр гэмт хэрэг үйлдэхэд хамгийн сүүлийн үеийн технологиуд ихээр ашиглагдаж байгаа нь тэдгээрийг илрүүлэх, шалгах арга замыг шинээр бий болгож байгаа ба үүнээс үүдэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт цахим нотлох баримтыг дэлхийн түвшинд хэрэглэж байна. Гарын авлагын гуравдугаар бүлэгт нотлох баримтыг бэхжүүлэх цахим арга хэрэгсэл болон цахим хэлбэрээр оршиж буй мэдээллийг хамааруулан эдгээр ойлголттой холбоотой нийтлэг зохицуулалт, практик хэрэглээний талаар тусгасан.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны үр дүн, ач холбогдол нь тухайн ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч байгууллагын гүйцэтгэх үүрэг хариуцлага, хүчин чармайлтаас шалтгаална. Иймээс эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын ажилтнууд буюу мөрдөгч, прокурорын ажилд дэмжлэг үзүүлэх, тэднийг чадавхжуулах зорилгоор энэхүү гарын авлагыг боловсрууллаа. Гарын авлагыг практикт ашиглахад хялбар хүртээмжтэй болгох, хуулийн хэрэглээг сайжруулах үүднээс тухайн сэдвийг Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжийн заалттай уялдуулан тодорхойлсон болно.

Зарим сэдвийн хувьд эрх зүйн орчин бүрдээгүй байх тул холбогдох олон улсын гэрээ конвенц, гадаад орны хууль тогтоомж, тэдний сайн туршлагыг тусгасан ба энэ нь нэг талаар тухайн улстай эрх зүйн туслалцааны чиглэлээр харилцахад мэдлэгтэй

болох, нөгөө талаар дурдагдсан сэдвийн талаар тодорхой ойлголттой болох, улмаар шаардлагатай хуулийн зохицуулалт бий болгоход тус дөхөм болно гэж үзэж байна.

Гарын авлагыг Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” төслийн хүрээнд боловсруулан хүргэж байна. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны тухай гарын авлага”-ыг бэлтгэх, хэвлэх зэрэг ажиллагааг хариуцан зохион байгуулсан тус төслийн хамт олонд талархал илэрхийлье.

Гарын авлага боловсруулах явцад Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн Ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн газрын төлөөлөл бүхий шинжээчдийн баг санал зөвлөмж өгч, удаа дараа хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллалаа.

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

1.1.Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх эрх зүйн үндэслэл

- 1.1.1.Олон улсын гэрээ конвенц
- 1.1.2.Бусад үндэслэл

1.2.Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ

- 1.2.1.Гэрээ байгуулах
- 1.2.2.Эрх бүхий төв байгууллага
- 1.2.3.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээ
- 1.2.4.Гэрээний хугацаа

1.3.Эрх зүйн туслалцааны хүсэлт

- 1.3.1.Гадаад улсад явуулах эрх зүйн туслалцааны хүсэлт боловсруулах
- 1.3.2.Гадаад улсаас эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээж авах, биелүүлэх

ХОЁРДУГААР БҮЛЭГ.ХӨРӨНГӨ БУЦААХ АЖИЛЛАГАА

2.1 Хөрөнгө буцаах ажиллагааг явуулах эрх зүйн үндэслэл, арга хэлбэр, төрөл

- 2.1.1. Хөрөнгө буцаах ажиллагааны талаар
- 2.1.2.Эрх зүйн үндэслэл, эх сурвалж, баримтлах зарчмууд
- 2.1.3. Гадаад улсад илгээх хөрөнгө буцаах тухай хүсэлтийн загвар
- 2.1.4. Гадаад орны хуульд заасан тусгай шаардлагууд
- 2.1.5. Виртуал хөрөнгийг буцаах ажиллагаанд анхаарах асуудал
- 2.1.6.Хөрөнгө буцаах талаар гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэх

2.2. Хөрөнгө буцаах талаар хүсэлтийг илгээхээс өмнөх ажиллагаа

- Хүсэлтийг илгээхээс өмнө бүрдүүлэх мэдээлэл
- Нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах
- Олон улсын байгууллага, сүлжээ

2.3. Хөрөнгө буцаах ажиллагааны төрлүүд

- 2.3.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хөрөнгө буцаах
- 2.3.2 Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хөрөнгө буцаах

2.4.Хөрөнгийн менежмент

- 2.4.1. Хөрөнгийн менежментийн талаарх ойлголт, хэлбэр, анхаарах асуудал
- 2.4.2.Хөрөнгийн менежментийн талаарх үндэсний эрх зүйн орчин, практик хэрэглээ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАДААД УЛСААС ЦАХИМ НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ АЖИЛЛАГАА

3.1. Цахим нотлох баримтын талаар ерөнхий ойлголт

3.2. Цахим нотлох баримтын талаар эрх зүйн зохицуулалт

3.2.1. Дотоодын эрх зүйн орчин

3.2.2. Гадаад улсуудын болон олон улсын эрх зүйн орчин

3.3. Гадаад улсаас цахим нотлох баримт олж авах практик алхмууд

3.3.1. Цахим нотлох баримтыг хамгаалах, хадгалах арга хэмжээ авах

3.3.2. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт илгээхээс өмнөх ажиллагаа

3.4. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт илгээх

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

1.1. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх эрх зүйн үндэслэл

1.1.1. Олон улсын гэрээ конвенц

Тухайн улс өөрийн нутаг дэвсгэрт болсон хэрэг маргааныг шийдвэрлэх боловч улс орон дамнасан, өөр улсын эрх ашгийг хөндсөн, гадаадын иргэн, хуулийн этгээд оролцсон хэргийг дангаар шийдвэрлэхэд багагүй бэрхшээл учирдаг. Гэмт хэрэг зөвхөн тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх төдийгүй илүү зохион байгуулалттай, хил дамнасан шинжтэй болж байгаа тул бусад орны ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллаж зарим гэмт хэргийг нотлох, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх шаардлага үүсдэг. Энэ тохиолдолд улс орнууд нэг талаас өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хангах, нөгөө талаас нутаг дэвсгэр дээрээ бусад улсын шүүх эрх мэдлийн эрх ашгийг хангах шаардлагын улмаас эрх зүйн туслалцаа харилцан үзүүлдэг.¹

Эрх зүйн харилцан туслалцаа гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд гадаад улсад байгаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нотлох баримтыг олж авах албан ёсны үйл ажиллагааг хэлнэ.²

Манай улс гадаад улстай олон талт болон хоёр талт олон улсын гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлдэг.

Олон талт олон улсын гэрээ конвенц

Олон талт олон улсын конвенц гэрээ хэлэлцээрүүд нь олон улсын эрх зүйн дагуу талууд заавал дагаж мөрдөх буюу эрх зүйн туслалцаа үзүүлэх үүрэг хүлээлгэсэн заалтууд агуулдаг. Дээрх заалтууд нь хамтын ажиллагааны цар хүрээ болон хэрэглэх процессуудыг тодорхойлж, урьдчилан тооцоолох боломж болон тодорхой байдал бий болгодог³. Монгол Улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баталсан 25 олон талт гэрээ⁴ (конвенц)-д нэгдэн орсон. Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах нь Олон улсын гэрээний тухай хуулиар зохицуулагдах ба тухайн гэрээг заавал биелүүлэхээ олон улсын хэмжээнд зөвшөөрсөн үйлдэл болно.

Эдгээр олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсноор авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль бусаар олсон орлого,

1 “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь” УБ, 2009., 5 дахь тал

2 “Авлигатай тэмцэх гарын авлага” ЕАБХАБ, 2016., 228 дахь тал /www.osce.org/

3 Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020., 249 дэх тал.

4 Монгол улсын нэгдэн орсон эрх зүйн баримт бичгийн жагсаалт, <http://www.vienna.embas-sy.mn/index.php?moduls=15>.

эд зүйл, хөрөнгийг буцаан авах асуудлаар гишүүн орнууд холбогдох байгууллагаараа дамжуулан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх салбарт хамтран ажиллах боломж бүрдсэн.

Эрх зүйн туслалцааны хүсэлт боловсруулахад тухайн гэмт хэргийн шинж, хэргийн нөхцөл байдлаас хамааран нэг буюу хэд хэдэн олон улсын конвенц болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн алийг нь хэрэглэж болох, аль нь илүү үр дүнтэй болохыг анхаарах нь чухал юм. Иймээс эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхийг хүсэхээр төлөвлөж буй улс нь Монгол Улсын нэгдэн орсон конвенцын гишүүн эсэхийг тодруулах хэрэгтэй.⁵

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлын талаар тусгасан зарим олон улсын конвенцыг дурдахад⁶:

№	Нэр	Монгол Улс соёрхон баталсан он	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай заалт
1	Авлигын эсрэг конвенц /United Nations Convention against Corruption/ ⁷	2005 он	Конвенцын 46 дугаар зүйлд эрх зүйн туслалцааны талаар заасан.
2	Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай конвенц /International Convention for the Suppression of the Financing of Terrorism/ ⁸	2003 он	Конвенцын 12 дугаар зүйлд эрх зүйн туслалцааны талаар заасан.
3	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц /United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances/ ⁹	2001 он	Конвенцын 7 дугаар бүлэгт эрх зүйн туслалцааны талаар заасан.
4	Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц /United Nations Convention against Transnational Organized Crime/ ¹⁰	2006 он	Конвенцын 18 дугаар зүйлд эрх зүйн туслалцааны талаар заасан.

5 Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаал

6 Эрх зүйн акт дэлгэрэнгүй (legalinfo.mn)

7 [http://www.unodc.org/documents/treaties/UNCAC/ Publications/Convention/08-50026_E.pdf](http://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026_E.pdf)

8 http://www.paclii.org/vu/legis/consol_act/icftsofota769

9 http://www.unodc.org/documents/commissions/Conventions/ebook/13-85380_Ebook_WEB.pdf

10 [http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/ Publications/TOC%20Convention/TOCe-book-e.pdf](http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCe-book-e.pdf)

5	Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц /International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance/ ¹¹	2014 он	Конвенцын 14 дүгээр зүйлд эрх зүйн туслалцааны талаар заасан.
6	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц /United Nations Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment/ ¹²	2000 он	Конвенцын 9 дүгээр зүйлд эрх зүйн туслалцааны талаар заасан.
7	Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц /UNESCO Convention on the Means of Prohibiting and Preventing the Illicit Import, Export and Transfer of Ownership of Cultural Property/ ¹³	1991 он	Конвенцын 13 дугаар зүйлд хамтын ажиллагааны талаар заасан.

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянах, шүүх ажиллагаа дахь эрх зүйн харилцан туслалцааны тухай зохицуулалтыг агуулдаг, улс орнуудын хооронд нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн авлигатай тэмцэх хамтын ажиллагааны баримт бичиг болох Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь 8 бүлэг, 71 зүйлээс бүрдэнэ. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх талаар заасан 46 дугаар зүйл нь 30 хэсгээс бүрдэж байгаа нь уг асуудлыг бусад олон улсын гэрээтэй харьцуулахад илүү тодорхой зохицуулсныг харуулна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц:

46 дугаар зүйл. Эрх зүйн харилцан туслалцаа

7. Тухайн оролцогч улсууд хоорондоо эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулаагүй тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийн хувьд энэ зүйлийн 9-өөс 29 дэх хэсгийг хэрэглэнэ. Хэрэв эдгээр оролцогч улс хоорондоо эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан бөгөөд тухайн гэрээний оронд энэ зүйлийн 9-29 дэх хэсгийг хэрэглэхээр тохиролцоогүй бол тухайн гэрээний холбогдох заалтыг хэрэглэнэ. Хамтын ажиллагаанд нь тус дөхөм болох бол энэ зүйлийн эдгээр заалтыг хэрэглэхийг оролцогч улсуудад тууштай санал болгож байна.

11 https://treaties.un.org/doc/publication/ctc/ch_iv_16.pdf

12 https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtsg_no=IV-9&chapter=4&-clang=_en

13 <https://en.unesco.org/about-us/legal-affairs/convention-means-prohibiting-and-preventing-illicit-import-export-and>

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцын 14 дүгээр зүйлийн 1-д “Оролцогч улсууд хүчээр алга болгох гэмт хэргийн талаар үүсгэсэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбогдуулан эрх зүйн харилцан туслалцааг өөр хоорондоо дээд зэргээр үзүүлнэ, түүний дотор байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай бөгөөд тэдний мэдэлд байгаа бүх нотлох баримтыг гаргана” гэж заасан.

Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан олон улсын гэрээний талаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo.mn/-ийн “Монгол улсын олон улсын гэрээ” гэсэн ангиллаас үзэж болно. Хүчин төгөлдөр олон улсын гэрээ, олон улсын гэрээний албан ёсны орчуулгын талаар болон олон улсын гэрээ нь Төрийн мэдээллийн эмхэтгэлд болон бусад байдлаар албан ёсоор хэвлэн нийтлэгдсэн тухай Гадаад харилцааны яамны Гэрээ эрх зүйн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гадаад хамтын ажиллагааны газраас мэдээлэл авах боломжтой.

Дээр дурдсантай холбоотой хуулийн заалтаас дурдахад:

Олон улсын гэрээний тухай хууль ¹⁴	Холбогдох хэсгийн агуулга
7 дугаар зүйл. Олон улсын гэрээ үйлдэх хэл, орчуулга	7.6. Олон талт олон улсын гэрээний хувьд уг гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээг монгол хэлнээ орчуулж, гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэх асуудлын хүрээнд тухайн орчуулгыг хянан баталгаажуулна.
30 дугаар зүйл. Олон улсын гэрээг нийтлэх	30.1. Улсын Их Хурал соёрхон баталсан олон улсын гэрээг тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан хуулийн хамт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.
31 дүгээр зүйл. Олон улсын гэрээг хадгалах	31.1. Олон улсын гэрээний эх бичвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хадгална.
32 дугаар зүйл. Олон улсын гэрээний бүртгэл хөтлөх	32.1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын хоёр талт болон олон талт олон улсын гэрээний бүртгэл хөтөлнө.
Хууль тогтоомжийн тухай хууль ¹⁵	Холбогдох хэсгийн агуулга

14 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №02

15 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015 он, №25

45 дугаар зүйл.Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх	45.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн нэгдсэн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх, хууль тогтоомжийг системчлэх ажлыг хариуцан зохион байгуулна. 45.2.Энэ хуулийн 45.1-д заасан санд Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийг соёрхон баталсан тухайн гэрээний хамт оруулна.
--	---

Олон улсын гэрээ конвенцын заалтыг хэрэглэхэд тухайн олон улсын конвенцод заасан үүргийг дотоодын хууль тогтоомжид тусгасан эсэх буюу “нутагшуулсан” эсэхийг анхаарах шаардлагатай.

Зарим улс дотоодын хууль тогтоомжоор тодорхой зохицуулалт хийж өгдөг бол зарим нь бүрэн бус зохицуулалттай эсхүл олон улсын гэрээг нутагшуулсан ямар ч зохицуулалт хийхгүйгээр харин хэрэгжиж буй Эрүүгийн хууль болон процессын хуулийн дутууг гэрээний заалтад тулгуурлан нөхөж хэрэглэх нь бий.¹⁶ Тус улсын хувьд Олон улсын конвенцын заалтад холбогдох дотоодын хууль тогтоомжийн заалтыг нийцүүлж, тусгасны үндсэн дээр хэрэгжүүлж ажилладаг.

Олон улсын гэрээний тухай хуулиас:

34 дүгээр зүйл. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль шинээр батлах

34.4.Олон улсын гэрээ байгуулснаар, олон улсын гэрээнд нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хүчин төгөлдөр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай эсэхийг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тодорхойлно.

Хоёр талт олон улсын гэрээ

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагаа нь ихэвчлэн улс хоорондын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс болсон хоёр талт гэрээ буюу эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний дагуу явагддаг

Нэгдсэн Үндэстний Байгууллага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх асуудлаар хамтын ажиллагаагаа сайжруулах зорилго бүхий улс орнуудын хоёр талт гэрээ байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх баримт бичиг болсон “Эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх загвар гэрээ”-г¹⁷ боловсруулан гаргасан нь эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулахад ашиглах гол үндэслэл болж байна.

16 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага”: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020., 250 дахь тал.

17 http://www.unodc.org/pdf/model_treaty_mutual_assistance_criminal_matters.pdf

Монгол Улс одоогийн байдлаар эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай 19 гэрээг байгуулсан байна. /Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний талаар 1.2-ыг үзнэ үү/

Бүс нутгийн хэмжээнд ихэвчлэн үйлчилдэг олон улсын гэрээ, хэлэлцээр

Хамтын ажиллагааны энэ хэлбэрийн талаар өргөн хүрээний заалт бүхий гэрээнд хамаарах зарим олон улсын гэрээ конвенцыг дурдахад: Авлигатай тэмцэх Америкийн улсууд хоорондын конвенц, Өмнөд Африкийн оролцогч улсууд болон Европын Холбооны оролцогч улсуудын хооронд Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай 2000 оны конвенц ба үүний 2001 оны нэмэлт протокол, мөн Эрүүгийн асуудлаар харилцан туслалцах тухай Арабын улсуудын холбооны 1983 оны конвенц¹⁸ Иргэн, гэр бүл, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн харилцааны тухай 1993 оны конвенц¹⁹ (Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн улсууд хоорондын), Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай 2004 оны гэрээ²⁰ (Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн гишүүн улсууд хоорондын) зэрэг болно.

Бүс нутгийн хэмжээнд ихэвчлэн үйлчилдэг олон улсын гэрээ, хэлэлцээр нь улс болгонтой тусгайлсан гэрээ байгуулахгүйгээр улс орнуудтай сайн дурын болон бүс нутгийн хэмжээнд харилцан туслалцаа үзүүлэх механизм бий болгон хамтран ажиллах явдал юм. Жишээ нь: Европын Холбоо нь эрүүгийн хэргээр хамтран ажиллах нэгдсэн стандартыг Европ тивийн хэмжээнд бий болгох зорилгоор Европын Зөвлөлөөс 1959 онд гаргасан Эрүүгийн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенц²¹ болон түүний нэмэлт протоколууд үйлчилж байна.

1.1.2.Бусад үндэслэл

Харилцан адил байх зарчим

Хоёр талт, эсхүл олон талт гэрээ хэлэлцээр байхгүй тохиолдолд харилцан адил байх зарчмын үндсэн дээр эрх зүйн туслалцаа үзүүлж болно. Харилцан адил байх зарчим гэж тухайн харилцааг зохицуулсан олон улсын гэрээгүй тохиолдолд хүсэлт гаргагч улсаас ижил төрлийн туслалцааг үзүүлэх баталгааг хүсэлт хүлээн авагч талд гаргах дипломат харилцаанд хэрэглэгддэг олон улсын эрх зүйн зарчмыг ойлгоно. Эрх зүйн туслалцааны хүсэлт гаргагч улс нь “Харилцан туслалцах амлалт” өгөх буюу Promise of Reciprocity гэдэг нь хүсэлт хүлээн авагч улсад ижил төрлийн эрх зүйн туслалцаа шаардагдсан тохиолдолд хүсэлт гаргагч улс нь адилхан туслалцаа үзүүлнэ гэсэн амлалт юм²². НҮБ-ын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн конвенцуудын нийтлэг

18 UNCAC, Technical guide, 2009. http://www.unodc.org/documents/corruption/Technical_Guide UNCAC.pdf

19 <https://cis.minsk.by/page/614>

20 <https://asean.org/wp-content/uploads/2021/01/20160901074559.pdf>

21 <http://www.coe.int/fr/web/conventions/fulllist/-/conventions/rms/0900001680065ce>

22 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны гарын авлага УБ, 2015., 21 дэх тал

шаардлагын дагуу ихэнх улсууд “харилцан адил байх зарчмыг” хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ тухайгаа дотоодын хууль тогтоомждоо тусгасан байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд²³ заасан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт этгээд, ялтан шилжүүлэх хүсэлтийг биелүүлэх эрх зүйн үндэслэлд харилцан адил байх зарчмыг хэрэглэх зохицуулалт тусгагдаагүй ба харин Прокурорын тухай хуульд²⁴ харилцан адил байх зарчмын талаар заасан.

Прокурорын тухай хуулиас:

26 дугаар зүйл. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх

26.2. Прокурор энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3-т заасан ажиллагааг олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх, олон улсын гэрээгээр зохицуулагдаагүй тохиолдолд **харилцан адил байх зарчимд** тулгуурлан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлж болно.

Зарим улсын Эрүүгийн процессын хуульд эрх зүйн туслалцаа үзүүлэхэд харилцан адил байх зарчмыг үндэслэхээр тусгасан байдаг. Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улсын Эрүүгийн процессын хуулийн²⁵ 558 дугаар зүйлд, Оросын Холбооны Улсын Эрүүгийн процессын хуулийн²⁶ 453 дугаар зүйлд эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах тухай заасан ба олон улсын гэрээ хэлэлцээр байхгүй нөхцөлд харилцан адил байх зарчимд үндэслэнэ хэмээн тус тус тусгажээ.

Зарим улс хоёр талт гэрээгүй улс орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль тогтоомж баталсан байдаг ба ихэвчлэн харилцан адил байх зарчмыг үндсэн шалгуур болгодог. Тухайлбал, Эрүүгийн хэргээр олон улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Бүгд Найрамдах Беларусь Улсын хууль²⁷ нь харилцан адил байх зарчимд үндэслэн эрх зүйн туслалцаа хэрхэн үзүүлэх талаарх зохицуулалт бүхий хууль юм.

Үндэсний хууль тогтоомж

Үндэсний хэмжээнд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудал нь Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагддаг. Энэхүү хууль нь холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрийн хамт тус улс болон гадаад улсын хооронд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлын хэмжээ хязгаар, нөхцөл журмыг тодорхойлдог.

Шинэчлэн найруулж 2002 онд баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “Монгол Улсын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор,

23 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

24 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24

25 https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/blr/2004/___html/Belarus_Law_on_International_Legal

26 https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/

27 https://sherloc.unodc.org/cld/uploads/res/document/blr/2004/___html/Belarus_Law_on_International_Legal_Assistance_in_Criminal_Matters_RU.pdf

шүүхийн байгууллага болон гадаад улсын холбогдох байгууллагын эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа” гэсэн дөчин тавдугаар бүлэг нэмж, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлыг анх удаа хуульчилж тусгасан.

2017 онд шинэчлэн батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа” гэсэн дөчин хоёрдугаар бүлэг болж тусгагдсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас:

42.1 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргах

1. Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг нэгжлэг хийх, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн²⁸ Аравдугаар зүйлд “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” гэж, “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж тодорхойлсон.

Эрүүгийн хуулиас²⁹:

1.2 дугаар зүйл. Хууль ёсны зарчим

4. Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлыг зохицуулах дотоодын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох бусад хуулиас бүрдэж байна. Мөн тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад баримт бичгийг мөрдөж байна.

Бусад улсын хувьд зарим нь Эрүүгийн процессын хуульдаа эрх зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалтыг тусгадаг бол зарим улс нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тусдаа хууль батлан мөрддөг байна. Тухайлбал, Канад, Швейцар, Сингапур, Солонгос, Хятад, БНХАУ-ын ЗЗОБ Хонгконг зэрэг орнууд эрх зүйн харилцан туслалцааны асуудлыг зохицуулсан бие даасан хуультай.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас 2007 онд Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх тухай загвар хуулийг³⁰ гаргасан.

28 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №1

29 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07

30 http://www.unodc.org/pdf/model_treaty_extradition_revised_manual.pdf.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааны хүсэлтийн эрх зүйн үндэслэлийг бичихэд хүсэлтийг хүлээн авах улс нь эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар бие даасан хуультай бөгөөд тухайн хуульд заасан үндэслэлийг хүсэлтэд тусгах шаардлагатай гэж заасан тохиолдолд холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтыг үндэслэж бичнэ. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн бүлэг, зүйл, хэсэг, заалтыг үндэслэл болгоно.³¹

Хүсэлт тавих захидал

Хэрэв гэрээ, хэлэлцээр болон өөр ямар нэгэн эрх зүйн эх сурвалж байхгүй тохиолдолд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлж болох бас нэг арга бол хүсэлтийг дипломат шугамаар гэрээ хэлэлцээрийн бус аргаар тавих явдал юм. Үүнийг “Хүсэлт тавих захидал” буюу Letter Rogatory гэж нэрлэдэг.³² Дипломат шугамаар гэрээ хэлэлцээрийн бус аргаар тавьж байгаа хүсэлтийг дамжуулах үүргийг “Консулын харилцааны тухай Венийн конвенцод”³³ зааснаар тухайн оролцогч улсад Монгол Улсыг төлөөлөн сууж байгаа консул хамааран ажиллах үүрэг хүлээнэ.

Консулын харилцааны тухай Венийн конвенц:

5 дугаар зүйл. Консулын чиг үүрэг

(j) олон улсын хүчин төгөлдөр гэрээний дагуу, хэрэв тийм гэрээгүй бол хүлээн авагч улсын хууль, журамд үл харшлах аливаа өөр журмаар шүүхийн болон шүүхийн бус бичиг баримт дамжуулах, томилогч улсын шүүхийн даалгавар буюу шүүхэд зориулан мэдүүлэг авах даалгавар гүйцэтгэх

Энэхүү шугамаар авсан баримт, материал нь дангаараа шүүн таслах ажиллагааны явцад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй байх боловч урьд өмнө хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудыг дэмжих, бататгах болон цаашдын мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, чиглэлийг тодорхойлоход ач холбогдолтой.³⁴

1.2. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлага цөөнгүй гарах болсон. Энэ хэрэгцээ шаардлагын улмаас улс орнууд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэхэд хамтран ажилладаг ба эрх зүйн туслалцааны гэрээ байгуулах замаар тухайн асуудлаар төрийн холбогдох байгууллагуудтай шууд харилцах нь илүү шуурхай, үр дүнд хүргэдэг. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх

31 Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаал

32 “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг буцаан авах ажиллагаа”: гарын авлага, УБ, 2020., 27 дахь тал

33 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1165>

34 “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг буцаан авах ажиллагаа”: гарын авлага, УБ, 2020., 27 дахь тал

гэрээ нь хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагын хооронд шууд бөгөөд тогтвортой харилцааг тогтоож өгдөг ба заавал биелүүлэх заалтууд агуулсан байдаг.

Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын³⁵ “Гэрээг мөрдөх” гэсэн III хэсэгт “Аливаа хүчин төгөлдөр гэрээг түүний оролцогчид заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд гэрээг шударга сайн санаагаар хэрэгжүүлэх ёстой. Оролцогч нь гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтаас иш татах ёсгүй” гэж заасан.

Эрүүгийн хэргийн талаар баримт, нотолгоо, мэдээлэл авахаар хандах гэж байгаа улс нь Монгол Улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хоёр талт гэрээ, хэлэлцээр байгуулсан эсэхийг юуны түрүүнд тодруулах шаардлагатай.

Эрх зүйн туслалцааны хүсэлтэд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хүсэлт болгож байгаа мөрдөн шалгах ажиллагааг тухайлан заасан бүлэг, зүйл, хэсэг, заалтыг бичнэ.³⁶

1.2.1. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулах

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулахын өмнө тухайн оронтой гэрээ байгуулах шаардлага байгаа эсэхийг судлах ажиллагаа явагддаг. Тухайлбал, тус улсын иргэд ихээр зорчдог, амьдардаг сурдаг, улс дамнасан гэмт хэргийн улмаас баримт нотолгоо цуглуулах хэрэгцээ гардаг, хууль бусаар олсон хөрөнгө орлогыг тухайн улс руу шилжүүлэх асуудал гардаг зэрэг асуудлыг судалж хэрэгцээ шаардлагыг тодорхойлно.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ нь Олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу олон улсын гэрээ мөн тул тус хуульд заасан журмын дагуу байгуулна.

Олон улсын гэрээний тухай хуулиас

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь **хоёр** болон олон талт олон улсын гэрээ байгуулах, соёрхон батлах, батлах, хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох, тайлбар хийх, гэрээг биелүүлэх, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээний үйлчлэлийг дуусгавар болгох, нийтлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулах процесс нь Олон улсын гэрээнд заасан журмын дагуу тогтоосон дараалалтай хугацаа шаардсан ажиллагаа байдаг. Мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу хоёр талт олон улсын гэрээний монголын талын төслийг уг гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан шаардлагатай бол холбогдох бусад

35 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1214>

36 Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаал

байгууллагатай хамтран боловсруулж, олон улсын гэрээний нөгөө талтай олон улсын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийж, гэрээний төслийг эцэслэн тохиролцсоны дараа уг гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хариуцан хийх ажиллагаа, Засгийн газар, Улсын Их Хурлаар хянан үзэх, хэлэлцэн батлах ажиллагаа хуулийн дагуу явагддаг.

Тухайлбал, Засгийн газар гарын үсэг зурсан заавал соёрхон батлах хоёр талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, тухайн гэрээний эх бичвэрийн хуулбар, шаардлагатай бол тухайн олон улсын гэрээний хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулга болон холбогдох бусад баримт бичгийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хууль, дэмжээгүй бол хуулийн төслийг Засгийн газарт буцаах тухай тогтоол гаргадаг байна.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.4-т **“эрх зүйн туслалцаа үзүүлэх**, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээ”-г Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар заасан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Төрийн ордон
Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ³⁷

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хооронд 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАН

Монгол Улс анх Бүгд Найрамдах Унгар Улстай 1968 онд “Иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулж байсан ба үүнээс хойш хуучнаар социалист орон гэгдэж байсан 10 гаруй орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг байгуулсан. Энэ үед эрх зүйн туслалцааны асуудлыг багцаар нь буюу иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, эрүүгийн хэргийн асуудлуудыг нэгтгэн нэг гэрээнд багтааж зохицуулалтыг хийдэг байсан.

1990 оноос хойш эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний агуулгыг дахин хянах, байгуулсан гэрээний зарим зүйл заалтыг өөрчлөн тодруулах шаардлага гарсан тул тухайн үед зарим гэрээг шинэчлэн найруулсан байна. Тухайлбал, 1988 онд ЗСБНХУ-тай байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээг шинэчлэн найруулж “Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ”-г 1999 онд байгуулсан.

37 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14038>

Хоёр талт гэрээнүүд нь талуудын эрх зүйн уламжлал болон бололцоонд уялдсан байдаг бөгөөд “нэг стандартыг” бүхий л зүйлд тааруулах олон талт гэрээнээс ялгаатай. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний зохицуулах зүйл нь эрх зүйн харилцан туслалцаа байхаас гадна үүнийг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн харилцаа байна. Эдгээр харилцаа нь хоёр талын хамтран ажиллах байгууллагын эрх мэдэл, эрх хэмжээ болон харилцан хүлээх үүргийг тогтоосон гэрээгээр зохицуулагдана.³⁸

Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд гэрээ байгуулсан хоёр талыг “Хүсэлт хүлээн авагч тал”, “Хүсэлт гаргагч тал” гэж нэрлэх ба гэрээнд дараахь үндсэн асуудлуудыг тусгасан байдаг. Үүнд:

- Тухайн гэрээний үйлчлэх хүрээг тогтоох ба эрүүгийн хэргийн талаар ямар төрлийн туслалцааг хэрхэн харилцан үзүүлэх;
- Харилцах эрх бүхий байгууллагыг тогтоох;
- Эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлтийг гүйцэтгэх, хүсэлтийн агуулгад тусгах асуудлыг тодорхойлох;
- Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэл, баталгаа гаргах, нууц хадгалалт, эрх зүйн туслалцааг биелүүлэхтэй холбогдон гарах зардал зэрэг.

1.2.2. Эрх бүхий төв байгууллага

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх олон улсын хамтын ажиллагаа нь төрийн байгууллагууд хоорондын харилцааг зохицуулж журамладаг. Олон улсын гэрээ, конвенцыг практикт амжилттай хэрэглэхэд улс орнууд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх боломжийг бүрдүүлсэн тогтолцоотой байх шаардлагатай байдаг.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд “Харилцах журам” буюу хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий төв байгууллагыг тогтоож өгдөг. Учир нь гэрээгээр тогтоосон эрх бүхий байгууллагаар дамжуулан гэрээнд заасан асуудлын хэрэгжилтийг хангахыг хэлэлцэн тохирогч улсууд бие биеэсээ шаарддаг.

Зөвхөн гэрээнд заасан эрх бүхий байгууллагаар эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг дамжуулахын зэрэгцээ мөн эдгээр байгууллага нь өөрийн улсын нутаг дэвсгэрт эрх зүйн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй байдгийг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын хувьд хоёр талт олон улсын гэрээ хэлэлцээрт харилцах төв байгууллагын чиг үүргийг Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг өөр өөр байгууллагууд хариуцахаар заасан байдаг.

НҮБ-аас гаргасан Эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх тухай загвар хуульд төв байгууллагын чиг үүргийг тодорхойлсон. Тухайлбал:

38 “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь” УБ, 2009., 13 дахь тал

5. Төв байгууллага: Хүсэлт гаргах, хүлээн авах

(1) Энэ хуулийн зорилгын хүрээнд дараах чиг үүрэг бүхий төв байгууллагыг байгуулна. Үүнд:

- (а) туслалцаа авах хүсэлт гаргах, тийм хүсэлт хүлээн авах, хүсэлтийг биелүүлэх ба эсхүл биелүүлэх ажлыг зохион байгуулах;
- (б) шаардлагатай тохиолдолд туслалцаа хүссэний хариуд ирүүлсэн аливаа баримт бичиг болон бусад материалыг гэрчлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;
- (в) туслалцаа хүссэн хүсэлтийг цэгцтэй, шуурхай шийдвэрлэхэд туслах бодит арга хэмжээ авах;
- (г) туслалцаа хүсэхтэй холбоотой нөхцөлүүдийн талаар хэлэлцээ хийх, тохиролцох, түүнчлэн эдгээр нөхцөлтэй нийцүүлэх явдлыг хангах;
- (д) туслалцаа хүссэн Улсын эрх бүхий байгууллагын туслалцаа авах хүсэлт болон бусад байгууллагад зөвшөөрөл олгох хүсэлтийн хариуд цуглуулсан нотлох баримтын шинжтэй материалыг дамжуулахад шаардлагатай гэж үзсэн ажлыг зохион байгуулах;
- (е) энэ хуульд заасан болон үр дүнтэй туслалцаа үзүүлэх, хүлээн авахад шаардлагатай бусад үүрэг даалгаврыг гүйцэтгэх.

Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх зарим гэрээнд эрх бүхий байгууллагын харилцааны талаар харилцан өөрөөр тусгасан байдаг. Жишээлбэл,

Казахстан Улстай байгуулсан гэрээнд:³⁹

4 дүгээр зүйл. Эрх зүйн туслалцаа үзүүлэхэд харилцах журам

1. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллага нь эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ өөрийн зохих төв байгууллагаар дамжуулан харилцана. Шаардлагатай тохиолдолд аймаг, мужийн хэмжээнд шууд харилцах бөгөөд түүнийгээ өөрсдийн төв байгууллагад мэдэгдэнэ.

Польш Улстай байгуулсан гэрээнд:⁴⁰

4 дүгээр зүйл. Харилцах журам

2. Энэ зүйлийн 1-д дурдсан Хэлэлцэн тохирогч хоёр Талын төв байгууллага, хууль сахиулах байгууллагууд хоорондоо шууд харилцах талаар нэмэлт хэлэлцээр байгуулж болно.

Мөн зарим гэрээнд эрх бүхий байгууллагууд гэрээг хэрэгжүүлэхдээ хоорондоо шууд харилцахаар, зарим гэрээнд дипломат шугамаар харилцахаар, зарим гэрээнд эрх бүхий төв байгууллагууд дипломат шугамаар, эсхүл шууд харилцахаар заасан ба зарим гэрээнд эрх бүхий төв байгууллагаар дамжуулан харилцана гэж л заасан байдаг.

39 “Монгол Улсаас бусад улстай байгуулсан Иргэн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний эмхэтгэл” УБ, 2016., 271 дэх тал

40 Мөн тэнд, 305 дахь тал

Бүгд Найрамдах Казахстан Улстай байгуулсан 1993 оны гэрээнд 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулж эрх бүхий төв байгууллагыг өөрчилсөн.

Ер нь гэрээнд эрх бүхий төв байгууллагыг өөрчилж болох талаар тухайлан тусгаагүй байдаг ба харин сүүлийн үед байгуулсан зарим гэрээнд энэ талаар заах болсон.

БНХАУ-ын ЗСОБ Макаотой байгуулсан хэлэлцээрт:

2 дугаар зүйл. Эрх бүхий төв байгууллага

3. Аль ч тал өөрсдийн эрх бүхий төв байгууллагаа өөрчилж болох бөгөөд энэхүү өөрчлөлтийн талаар нөгөө талдаа даруй бичгээр мэдэгдэнэ.

Прокурорын тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгаар “прокурорын төв байгууллага нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллага байна” гэж тусгасан байна. Улсын ерөнхий прокурорын газар нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагатай хамтран ажиллах ба эдгээр байгууллага нь хуульд заасан эрхлэх асуудлын дагуу эрүүгийн хэргийн талаар эрх зүйн хамтын ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Зургадугаар бүлэгт заасан Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан нь гадаад улсад илгээх туслалцаа үзүүлэх хүсэлтийг эрх бүхий төв байгууллагад хүргүүлэх, эрх бүхий төв байгууллагын өгсөн үүргийн дагуу гадаад улсаас ирүүлсэн хүсэлтийг биелүүлэх зэрэг үүргийг хүлээнэ.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцогч зарим байгууллагын чиг үүргийг хуульд тусгасныг авч үзэхэд:

Хуулийн нэр, № батлагдсан хугацаа	Холбогдох заалт
1 Прокурорын тухай хууль 2017.6.09	26 дугаар зүйл. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх 26.1. Прокурорын төв байгууллага нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэргийн талаар дараах ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллага байна: 26.1.1. эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа; 26.1.2. тогтоол биелүүлэх зорилгоор хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх; 26.1.3. хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх, Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах.

№	Хуулийн нэр, батлагдсан хугацаа	Холбогдох заалт
2	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль ⁴¹ 1993.5.06	20 дугаар зүйл. Засгийн газрын бүрэлдэхүүн 5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ: 7/Гадаад харилцааны сайд: гадаад улс, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт; 9/Хууль зүй, дотоод хэргийн сайд: эрх зүйн туслалцаа
3	Дипломат албаны тухай хууль ⁴² 2000.10.5	5 дугаар зүйл. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 5.1.11. Монгол Улсын олон улсын гэрээг байгуулах, эх бичвэрийг хадгалах дагаж мөрдөхтэй холбогдсон үйл ажиллагааг нэгдсэн аргачлал, мэргэжлийн зөвлөмжөөр хангах, тэдгээрийн дагуу Монголын талын хүлээсэн үүргийн биелэлтийн байдлыг бүхэлд нь нэгтгэн дүгнэх, хэрэгжилтийн явцын талаар Засгийн газарт илтгэж байх. 7 дугаар зүйл. Дипломат төлөөлөгчийн газрын чиг үүрэг 7.1.3.хоёр ба олон талын харилцааны асуудлаар хэлэлцээ хийх, гэрээ хэлцэл байгуулах, тохиролцсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх.
4	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017.5.18	6.2 дугаар зүйл. Мөрдөгч 1.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулна.
5	Авлигын эсрэг хууль ⁴³ 2006.7.6	18 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх 18.4.Авлигатай тэмцэх газар дараах бүрэн эрхтэй: 18.4.7.хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах; 18.4.17.авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль ⁴⁴ 2017.6.09	116 дугаар зүйл. Гадаад улсын болон олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх 116.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын, олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх журмыг энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлно.

41 Төрийн мэдээлэл эмхэтгэл:1993 он,№3

42 Төрийн мэдээлэл эмхэтгэл:2000 он,№39

43 Төрийн мэдээлэл эмхэтгэл:2006 он,№35

44 Төрийн мэдээлэл эмхэтгэл:2017 он,№24

Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ын 1.3 дугаар зүйлийн 2-т “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагад гүйцэтгүүлэхээр даалгах, биелэлтэд хяналт тавих, гадаад улсад уламжлах ажиллагааг Улсын ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь бусад чиг үүрэг бүхий хэлтэстэй хамтран зохион байгуулна” хэмээн заасан

1.2.3. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээ

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудлаар Монгол Улсаас бусад улстай байгуулсан гэрээний жагсаалт⁴⁵

д/д	Гэрээний нэр	Байгуулсан огноо	Гэрээнд заасан эрх бүхий төв байгууллага Монгол Улс	Гэрээнд заасан эрх бүхий төв байгууллага тухайн Улс
1	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Унгар Ард Улсын хооронд иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	1968.11.22	Шүүх, Прокурор Улсын нотариатын байгууллага	Шүүх, Прокурор, Улсын нотариатын байгууллага
2	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Болгар Ард Улсын хооронд иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	1968.11.27	Хуулийн төв байгууллага	Хуулийн төв байгууллага
3	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Румын Улсын хооронд иргэний болон гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх тухай гэрээ	1972.11.25	Хуулийн төв байгууллага	Хуулийн төв байгууллага

45 “Монгол Улсаас бусад улстай байгуулсан Иргэн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний эмхэтгэл”УБ, 2016

4	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Чехословак Улсын хооронд иргэн, гэр бүл ба эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх болон эрхийн харилцаа тогтоох тухай гэрээ /Энэ гэрээ Чех Улс, Словак Улсын аль алинд нь мөрдөгдөж байгаа/	1976.10.15	Шүүх, Прокурор Улсын нотариатын байгууллага	Шүүх, Прокурор, Улсын нотариатын байгууллага
5	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Югослав Улсын хооронд иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	1981.6.08	Хуулийн байгууллага	Хуулийн байгууллага
6	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын хооронд иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	1988.10.29	Шүүх, Прокурор, Улсын нотариатын болон бусад эрх бүхий төв байгууллага	Шүүх, Прокурор, Улсын нотариатын болон бусад эрх бүхий төв байгууллага
7	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	1989.8.31	Хууль зүй, арбитражын яам, тухайн үеийн нэрээр/ УДШ	Шүүх яам, Ардын дээд шүүх
8	Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хоорондын гэрээ	1993.10.22	Хууль зүй, дотоод хэргийн яам, УЕПГ, УДШ	Хууль зүйн яам, УЕПГ, УДШ
9	Монгол Улс, Украин Улсын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ	1995.6.27	Хууль зүйн яам, УДШ, УЕПГ	Хууль зүйн яам, УДШ, УЕПГ
10	Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын хооронд иргэн, гэр бүл, хөдөлмөр, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай гэрээ	1998.10.19	Хууль зүйн яам	Хууль зүйн яам
11	Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ	1999.4.20	Хууль зүйн яам, УЕПГ, ЦЕГ	Хууль зүйн яам, Дотоод явдлын яам, УЕПГ

12	Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хооронд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	1999.5.31	Хууль зүйн яам	Хууль зүйн яамны сайд эсхүл сайдын томилсон албаны хүн
13	Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын хооронд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	1999.12.04	Хууль зүйн яам, УЕПГ	Хууль зүйн яам, Ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий газар
14	Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын хооронд иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	2000.4.17	Хууль зүйн яам, УЕПГ	Хууль зүйн яам, Ардын дээд прокурорын газар
15	Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд иргэн, аж ахуйн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	2000.5.02	Хууль зүйн яам	Хууль зүйн яам
16	Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хооронд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	2001.01.03	УЕПГ	Дотоод явдлын яам
17	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр ⁴⁶	2018.3.26	ХЗДХЯ болон МУ-ын Хууль зүй, дотоод хэргийн сайдаас бүрэн эрх олгосон ажилтан	Хууль зүйн нарийн бичгийн дарга эсхүл түүнээс бүрэн эрх олгосон ажилтан

46 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019, №02

18	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ ⁴⁷	2018.6.04	ХЗДХЯ, УЕПГ, УДШ	Мөрдөн шалгах хороо, Улсын ерөнхий прокурорын алба, Улсын аюулгүй байдлын хороо, УДШ
19	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр ⁴⁸	2019.6.26	Хууль зүй, дотоод хэргийн яам	Ерөнхий прокурорын газар

Холбогдох хуульд заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулах хэрэгцээ шаардлагыг судлах, гэрээ байгуулахыг хариуцан зохион байгуулах ажлыг хариуцдаг. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олон улсын гэрээний эх бичвэрийг хадгалах үүрэгтэй. Иймд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний эх хувьтай танилцах, лавлагаа авах нөхцөлд тус яаманд хандах боломжтой байна.

Гадаад улсад эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах, гадаад улсаас ирсэн хүсэлтийг биелүүлэх ажиллагаа явуулах нөхцөлд тухайн улстай байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээтэй сайтар танилцаж судлах нь зүйтэй. Гэрээ ерөнхий заалтуудтай, хоорондоо адил байдаг гэж үзэх үүднээс гэрээнд хайхрамжгүй хандах явдал гардаг. Гэрээ болгон Талуудын хууль тогтоомж, харилцан тохиролцсонтой уялдан ялгаатай болон онцлог зохицуулалттай байдаг. Тиймээс гэрээний заалт болгоныг анхаарах шаардлагатай.

Тухайлбал Энэтхэг Улстай байгуулсан гэрээнд⁴⁹ харилцан туслалцаа үзүүлэх гэдэгт “...хүсэлт хүлээн авсан талаас эрүүгийн хэргийн талаар үзүүлэх бүх туслалцааг ойлгоно. Эрүүгийн хэрэг гэдэгт алан хядах ажиллагааг дэмжсэн гэмт хэрэг болон татвар, хураамж, гааль эд хөрөнгө, төлбөр тооцооны олон улсын шилжүүлэгтэй холбогдсон эрүүгийн гэмт хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааг багтаана” хэмээн дэлгэрэнгүй тусгасан байдаг.

47 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019, №08

48 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019, №08

49 Монгол Улсаас бусад улстай байгуулсан Иргэн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний эмхэтгэл УБ, 2016., 501 дэх тал

Зарим гэрээний заалтаас дурдахад:

БНХАУ-ын 330Б Хонконгтой байгуулсан хэлэлцээрт: 11 дүгээр зүйл.Цахим хурал Талууд өөрсдийн бололцоо, эсхүл хуультай нийцүүлэн тухайн хэрэг тус бүрээс шалтгаалан мэдүүлгийг цахим хурлын тусламжтайгаар авахаар тохиролцож болно. Энэ тохиолдолд хоёр тал цахим хурал хийх тусгай дэг журмыг тохиролцоно.
Вьетнам Улстай байгуулсан гэрээнд: ⁵⁰ 73 дугаар зүйл.Гэмт хэрэгтэй холбогдсон эд зүйлийг шилжүүлэх 1.Талууд бие биедээ гаргасан хүсэлтийн дагуу гэмт хэргийн зэвсэг, хэргийн ул мөр бүхий эсхүл гэмт хэргийн замаар олсон бүхий л эд зүйлийг гэмт этгээдтэй аль болох хамт шилжүүлнэ. 2.Гэмт этгээд нас барсан эсхүл өөр нөхцөл байдлын улмаас түүнийг шилжүүлэн өгөх боломжгүй тохиолдолд ч гэсэн энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд зүйлийг шилжүүлнэ.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд ихэвчлэн гэмт хэргийн замаар олсон эд зүйл, эд материал,мөнгө шилжүүлэх тухай заасан байдаг ба сүүлийн үед байгуулсан гэрээ, хэлэлцээрт гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хураан авах, буцааж олгох талаар тухайлан заалт оруулах болсон.

Тухайлбал:

БНХАУ-ын 330Б Макаотой байгуулсан хэлэлцээрт: 17 дугаар зүйл.Гэмт хэргийн улмаас олсон орлого 3.Гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураан авах тухай хүсэлтийг хүсэлт хүлээн авагч талын хуулийн хүрээнд зүй зохистой явуулна.Энэ нь хүсэлт хүлээн авагч талын шүүхээр баталгаажсан хүсэлт гаргагч талын шүүхээс гаргасан эцсийн шийдвэрийг агуулсан байна. 4.Хүсэлт хүлээн авагч тал хяналтдаа байлгаж буй хураагдсан орлогыг өөрийн хуулийн хүрээнд шийдвэрлэнэ. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хууль тогтоомжийн дагуу болон зүй зохистой хэмээн үзсэн нөхцөлийн үндсэн дээр хураагдсан орлогыг хүсэлт гаргагч талд шилжүүлэн өгч болно.
--

1.2.4.Гэрээний хугацаа

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд гэрээний хугацааг харилцан адилгүй заасан байдаг. Заримаас дурдахад:

Болгар Улстай байгуулсан гэрээнд ⁵¹	84 дүгээр зүйл Энэхүү гэрээг таван жилийн хугацаагаар байгуулав.Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Этгээд түүний хугацаа дуусахаас зургаан сарын өмнө энэхүү гэрээнээс татгалзахгүй бол түүний хугацаа нь дараачийн таван жил бүрд сунгагдаж байх болно.
--	--

50 Мөн тэнд, 445 дахь тал
51 Монгол Улсаас бусад улстай байгуулсан Иргэн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний эмхэтгэл, УБ, 2016., 49 дэх тал

Унгар Улстай байгуулсан гэрээнд ⁵²	76 дугаар зүйл. 1....Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 10 жилийн турш үйлчилнэ. 2.Хэрэв Хэлэлцэн Тохирогч Этгээдийн аль нэг нь дээр заагдсан хугацааг дуусгахаас нэг жилээс доошгүй хугацааны өмнө энэхүү Гэрээнээс татгалзахгүй бол түүний хүчин төгөлдөр байх хугацаа нь тодорхойгүй хугацаагаар сунгагдах бөгөөд Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн аль нэг нь нэг жилийн өмнө цуцлах хүртэл энэхүү Гэрээ хүчин төгөлдөр байна.
Казахстан Улстай байгуулсан гэрээнд	42 дугаар зүйл. Энэхүү гэрээ хугацаагүй бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал түүнийг цуцлах тухайгаа дипломат шугамаар бичгээр мэдэгдсэнээс хойш 6 сар өнгөрмөгц энэхүү гэрээний үйлчлэх хугацаа дуусгавар болно.

Сүүлийн үед байгуулсан гэрээнд хугацааны талаар заахгүйгээр тухайн гэрээг цуцлах, хүчингүй болгох нөхцөлийн талаар заах болсон. Тухайлбал, Беларусь Улстай байгуулсан гэрээнд “Аль ч тал нөгөө талдаа энэхүү гэрээг цуцлах мэдэгдлийг хэдийд ч дипломат шугамаар бичгээр хүргүүлж болно. Энэ гэрээ тус мэдэгдэл өгсөн өдрөөс хойш 6 сарын дараа хүчингүй болно” гэжээ.

Гэрээний үйлчлэлийн талаар зарим гэрээнд тусгаагүй ба зарим гэрээнд тусгайлан энэ талаар заасан байдаг.

Энэтхэг Улстай байгуулсан гэрээнд	22 дугаар зүйл. Хамрах хүрээ Энэхүү Гэрээ нь хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө буюу хойш гарсан аливаа хүсэлтэд нэгэн адил үйлчилнэ.
Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулсан гэрээнд ⁵³	21 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох, цуцлах Энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр болсноор, аль нэг хүсэлтийн холбогдох үйлдэл, эс үйлдэл нь энэхүү Гэрээг хүчинтэй болоогүй байхад үүсэн гарсан зэргээс үл хамааран бүхий л хүсэлтэд үйлчилнэ.
Беларусь Улстай байгуулсан гэрээнд	22 дугаар зүйл.Гэрээг хүчин төгөлдөр болгох, хэрэгжүүлэх, өөрчлөх болон цуцлах Энэхүү гэрээ түүнийг хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт мөн адил үйлчилнэ.

1.3 Эрх зүйн туслалцааны хүсэлт

1.3.1.Гадаад улсад явуулах эрх зүйн туслалцааны хүсэлт боловсруулах

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа хүсэх хүсэлт боловсруулахад Монгол Улсын олон улсын гэрээ, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хоёр талт гэрээ, дотоодын хууль тогтоомж болон хүсэлт хүлээн авах улсын холбогдох хууль тогтоомжийг судалж, тэдгээрт тавигдсан шаардлагыг хангах болон харгалзан үзэх асуудлуудыг анхаарах шаардлагатай. Ихэвчлэн “даалгавар эсхүл

52 Мөн тэнд, 9 дэх тал

53 Мөн тэнд, 375 дахь тал

хүсэлт” гэж нэрлэгддэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Дөчин хоёрдугаар бүлэгт “хүсэлт” гэж тусгасан болно.

Эрх зүйн туслалцааны хүсэлт боловсруулахаас өмнөх шатанд хийгдэх ажиллагаа

Гадаад улс орнуудад мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах ажиллагаа нь цаг хугацаа их ордог, үүрэг хүлээлгэсэн зохицуулалт байхгүйгээс шалтгаалан үр дүнгүй ажил болох тохиолдол гардаг. Гадаад улсад илгээсэн хүсэлтэд хүлээн авсан улсаас хүсэлтийг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй учир биелүүлэх боломжгүй тухай, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээтэй боловч хүсэлтийн загварыг өөрчлөн, өөрийн орны стандартын дагуу ирүүлэхийг шаардаж буцаах, эсхүл Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэрэг нь тухайн улсад гэмт хэрэгт тооцогдоогүй учир хүсэлтийн заалтыг хангахаас татгалсан хариу ирүүлдэг бол зарим улсад явуулсан хүсэлтэд ямар нэг хариу өгдөггүй тохиолдол гардаг байна.

Хүсэлт гаргах ажиллагаа үр дүнгүй болох нь албан ёсны хүсэлт гаргахаас өмнө албан бус түгээмэл арга замаар мэдээлэл эрж хайлгүйгээр шууд эрх зүйн туслалцаа хүсдэгээс шалтгаалдаг байна.

Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаалаас

2.1 дүгээр зүйл. Гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргах

1. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг хүргүүлэхээс өмнө прокурор, мөрдөгч нь шаардлагатай мэдээллийг нээлттэй эх сурвалж, мэдээлэл солилцох сүлжээ болон гадаад улсын ижил түвшний байгууллага хоорондын хамтын ажиллагааны тухай гэрээ, хэлэлцээр, санамж бичигт үндэслэн цуглуулсан байна.

2. Хүсэлт боловсруулахад тавигдах шаардлагын талаар хүсэлт хүлээн авах улсын эрх бүхий байгууллага, албан тушаалтантай урьдчилан мэдээлэл солилцож болно.

3. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүлээн авах улс нь эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар бие даасан хууль тогтоомжтой тохиолдолд хүсэлтэд тавигдах тусгай шаардлагыг судалж, туунд нийцүүлэн боловсруулсан байна.

Боломжтой тохиолдолд эхлээд албан бус сувгаас мэдээлэл хайх, холбогдох албан тушаалтантай нь харилцаж, хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай зүйлс, тулгарч болох бэрхшээлийн талаар ярилцах нь зүйтэй.

Улс орон бүрийн шаардлага нь харилцан адилгүй байдаг тул тухайн улсын эрх бүхий төв байгууллагатай урьдчилан харилцаж, ажиллагааг гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг тодруулах нь зүйтэй. Гадаад улсын хамтран ажилладаг болон бусад албан тушаалтантай зөвлөлдөх нь чухал боловч зарим улс эрх зүйн туслалцааны хүсэлт бэлтгэх илгээхэд эрх бүхий төв байгууллагаараа дамжуулан харилцахыг шаарддаг. Түүнчлэн гадаад орны эрх бүхий төв байгууллагын албан ёсны цахим хуудсанд эрх

зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах шаардлага болон тухайн шаардлагыг хангасан эрх зүйн туслалцааны хүсэлтийн загваруудыг байрлуулсан байдаг.⁵⁴

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд мэдээлэл солилцох талаар тусгайлан заасан байдаг. Тухайлбал:

БНАСАУ-тай байгуулсан гэрээнд:⁵⁵

11 дүгээр зүйл. Эрх зүйн асуудлаарх мэдээлэл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал нөгөө Талынхаа хүсэлтээр өөрийн улсын хууль тогтоомжийн үндсэн зарчим болон шинээр гарч буй хууль тогтоомж, түүнийг хэрэглэх асуудлаар харилцан мэдээлэл хийж, холбогдох материал солилцож байна.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг сонгоход бүхий л холбогдох гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжийн жагсаалт гаргаж ашиглах шаардлагатай. Энэ нь хүсэлтийг хүлээн авах магадлалыг нэмэгдүүлж өгдөг. Учир нь эрх зүйн туслалцааны төрөл болон хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах шалтгаан нь улс орнууд хооронд адилгүй байдаг. Хүсэлтийг нэг улсад эрх зүйн үндэслэлтэй гэж үзэх боловч өөр улсад татгалзах боломжтой.

Тодорхой мэдээллийг албан бусаар олж авах арга замуудыг бүрэн ашиглахад анхаарах шаардлагатай. Тухайлбал: Гадаад улсад байгаа сэжигтэн, гэрч, хохирогчийн хаягийн талаар болон бусад мэдээллийг Интерполоор, хөрөнгө мөнгө байршсан эсэх, тухайн бизнесийн байгууллага хууль зүйн дагуу бүртгэлтэй эсэх зэрэг мэдээллийг НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх алба болон StAR хөтөлбөр, мөн хөрөнгө хураан авах, царцаах чиглэлээр ажилладаг Европ дахь мэргэжилтнүүдийн албан бус сүлжээ-/CARIN-Camden Asset Recovery Inter-Agency Network¹²²/, Ази дахь ARIN зэрэг байгууллагаас хүлээн авсны дараа тухайн этгээдийг байцаах, төрөл бүрийн лавлагаа авах зэрэг ажиллагааг хийлгэхээр хүсэлт илгээх боломжтой байна. Авлигатай тэмцэх газар нь StAR хөтөлбөртэй харилцах байгууллагаар бүртгүүлэн StAR Интерполын хамтарсан “Global Focal point” гэх сүлжээг Монгол дахь Интерполын төвтэй хамтран байгуулж, шууд мэдээлэл солилцох болсон. /Шаардлагатай мэдээллийг олж авах боломжтой нээлттэй эх сурвалж, мэдээлэл солилцох сүлжээний цахим эх сурвалжийн жагсаалтыг “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага”-ын Хавсралт J - үзнэ үү⁵⁶/

54 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага”: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020., 247 дахь тал.

55 Монгол Улсаас бусад улстай байгуулсан Иргэн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэх, ялтан шилжүүлэх тухай гэрээний эмхэтгэл УБ, 2016., 161 дэх тал

56 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага”: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020., 397 дахь тал.

Мөн утсаар холбогдож харилцах, захиргааны хамтын ажиллагааны эсхүл түншүүд хоорондын биечлэн уулзалт хэлбэрээр байж болно. Ихэвчлэн эрх бүхий байгууллага хоорондын мэдээлэл солилцоо албан ёсны эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт явуулахыг шаарддаггүй. Албан бусаар мэдээлэл солилцоход өөр улсад байх түнш байгууллагууд хоорондын харилцан ойлголцлын санамж бичгээр тогтсон захиргааны хамтын ажиллагааг ашигладаг.⁵⁷ Гадаад улсын ижил түвшний байгууллага хоорондын хамтын ажиллагааны тухай гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн талаар хууль сахиулах байгууллагаас тодруулах боломжтой/

Монгол Улсын ерөнхий прокурорын газраас гадаад улсын прокурорын байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг, хэлэлцээрийн жагсаалтыг Улсын ерөнхий прокурорын газрын цахим хуудаст байршуулсан байдаг⁵⁸.

Ийм хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг байгуулснаар хууль сахиулах байгууллагууд мэдээлэл солилцох боломж бүрдэж, авагдсан баримт мэдээллийг нягталсны үндсэн дээр эрх зүйн туслалцааны хүсэлт гаргахад ач холбогдолтой байх болно.



Эрх зүйн туслалцааны хүсэлт боловсруулахад анхаарах асуудал

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын оролцогч улсууд авлигын гэмт хэрэгтэй холбогдуулан мөрдөн байцаах яллах, шүүх ажиллагаа явуулахад эрх зүйн хамгийн өргөн хүрээний туслалцааг бие биедээ үзүүлэх үүрэг хүлээсэн байдаг. Конвенцын 46 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт албан ёсны эрх зүйн туслалцаа хүсэж болох зүйлсийг тодорхойлон заажээ.

Мөн эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд туслалцаа хүсч болох зүйлсийг тусгасан байдаг. Тухайлбал:

⁵⁷ Мөн тэнд, 221 дэх тал.

⁵⁸ <https://prokuror.mn/international-coop>

Бүгд Найрамдах Солонгос улстай байгуулсан гэрээнд:

1 дүгээр зүйл. Гэрээний үйлчлэх хүрээ

3. Туслалцаанд дор дурдсан зүйлийг хамруулна. Үүнд:

- а/ аливаа этгээдээс нотлох баримт болон мэдүүлэг авах;
- б/ мэдээлэл, бичиг баримт, хэргийн материал, эд зүйлийг өгөх;
- в/ аливаа этгээд эсхүл эд зүйлийн байршлыг тогтоох, тэдгээрийг танин тогтоох;
- г/ шүүхийн бичиг баримт гардуулах;
- д/ нэгжих болон эд зүйл хураан авах тухай хүсэлтийг биелүүлэх;
- е/ саатуулагдсан этгээд болон бусад этгээдүүдээр мэдүүлэг өгүүлэх, эсхүл тэдгээрийг мөрдөн байцаах үйл ажиллагаанд туслалцуулах;
- ё/ гэмт хэргийн улмаас олсон эд зүйлийн талаар туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах;
- ж/ Хүлээн авагч талын хууль тогтоомжоор хориглоогүй бусад хэлбэрийн туслалцаа үзүүлэх.

Албан ёсоор тавьсан эрх зүйн туслалцааны хүсэлтэд туслалцаа үзүүлэх эсэх нь тухайн хүсэлтийг хүлээн авсан улсын хоёр болон олон талт гэрээгээр хүлээсэн үүрэг амлалт, тухайн улсын дотоодын хууль тогтоомж, хүсэлт тавьсан болон хүсэлт хүлээн авсан улсуудын хоорондын харилцаа, хамтын солилцооны зарчим, тухайлбал талуудын харилцан бие биедээ ижил тэнцүү туслалцаа үзүүлэх боломж бололцоо зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.⁵⁹

БНХАУ-ын ЗСОБ Хонгконгийн Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хуулиас:⁶⁰

8. Хонг Конгод тусламж үзүүлэх хүсэлт гаргах

(1) Хонконгоос гадуурх газраас Хонконг руу эрүүгийн хэрэгт туслалцаа үзүүлэх хүсэлтийг Хууль зүйн нарийн бичгийн даргад гаргаж болно. (1997 оны L.N. 362-т нэмэлт өөрчлөлт оруулсан)

(2) (1)-д заасан хүсэлтэд дараах зүйлийг хавсаргана.

- (а) хүсэлтэд хамаарах эрүүгийн асуудалтай холбоотой эрх бүхий байгууллагын нэр;
- (б) эрүүгийн хэргийн шинж чанарын тодорхойлолт (ялангуяа эрүүгийн хэрэг хамаарах гадаад гэмт хэргийн дэлгэрэнгүй мэдээлэл), холбогдох баримт, хууль тогтоомжийн хураангуйг тусгасан мэдэгдэл;
- (в) хүсэлтийн зорилго, хүссэн тусламжийн шинж чанарын тодорхойлолт;
- (г) хүсэлтийг биелүүлэхийн тулд Хонг Конгоос гадуурх тухайн газар дагаж мөрдөхийг хүсэж буй журмын дэлгэрэнгүй мэдээлэл, үүнд аливаа мэдээлэл, баримт бичиг, зүйлийг тухайн газарт нийлүүлэх арга, хэлбэрийн дэлгэрэнгүй мэдээлэл, хүсэлтийн дагуу;
- (д) хүсэлтийн нууцлалын талаарх тухайн газрын хүсэлт, эдгээр хүсэлтийн шалтгааныг тодорхойлсон мэдэгдэл;
- (е) тухайн газар хүсэлтийг биелүүлэхийг хүссэн хугацааны дэлгэрэнгүй мэдээлэл;
- (ж) хэрэв хүсэлт нь Хонг Конгоос тухайн газар руу зорчиж байгаа хүнтэй холбоотой бол тухайн хүнд ямар тэтгэмж олгох тухай дэлгэрэнгүй мэдээлэл, хүсэлтийн дагуу тухайн хүн тухайн газарт байх үед нь байршуулах зохицуулалт;

59 “Авлигатай тэмцэх гарын авлага” ЕАБХАБ, 2016., 231 дэх тал /www.osce.org/

60 <https://www.elegislation.gov.hk/hk/cap525!en.pdf>

- (ж) эрүүгийн хэрэгт хамаарах гаднын гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээг тодорхойлсон мэдэгдэл; болон
(i) хүсэлтийг биелүүлэхэд тусалж болох бусад мэдээлэл.

Эрх зүйн туслалцааны хүсэлт гаргахад ашиглах нийтээр зөвшөөрөгдсөн тусгайлсан заогвар байхгүй ч холбогдох гэрээ хэлэлцээрт хүсэлт бэлтгэхэд тавигдах шаардлагуудыг тусгасан ба дотоодын хууль тогтоомжийн дагуу тодорхой журам, шаардлагад нийцүүлсэн байх ёстой байдаг. Хүсэлт нь хүсэлт гаргагч эрх бүхий байгууллагаас нэгтгэн боловсруулсан бие даасан нэг бүхэл материал байх ёстой ба холбогдох гэрээ хэлэлцээр дотоодын хууль тогтоомжид заасан шаардлагатай бүх мэдээллийг агуулсан байна. Бүрэн бус хүсэлт илгээсэн нь нэмэлт мэдээлэл шаардах туслалцаа үзүүлэхийг хойшлуулах, татгалзах үндэслэл болж болно.⁶¹

Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд бүрэн бус хүсэлтэд нэмэлт мэдээлэл шаардаж болох талаар заасан байдаг. Тухайлбал:

Польш Улстай байгуулсан гэрээнд:

87 дугаар зүйл. Хүсэлтэд нэмэлт хийх

Хэрэв даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал мэдээлэл, баримт бичгийг гүйцэд бус байна гэж үзвэл нэмэлт мэдээлэл шаардаж болно. Ийм нэмэлт мэдээлэл авахын тулд даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал хугацаа тогтоож болно. Үндэслэл бүхий хүсэлтээр уг хугацааг сунгаж болно. Нэмэлт мэдээлэл ирээгүй тохиолдолд тухайн нөхцөлд байгаа мэдээлэл, баримт бичигт үндэслэн шийдвэрлэнэ.

Эрх зүйн туслалцааны гэрээ бүрд “Хүсэлтийн агуулга” гэсэн тусгай зүйл байдаг. Тухайлбал Казахстан Улстай байгуулсан гэрээнд заасан Хүсэлтийн агуулгад тусгах зүйлд “..уг үйлдсэн хэргийн бодит нөхцөл байдлын тухай тодорхойлолт, түүний эрүүгийн хэргийн зүйл анги, шаардлагатай тохиолдолд гадаад төрх байдал болон түүний зураг, хурууны хээ” хэмээн нарийвчлан дурдсан байна.

Аливаа улс орнуудад эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах хууль зүйн шаардлагуудтай байдгийг хүсэлт боловсруулахад анхаарах хэрэгтэй.

Тэдгээрээс зарим шаардлага болон харгалзан үзэх асуудлын талаар дурдахад:

Харилцан гэмт хэрэгт тооцох

Олон оронд харилцан гэмт хэрэгт тооцдог байхыг шаарддаг. Тухайн туслалцаа авахаар хүсэлт илгээж буй үйлдэл нь талуудад гэмт хэрэгт тооцогдсон байх шаардлагатай. Зарим улсад тодорхой нөхцөл байдлуудад энэхүү шалгуураас чөлөөлдөг. Зарим нь энэхүү шалгуурыг илүү хатуу хэрэгжүүлдэг. /нэр томъёоны хувьд тохирсон байх эсхүл тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн элемент нь адил байх/ Гэвч улс орнууд сүүлийн үед үйлдэлд тулгуурласан арга барилыг хэрэгжүүлж байгаа. Энэ нь тухайн нэр томъёогоор тодорхойлогдож байгаа үйлдэл нь талуудын дотоодын хууль

61 Мөн тэнд, 231 дэх тал

тогтоомжоор гэмт хэрэгт тооцдог байх тухай ойлголт юм.⁶² Авлигын эсрэг конвенцод гишүүн улс орнуудыг үйлдэлд суурилсан аргыг хэрэгжүүлэхийг дэмжсэн байдаг. Тухайлбал:

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц:

43 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа

2. Тухайн үйлдлийг хоёр улсын аль аль нь гэмт хэрэг гэж хуульчилсан байх зарчмыг олон улсын хамтын ажиллагааны явцад шаардаж буй тохиолдолд, хэрэв туслалцаа үзүүлэх хүсэлтэд дурдагдсан гэмт хэргийн шинжтэй үйлдэл нь Оролцогч улсын аль алиных нь хуулиар эрүүгийн хэрэгт тооцогддог бол (уг гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын хуулиар хүсэлт гаргагч Оролцогч улсын хуульд заасан гэмт хэргийн адил ангилалд багтаадаг эсэх эсхүл адил нэр томъёогоор нэрлэдэг эсэхээс үл хамааран) уг зарчмыг хангаж байна гэж үзнэ.

Ямар ч тохиолдолд албан бус туслалцаа авах явцад урьдчилан зөвшилцөж харилцан гэмт хэрэгт тооцох шалгууртай холбоотой асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

Зарим улс орнуудад гэмт хэргийг нарийвчлан хуульчлаагүй байдаг бөгөөд үйлдэлд тулгуурласан арга барил нь авлигын гэмт хэргүүдэд илүү хэрэгтэй байдаг. Тухайлбал, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, гадаад улсын нийтийн албан тушаалтанд хахууль өгөх, татвараас зайлсхийх гэх мэт. Гэмт хэргийн талаарх жагсаалт гаргаснаас тухайн үйлдлийн талаар тайлбарлах нь чухал бөгөөд хүсэлт хүлээн авагч улсад хүсэлт илгээж буй Талын дотоодын хууль тогтоомжийг ойлгох мэргэжилтэн байхгүй байх боломжтой бөгөөд өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн нэршлээр нь гэмт хэрэгт тооцох эсэхийг дүгнэх магадлалтай.

Тухайн гэмт хэргийг гэмт үйлдэлтэй уялдуулан холбож, эрх зүйн туслалцааны хүсэлтийг тайлбарлах нь чухал. Түүнчлэн хүсэлт боловсруулахдаа нэр томъёоны хувьд төөрөгдөлд оруулах тодорхой үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Тухайлбал түгээмэл нэр томъёо болох “хууль бус гүйлгээ” нь зарим оронд татвараас зайлсхийх, хөрөнгийг гадагшаа гаргах зэрэг нэр томъёоллоор хэрэглэдэг тул асуудалтай. Энэ тохиолдолд түгээмэл хэрэглэгддэг “хууль бус гүйлгээ” нэр томъёог хэрэглэх нь зүйтэй.⁶³

Нотолгооны шаардлага

Хангалттай хэмжээнд нотлох баримтаар үнэлэгдэхүйц баримт мэдээллээр хангах босгыг даваагүй эсхүл нотлох баримтыг цуглуулах бусдад хамгийн бага хохирол

62 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага”: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020., 253 дахь тал.

63 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага”: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020., 255 дахь тал.

учруулах гэх мэт наад захын шаардлагыг хангаагүй нь тухайн хүсэлтийг буцаах, гүйцэтгэхээс татгалзах үндэслэл болно.⁶⁴

Хэдийгээр албан арга хэмжээ шаардлагагүй үед хууль сахиулах байгууллагууд хооронд албан бус, илүү түргэн, уян хатан сувгийг ашиглаж болох боловч албан бус сувгаар нотлох баримт олж авахад нотлох баримт болж чадах эсэх талаар асуудал үүсэх магадлалтайг анхаарах шаардлагатай. Тиймээс хууль сахиулах байгууллага нотлох баримт олж авахаар хичээхдээ урьдаас тогтсон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх сувгийг ашиглаж байвал зохистой. Албан арга хэрэгслийг ашиглах нь мөн эрсдэл өндөртэй мэдээллийг хамгаалах илүү өндөр түвшний арга хэмжээг хангаж өгнө⁶⁵

Иймд нотлох баримтын шаардлага стандарт болон нотлох баримтаар үнэлэгдэхүйц баримт мэдээллийн жишээ зэрэг асуудлын талаар эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнө зөвшилцөх хэрэгтэй. Хүсэлт хүлээн авагч улсаас хүсэж буй нотлох баримт болон бусад баримтуудыг чухам ямар хэлбэр дээр гаргавал нотлох баримтаар үнэлэгдэхийг тодорхойлох нь зүйтэй.

Сингапур улсын Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулиас⁶⁶

2-р хэсэг-Нотлох баримт олж авахад туслалцаа үзүүлэх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах

21.—(1) Гадаад улсын шүүхээр хүлээгдэж буй аливаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоор нотлох баримтыг Сингапурт авах хүсэлтийг гадаад улсын зохих байгууллагаас гаргасан тохиолдолд Ерөнхий прокурорын зүгээс бичгээр гаргах мэдэгдлээр Магистратын шүүхээс нотлох баримтыг авч, нотлох баримтыг зохих эрх бүхий байгууллагад шилжүүлэх зөвшөөрөл олгох бөгөөд ингэхдээ мэдэгдэлд заасан аливаа нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

(2) Магистратын шүүхээс (1) дэд зүйлд заасан мэдэгдлийг хүлээн авсны дараагаар:

(a) Эрүүгийн хэргийн ажиллагаатай холбоотойгоор мэдүүлэг өгөхийн тулд шүүхийн өмнө ирсэн гэрч бүрээс Сингапурын хууль тогтоомжийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг буруутгагдаж байгаа мэт нотлох баримтыг авна;

(b) нотлох баримтыг бичгээр үйлдэхийг шаардаж, уг нотлох баримтыг агуулсан мэдэгдлийн төгсгөлд Магистратын шүүхээс нотлох баримтыг цуглуулсан болохыг баталгаажуулах; мөн

(c) баталгаажуулсан баримт бичгийг Ерөнхий прокурорт илгээх.....

Улс орнуудын нотлох баримтаар үнэлэх шалгуур нь адилгүй байдаг тул энэхүү шаардлага нь зарим тохиолдолд хүндрэлтэй байдаг. Хүсэлт хүлээн авагч улс нь хүсэлт

64 Мөн тэнд 256 дахь тал

65 UNCAC, Technical guide, 2009.-191 http://www.unodc.org/documents/corruption/Technical_Guide_UNCAC.pdf

66 <https://sso.agc.gov.sg/Act/MACMA2000>

илгээж буй улсаас илүү өндөр стандарт шаардах боломжтой. Аль нэг улсад зохистой хэмжээнд эрх зүйн туслалцааны хүсэлт гэж тооцогдож байхад нөгөөд нь хэтэрхий өргөн цар хүрээтэй хүсэлтэд тооцогддог.

Хүсэлт хүлээн авагч улсын холбогдох байгууллагад дотоодынх нь хууль тогтоомжийн дагуу эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай нотлох баримтаар үнэлэгдэх хангалттай баримт мэдээлэл өгөх шаардлагатай байдаг. Дээр дурдсантай холбоотой тус улсын хуулийн заалтаас дурдахад:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	Холбогдох хэсгийн агуулга
1.2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ, хязгаар	2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална.
16.1 дүгээр зүйл. Нотлох баримт	3. Прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн болон энэ хуулийн Дөчин хоёрдугаар бүлэгт заасан журмаар гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно.
42.6 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хүсэлтийг биелүүлэх	1. Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бөгөөд гадаад улсын эрх бүхий байгууллага уг хэргийг үргэлжлүүлэн шалгуулах хүсэлт ирүүлсэн бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу явуулна. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийн хэргийг гадаад улсын эрх бүхий байгууллага шалгасан материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу шилжүүлж авах ба энэ хуульд заасан шаардлагыг хангасан нөхцөлд нотлох баримтаар тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Хүсэлт боловсруулахад дээр дурдсанчлан хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Талуудын хооронд байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ, дотоодын хууль тогтоомж болон хүсэлт хүлээн авах улсын холбогдох хууль тогтоомжийг судалж, анхаарах шаардлагатай.

Учир нь хэргийг шүүхэд хянан хэлэлцэх явцад эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны үр дүнд цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтыг хэрхэн олж авснаас хамаарч нотлох баримтыг үнэлэх, цаашид гэмт

этгээдийн хууль бус үйлдлийг хөдөлшгүй нотлох, хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд саад бэрхшээл тулгарч болзошгүй байдаг.⁶⁷

Баталгаа болон амлалт, Харилцан адил байх зарчим, нууцлалыг хангах, хэрэглэх хязгаар /тусгайлсан/ төлбөрийг төлөх амлалт

Олон улс оронд харилцан адил байх баталгаа шаарддаг. Хүсэлт илгээж буй улс нь хүлээн авагч улсад төстэй хэрэгт ижил төрлийн туслалцаа үзүүлэх талаар бичгээр мэдэгдэнэ. Мөн хүсэлт илгээж буй улсаас тухайн эрх зүйн туслалцааны хүсэлт нь нууцлалтай эсэхийг тодорхой дурдахыг шаарддаг. Түүнчлэн улс орнууд нь хүсэлт илгээж буй улсад гаргаж өгсөн мэдээллийг зөвхөн эрх зүйн туслалцааны хүсэлтэд дурдсан хэрэгт ашиглах талаар баталгаа шаарддаг бөгөөд өөр хэрэгт ашиглах эсхүл гуравдагч этгээдэд шилжүүлэн өгөхийг хориглодог.

Тухайлбал БНХАУ-ын 2018 онд баталсан Эрүүгийн шүүхийн чиглэлээр олон улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн⁶⁸ 18 дугаар зүйлд “Эрүүгийн чиглэлээрх эрх зүйн туслалцааны хүрээнд хүлээн авсан нотлох баримт материалыг тухайн хэргээс өөр хэрэгт ашиглах хүсэлтийг гадаад улсаас гаргахад гадаад харилцааны асуудал хариуцсан эрх бүхий байгууллага нь тухайн хүсэлтийг эрх бүхий байгууллагад хүргүүлэн, тухайн эрх бүхий байгууллага нь тухайн хүсэлтийг хангах эсэх дээр өөрийн шийдвэрийг гаргана” гэж заасан.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц:

46 дугаар зүйл. Эрх зүйн харилцан туслалцаа

20. Хүсэлт гаргагч оролцогч улс нь хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээнээс бусад тохиолдолд хүсэлт гаргаснаа болон хүсэлтийн агуулгыг нууцлахыг хүсэлт хүлээн авагч оролцогч улсаас шаардаж болно. Хэрэв хүсэлт хүлээн авагч оролцогч улс нууцлах шаардлагыг биелүүлж чадахгүй бол энэ тухайгаа хүсэлт гаргагч оролцогч улсад даруй мэдээлнэ.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хооронд байгуулсан гэрээний 8 дугаар зүйлд нууц хадгалалтын талаар заасан ба үүнд: “Хүсэлт хүлээн авагч тал нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлт, түүний агуулга, холбогдох баримт бичиг болон хүсэлтийн дагуу авсан арга хэмжээний талаарх нууцлалыг хадгалахад дээд зэргийн хүчин чармайлт гаргана. Хэрэв хүсэлтийг биелүүлэхэд хүсэлтийн нууцлалыг зөрчихгүй байх боломжгүй бол энэ талаар хүсэлт гаргагч талд мэдэгдэж, тухайн хүсэлтийг үргэлжлүүлэн биелүүлэх эсэхийг тодруулна” гэжээ.

Мөн зарим улс орнууд нь тухайн хүсэлтийг нь гүйцэтгэх явцад учирч болох аливаа хохирол төлбөрийг барагдуулах талаар амлалт авахыг шаарддаг.

67 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны гарын авлага, УБ, 2015., 7 дахь тал

68 <https://en.pkulaw.cn/display.aspx?cgid=b1575aa60196ebe4bdfb&lib=law>

Эдгээр баталгаанууд нь зарим хэрэгт шаардлагагүй байж болох боловч тухайн улс хооронд энэ талаар зөвшилцөх шаардлагатай. Гэвч эдгээр баталгаанууд нь ихэнх тохиолдолд заавал шаардагддаг бөгөөд баталгааг гаргаагүй тохиолдолд тухайн эрх зүйн туслалцааны хүсэлтийг нь гүйцэтгэхээс татгалзах магадлалтай.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн хэлбэр агуулгад тавигдах шаардлага

Эрх зүйн туслалцааны хүсэлтүүд нь бичгээр байж, хүсэлт хүлээн авагч улс хэрэглэж буй олон улсын гэрээ, талуудын эрх бүхий төв байгууллагаас тавьсан хэл, агуулга, хэлбэрийн талаарх шалгуурыг хангасан байна. Өмнө нь дурдсанчлан эдгээр шалгуурын талаар албан ёсны хүсэлт илгээхээс өмнө олж мэдсэн байж, хүсэлтийг илгээх шаардлагатай юм. Энэ нь хугацаа алдах, хүсэлт гүйцэтгэхээс татгалзахаас сэргийлэх, хүсэлт хүлээн авагч улсад урьдчилж бэлтгэх зэрэг боломж олгодог.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай зарим гэрээнд эрх зүйн туслалцааны хүсэлтийг яаралтай тохиолдолд өөр хэлбэрээр өгч болох боловч дараа нь заавал бичгээр өгч баталгаажуулах шаардлага тавигддаг.

Энэтхэг Улстай байгуулсан гэрээнд:

13 дугаар зүйл. Хүсэлтийн агуулга

4. Хүсэлтийг бичгээр үйлдэнэ. Яаралтай буюу Хүсэлт хүлээн авсан Тал өөр хэлбэрээр тавихыг зөвшөөрсөн бол хүсэлтийг факс эсхүл бусад тохиролцсон цахилгаан холбоогоор хүргүүлж болох боловч дараа нь эх хувийг даруй хүргүүлэн баталгаажуулна.

Беларусь Улстай байгуулсан гэрээнд:

6 дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа хүсэх

1. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг бичгээр гаргана. Хойшлуулж болохгүй тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг бичгээр баталгаажуулах боломжтой аливаа цахилгаан холбооны хэрэгсэл ашиглан түүн дотор Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага /ИНТЕРПОЛ/-оор дамжуулан хүлээн авч болно. Баримт бичгийн эх хувийг нэн даруй хүсэлт хүлээн авагч талд хүргүүлэх ёстой.

БНХАУ-ын 330Б Макаотай байгуулсан хэлэлцээрт:

4 дүгээр зүйл. Хүсэлтийн агуулга

1. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг бичгээр гаргана. Яаралтай тохиолдолд хүсэлт хүлээн авагч талд хүсэлтийг өөр хэлбэрээр гаргаж болох бөгөөд түүнээс хойш арван тав /15/ хоногийн дотор баталгаажуулан бичгээр хүргүүлнэ.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт боловсруулахад тодорхой, нийтлэг буюу Авлигын эсрэг конвенцын болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэр томьёог ашиглах нь ач холбогдолтой.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа авах хүсэлт нь мэдээлэл хүсэхээс илүүтэйгээр эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлж авах зорилготой мөрдөн шалгах тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхэд чиглэгдсэн байвал зохино.

Мөн хүсэж буй туслалцааг бичихдээ хийлгэх ажиллагаа бус олж авах үр дүнг нь илүү тусгаж өгөх нь зүйтэй. Учир нь тухайн үр дүнд хүрэхэд шаардлагатай арга хэмжээ нь улс орон бүрд адилгүй байдаг. Тухайлбал, нэг улсад нэгжлэг хийж хураан авах зөвшөөрөл гарч байж банкны баримтыг олж авах бол өөр улсад баримт бичиг гаргуулах зөвшөөрөл олгодог.

Хүсэлт бичихдээ ямар туслалцаа хүсэж байгаагаас шалтгаалан тавигдах шаардлага өөр өөр байна. Тухайлбал ялтнаас /хүсэлт хүлээн авах улсад хоригдож байгаа/ мэдүүлэг авахаар түр хугацаагаар шилжүүлэх хүсэлт гаргаж байгаа бол дараах мэдээллийг өгнө:

- Ялтныг мөрдөн шалгах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах ач холбогдлыг тайлбарлана.
- Ялтан нь тухайн улс руу аялахыг зөвшөөрсөн эсэх эсхүл энэхүү зөвшөөрлийг хүсэлт хүлээн авагч улсаар авхуулахыг хүсэх.
- Ялтныг түр хугацаагаар шилжүүлсэн тохиолдолд тухайн хугацаанд баривчлах буюу цагдан хориотой байлгах баталгаа өгнө.
- Ялтны туслалцаа тухайн эрх зүйн туслалцаа хүссэн эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд шаардлагагүй болмогц Талуудын тохиролцооны дагуу хүсэлт хүлээн авсан улсад яаралтай эргүүлэн шилжүүлнэ.
- Хүсэлт гаргахдаа тухайн ялтныг түр хугацаагаар шилжүүлэн авахаас өмнө үйлдсэн гэмт хэрэгтэй холбогдуулан түүнийг хорьж цагдахгүй, шүүн шалгахгүй, шийтгэхгүй гэсэн баталгааг хүсэлт хүлээн авсан улсад өгнө.
- Ялтныг хүсэлт хүлээн авсан улсад ялтан шилжүүлэн өгөх шаардлагагүйгээр эргүүлэн өгнө гэсэн баталгаа өгнө.
- Хүсэлт гаргахдаа хүсэлтийг хүлээн авагч улсад баривчлагдсан, цагдан хориотой байх үеийн төсөв, зохион байгуулалт, түр хугацаагаар шилжүүлэн өгөх зардал болон бусад урьдчилан биелүүлэх нөхцөл байдал зэргийг хэлэлцэх хариуцсан ажилтны холбогдох мэдээллийг өгнө.⁶⁹

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд дээр дурдсан этгээдээс мэдүүлэг авах үеийн эрх зүйн хамгаалалт болон мэдүүлэг авах замаар олж авсан мэдээллийн нууцыг хадгалах талаар тодорхой тусгасан байдаг.Тухайлбал:

69 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны гарын авлага УБ, 2015., 62 дахь тал

БНХАУ-ын 330Б Хонконгтой байгуулсан хэлэлцээрт:

12 дугаар зүйл. Нотлох баримт гаргаж өгөх, эсхүл мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор хоригдож байгаа этгээдийг шилжүүлэх

1. Энэхүү хэлэлцээрт заасны дагуу хэрэв хүсэлт хүлээн авагч тал зөвшөөрвөл мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэх, эсхүл шүүн таслах ажиллагаанд гэрч, шинжээчээр оролцуулах зорилгоор хүсэлт гаргагч талд байлцуулах шаардлагатай хүсэлт хүлээн авагч талд хоригдож байгаа этгээдийг өөрийнх нь зөвшөөрөл болон хүсэлт гаргагч талаас уг этгээдийг үргэлжлүүлэн хорьж байгаад хүсэлт хүлээн авагч талд буцаан хүргүүлэх баталгааг гаргаж өгсөн тохиолдолд хүсэлт хүлээн авагч талаас хүсэлт гаргагч талд шилжүүлнэ.

2. Энэ зүйлд заасны дагуу шилжүүлсэн этгээдийн хорих ялын хугацаа түүнийг хүсэлт гаргагч талд байхад дуусгавар болсон тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал түүнийг хорих ялаас чөлөөлөхийг хүсэлт гаргагч талд зөвлөнө.

14 дүгээр зүйл. Аюулгүйн ажиллагаа

1. 12.. дугаар зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтээр хүсэлт гаргагч талд байгаа этгээд нь хүсэлтэд хамаарах байцаан шийтгэх ажиллагаа эсхүл мөрдөн байцаах ажиллагаанаас өөр бусад мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэх, эсхүл байцаан шийтгэх ажиллагаанд нотлох баримт өгөх үүрэг хүлээхгүй.


2. 12.. дугаар зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийг зөвшөөрөөгүй этгээд хүсэлт, эсхүл зарлан дуудахад эсрэг мэдэгдэл хийснийг үл харгалзан энэ шалтгаанаар аливаа шийтгэл, албадлагын арга хэмжээ авах хариуцлага хүлээхгүй.

9 дүгээр зүйл. Ашиглалтын хязгаар

1. Хүсэлт гаргагч тал хүсэлт хүлээн авагч талаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр хүсэлтэд зааснаас бусад зорилгоор энэхүү хэлэлцээрийн дагуу олж авсан мэдээлэл, эсхүл нотлох баримтыг задруулж, эсхүл ашиглахгүй.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох аргачилсан зааварт гадаад улсад мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргах талаар тодорхой тусгасан.

Тухайлбал, Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Аргачилсан заавар”-ын гуравдугаар бүлэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг биелүүлэх тухай заасан. Үүнд хүсэлт боловсруулах, хянах ажиллагаа, баримтлах хугацааны талаар:



Улсын ерөнхий прокурорын дээр дурдсан тушаалын хоёрдугаар хавсралтаар “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийн загвар”-ыг баталсан ба хүсэлт боловсруулахад тавигдах бүх шаардлагыг харгалзан үзэж тусгасан. Хүсэлт боловсруулахад энэхүү загварыг ашиглаж түүнд заасан агуулгыг тодорхой бичнэ:

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХҮСЭХ ТУХАЙ

ХААНА: Хүсэлт хүлээн авах улсын эрх бүхий байгууллагын нэр, хаягийн мэдээлэл.

ХААНААС: Хүсэлт гаргаж байгаа мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын нэгж, газар, хэлтэс, хаягийн мэдээлэл.

ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ: Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хоёр талт гэрээ болон тухайн хэргийг хамаарах Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээрт хүсэлт болгож байгаа мөрдөн шалгах ажиллагааг тухайлан заасан бүлэг, зүйл, хэсэг, заалтыг бичнэ. Хүсэлтийг хүлээн авч гүйцэтгэх улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулаагүй тохиолдолд тухайлсан харилцааг зохицуулсан олон улсын гэрээ конвенц болон харилцан адил байх зарчмыг үндэслэж, эрх зүйн туслалцаа хүсэж болно.

Хүсэлтийг хүлээн авч гүйцэтгэх улс нь эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар бие даасан хуультай бөгөөд тухайн хуульд заасан үндэслэлийг хүсэлтэд тусгах шаардлагатай гэж заасан тохиолдолд холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтыг үндэслэж бичнэ. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн бүлэг, зүйл, хэсэг, заалтыг үндэслэл болгоно.

ХЭРГИЙН ТОВЧ УТГА: Хэнд холбогдуулан ямар гэмт үйлдлийг шалгаж тогтоохоор хаана мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолын огноо, хэргийн дугаарыг бичнэ.

ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ:

Овог нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний харьяалал, оршин суугаа хаяг, мэргэжил, ажил эрхлэлтийн байдал. Хуулийн этгээдийн нэр, хаяг, бүртгэгдсэн газар, огноо, эзэмшигчийн нэр. Хүсэлтийг гүйцэтгэхэд дэмжлэг болох бусад мэдээлэл /паспорт, бүртгэгдсэн гэрчилгээний хуулбар, фото зураг, лавлагаа гэх мэт/

ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛ, ЯЛ ШИЙТГЭЛ, ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ТАЛААРХ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЭЛ: Монгол Улсын Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт заасан гэмт хэргийг шалгаж байгаа талаар болон тухайн гэмт хэргийн ял шийтгэлийн төрөл, хэмжээ хөөн хэлэлцэх хугацааны талаар хуулийн заалтыг албан ёсны эх сурвалжийг дурдан иш татаж оруулна. /Хуулийн заалтыг бүхэлд нь зааж өгөх, эсхүл тусад нь хавсаргах/

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААГААР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ: Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал энэ талаар ямар баримт, мэдээлэл байгаа болох, гадаад улсад явуулах мөрдөн шалгах ажиллагаатай ямар шалтгаанаар хэрхэн холбогдож байгааг цаг хугацааны дарааллаар бичнэ. Хүсэлтийг гүйцэтгэхэд дэмжлэг болох баримтуудыг хавсаргаж болно. /төлбөрийн баримт, гэрчилгээ, схем, график гэх мэт/

ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЗОРИЛГО, ШААРДЛАГА: Хүсэлт болгож байгаа мөрдөн шалгах ажиллагааг тухайн гадаад улсад явуулах болсон шаардлага, ач холбогдол, хүсэлтийг гүйцэтгэснээр хэргийн зүйлчлэл ямар болох, хохирол, хор уршгийг төлүүлэх, шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой болох зэрэг хүрэх үр дүнгийн талаар бичнэ.

ХҮСЭЛТИЙН ТОВЧ АГУУЛГА: Хүсэлт болгож буй мөрдөн шалгах тодорхой ажиллагаа, ямар баримт, лавлагаа, мэдээлэл авахыг хүсэж байгаагаа товч бичнэ.

ХҮСЭЛТ БОЛГОЖ БУЙ МӨРДӨН ШАЛГАХ ТОДОРХОЙ АЖИЛЛАГАА: “Хүсэлтийн товч агуулга” хэсгийг дэлгэрүүлж, тухайн улсын нутаг дэвсгэрт хийгдэх мөрдөн шалгах тодорхой ажиллагааг тоочин бичнэ. Хүсэж буй туслалцааны төрлөөс хамааран хүсэлтэд шаардлагатай мэдээллийг тусгана. Тухайлбал:

(а) Гэрч, хохирогч, шинжээчийн мэдүүлэг авах болон бичиг баримт лавлагаа, мэдээлэл, бичиг баримт гаргуулж авах тухай хүсэлтэд:

- мэдүүлэг өгөх хүний холбогдох мэдээлэл (овог нэр, төрсөн огноо, төрсөн газар, иргэний харьяалал, боловсрол, мэргэжил, оршин суугаа хаяг, ажил эрхлэлтийн байдал г.м)
- асуух асуултууд, тодруулах нөхцөл байдал;
- лавлагаа, хуулбарлан авах бичиг баримтын (банкны болон санхүүгийн) төрөл, жагсаалт, уг бичиг баримт байгаа газрын хаяг, хамаарах цаг хугацаа...гэх мэт.

(б) Үзлэг, нэгжлэг хийх тухай хүсэлтэд:

- үзлэг, нэгжлэг хийх хувь хүн болон хуулийн этгээдийн нэр, хаяг, хураан авах эд зүйл, бичиг баримтын жагсаалт;
- хураан авах эд зүйл, бичиг баримт нь эрүүгийн хэрэгтэй хэрхэн хамааралтай талаар тайлбар;
- үзлэг, нэгжлэг хийх, эд зүйл хураан авах талаар эрх бүхий байгууллагаас олгосон шийдвэр, холбогдох хуулийн зүйл, заалт, түүний тайлбар;
- хуулиар хамгаалагдсан хувь хүний болон байгууллагын нууцад хамаарах мэдээ, бичиг баримт болон иргэний банк дахь хадгаламж, зээлтэй холбоотой эд зүйл, бичиг баримтыг битүүмжлэх бол эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл;

(в) Банкнаас лавлагаа, мэдээлэл авах тухай хүсэлтэд:

- банкны нэр, хаяг, данс эзэмшигчийн нэр, дансны дугаар, авах шаардлагатай баримт бичгийн төрөл (данс нээх хүсэлт, бүрдүүлбэр бичиг баримт, дансны үлдэгдэл, гадаад мөнгөн гуйвуулгын талаар мэдээлэл, дансны харилцагч нарын мэдээлэл, данстай холбоотой бусад шаардлагатай мэдээлэл...гэх мэт);
- дансны гүйлгээний хамрах хугацаа
- шаардлагатай бусад мэдээлэл;

(г) Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болон гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, эд зүйлийг хураах, битүүмжлэх, буцаан авах ажиллагааны тухай эрх зүйн туслалцааны хүсэлтэд тусгах:

- хураан авах, битүүмжлэх, эсхүл буцаан авах хөрөнгийн нэр, төрөл, хэмжээ, үнэлгээ, түүнийг эзэмшигч, холбогдох бүх банкны дансны дугаар, төрөл, хөрөнгө худалдан авсан талаарх дансны гүйлгээ зэрэг шаардлагатай мэдээлэл, эсхүл түүнийг илэрхийлсэн хүснэгт, график, зохион байгуулалтын схем, РРТ танилцуулга;
- хөрөнгө, орлогыг хураан авах, битүүмжлэх, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах тухай эрх бүхий субъектийн шийдвэр;
- хөрөнгө орлогыг хураан авах тухай шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн шийдвэр;
- олон улсын гэрээнд заасан тохиолдолд эрүүгийн хэрэгт хураан авах, битүүмжлэх, улсын орлого болгох ажиллагааг хийлгэх талаар прокурорын нэхэмжлэл;
- шаардлагатай бусад мэдээлэл.

ТУСГАЙ ХҮСЭЛТ: /Шаардлагатай тохиолдолд бичнэ/

- Хүсэлтийг гүйцэтгэх улсын хууль тогтоомжтой харшлахгүй бол гэрч, хохирогч, шинжээчийн мэдүүлэг авах зэрэг хүсэлтийг Монгол Улсын хуульд заасан тусгай журам, дарааллын дагуу гүйцэтгэхийг хүсэх;
- Хүсэлтийг гүйцэтгэх явцад тухайн улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил, гэмт хэрэг илэрсэн нөхцөлд түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл ирүүлэхийг хүсэх;

- Хүсэлтийг гүйцэтгэх явцад хүсэлт гаргагч улсын эрх бүхий байгууллагын төлөөлөл байлцах хүсэлтэй байгаа, түүний шалтгааныг бичих.

НУУЦЫГ ХАДГАЛАХ САНАМЖ: /Шаардлагатай тохиолдолд бичнэ/ Хүсэлт, түүнд агуулагдаж байгаа мэдээллийг нууцлах шаардлагатай бол үндэслэлийг тайлбарлаж, бусдад задруулахгүй байх талаар сануулна.

ХУУЛЬ ЗҮЙН БАТАЛГАА: Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хууль болон хүсэлтийг хүлээн авагч улсын дотоодын хууль тогтоомжид эрх бүхий байгууллагын тусгайлсан баталгаа гаргахыг шаардаагүй бол хүсэлтэд хүний эрх, эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг баталгааг бичнэ.

Тухайлбал: - Энэхүү эрүүгийн хэрэгт хүссэн эрх зүйн туслалцаа нь ямарваа улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид болно.

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа нь хүний нэр төр, алдар хүндийг гутаасан доромжилсон, хүний эрхийг зөрчсөн үйлдэл, эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрцгий хандах бүх үйлдлээс ангид болно.

- Хүсэлтийн дагуу цугларсан нотлох баримтыг зөвхөн энэ хэргийн мөрдөн байцаалтын болон шүүн таслах ажиллагаанд ашиглах ба эрх зүйн туслалцааны дүнд авсан аливаа мэдээлэл, нотлох баримтыг нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд дамжуулахгүй.

- Хүнийг арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн гарал үүслээр ялгаварлан гадуурхах зорилго агуулаагүй болно...гэх мэт.

ИЖИЛ ТӨРЛИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АМЛАЛТ: /Шаардлагатай тохиолдолд бичнэ/

Хүсэлтийг хүлээн авагч улс нь уг хүсэлтийг илгээхэд үндэслэл болгож буй олон талт гэрээний гишүүн улс биш, эсхүл эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулаагүй тохиолдолд харилцан ижил төрлийн эрх зүйн туслалцаа үзүүлэх /reciprocity/ амлалтыг гаргана.

ХҮСЭЛТИЙГ БИЕЛҮҮЛЭХ ХУГАЦАА: /Шаардлагатай тохиолдолд бичнэ/ Хүсэлтийг шуурхай гүйцэтгэх шаардлагатай бол энэ тухай үндэслэлээ тайлбарлаж, боломжит хугацааг заана.

ХАВСРАЛТ /Хавсаргасан баримтуудаа дугаарласан байна/.

Хүсэлтийг илгээж байгаа албан тушаалтан

Хүсэлтийг танилцуулсан албан тушаалтан

Гарын үсэг, байгууллагын тэмдэг,

Огноо.

----- оОо -----

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах, анхаарах асуудлын талаар олон сурах бичиг, гарын авлага гарсныг судлан үзэх нь зүйтэй.⁷⁰

70 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага”: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 391 дэх тал.

Эрх зүйн туслалцааны хүсэлт нь хүсэлт хүлээн авагч улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэлээр үйлдэгдсэн байх шаардлагатай. Орчуулга хийх үүргийг хүсэлт илгээж буй улс хүлээнэ. Зарим онцгой тохиолдолд хүсэлт илгээж буй улс төлбөрийг нь хариуцахыг зөвшөөрвөл хүсэлт хүлээн авч буй улсад орчуулгыг гүйцэтгүүлж болдог. Тодорхой хэргүүдэд зарим улс орнууд нь орчуулгын зардлыг өөрсдөө хариуцах тохиолдол байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас:

42.1 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргах

3. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол хүсэлтийг хүлээн авах улсын хэлээр үйлдэнэ.

Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаалаас:

3.1 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг биелүүлэх

10. Гадаад улсад хүргүүлэх болон ирүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлт, холбогдох материалыг орчуулах ажиллагааг мөрдөн шалгах байгууллагад даалгана.

Хэрэв орчуулгын үйлчилгээ авч байгаа бол хуулийн нэр томъёоны талаар мэдлэгтэй мэргэжлийн орчуулгын үйлчилгээ авах нь чухал. Учир нь орчуулгын алдаа нь үл ойлголцол төрүүлж түүнийг тодруулахад хугацаа алдах эрсдэлтэй. Энэ нь зарим тохиолдолд хүсэлт гүйцэтгэх процессын хамгийн том саад нь болдог.⁷¹

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиас:⁷²

17 дугаар зүйл. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан

17.3. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

17.3.8. гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх олон улсын гэрээнд заасан Монголын талын эрх бүхий төрийн байгууллагаас гадаад улсад хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт болон холбогдох баримт бичгийг гадаад хэл рүү орчуулах төлбөрийг гаргах.

17.4. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

Хүсэлт илгээж буй улсаас хүсэлт хүлээн авч буй улсад хүсэлтийг гүйцэтгэхэд тавих тусгайлсан хууль тогтоомжийн шаардлага байвал /тухайлбал мэдүүлэг авч байгаа албан тушаалтанд тавигдах тусгайлсан шаардлага гэх мэт/ хүсэлтдээ тусгана. Тухайн эрх зүйн туслалцааны хүсэлт нь яаралтай биелэгдэх шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх сүүлийн хугацаа болон шалтгааныг баримтаар баталгаажуулах /тухайлбал шүүх хурлын товын талаарх мэдээлэл/

71 Мөн тэнд, 257 дахь тал

72 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №48

Хүсэлтийг тухайн улстай байгуулсан гэрээнд заасан харилцах эрх бүхий төв байгууллагаар дамжуулан Хүсэлт хүлээн авагч Талд илгээдэг.

Хэрэв Хүсэлт хүлээн авагч байгууллага уг хүсэлтийг гүйцэтгэх эрх бүхий байгууллага биш бол холбогдох байгууллагад нь хүсэлтийг шилжүүлж энэ тухайгаа Хүсэлт гаргасан байгууллагад мэдэгдэнэ.

Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаалаас:

1.3 дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллага

3.Улсын ерөнхий прокурорын газраар дамжуулахгүйгээр гадаад улсын эрх бүхий байгууллага, албан тушаалтанд эрх зүйн туслалцаа үзүүлэх, хавтаст хэргийн материалыг гадаад улсын холбогдох байгууллагад хүргүүлэх, шилжүүлэн авах, эрүүгийн хэргээс нотлох баримт шилжүүлэн өгөхийг хориглоно”

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг биелүүлэхдээ Хүсэлт хүлээн авсан улс өөрийн орны хууль тогтоомжийг баримтлах бөгөөд Хүсэлт гаргагч талын хүсэлтээр (хэрэв дотоодын хууль тогтоомжтой нь зөрчилдөхгүй бол) тухай орны процессын хэм хэмжээг хэрэглэж болдог.

Иймээс хүсэлт гаргахын өмнө тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд Хүсэлт хүлээн авагч Тал нь Хүсэлт гаргагч Талын хууль тогтоомжийг хэрэглэж болох эсэх, хүсэлт /даалгавар/-ийг гүйцэтгэхэд аль улсын хууль тогтоомжийг ашиглах талаар заасан эсэхийг судлах шаардлагатай.

Хүсэлтийг биелүүлэхтэй холбогдон гарах зардлыг хүсэлт Хүлээн авагч Тал хариуцдаг нийтлэг зарчим байдаг бөгөөд гэрээнд заасан зарим нөхцөлийн дагуу Хүсэлт хүлээн авагч Талаас Хүсэлт гаргагч Талд зарим зардлыг төлүүлэхээр нэхэмжилж болно. Тухайлбал, гэрч, шинжээчийн зардал, тусгай ажиллагаа явуулсан зардал гэх мэт.

Хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах үндэслэл:

Холбогдох олон улсын гэрээ конвенцод эрх зүйн туслалцааны хүсэлт гүйцэтгэхээс татгалзахыг хориглосон үндэслэлийг заасан байдаг. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг ганцхан санхүүгийн асуудалтай холбоотой гэж үзэж гүйцэтгэхээс татгалзахыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 46 дугаар зүйлийн 22-т, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенцын 3 дугаар зүйлийн 10-т, Эрх зүйн туслалцааны хүсэлтийг банкны нууцлалын асуудалтай холбогдуулан гүйцэтгэхээс татгалзахыг Авлигын эсрэг конвенцын 46 дугаар зүйлийн 8-д Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенцын 18 дугаар зүйлийн 8-д хориглосон.

Эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах ерөнхий болон нотлох баримтын талаарх шаардлагаас гадна ихэнх тохиолдолд тухайн хэрэг тус бүрийн онцлогоос хамааран тодорхой нөхцөл байдалд хүсэлт хүлээн авагч улс хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах эрх эдлэхийг зөвшөөрсөн байдаг.

Зарим улс орнуудад эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах дараах шалтгаан байдаг:

Үндсэн ашиг сонирхол-Эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүлээн авч буй улсын үндсэн ашиг сонирхолд халдаж байна гэж үзвэл гүйцэтгэхээс татгалздаг. Үндсэн ашиг сонирхлыг аливаа конвенцод дурдаагүй боловч бүрэн эрх нийтийн хэв журам, аюулгүй байдал, дотоодын нөөцөд илт ачаалал өгөх зэрэг ойлголтыг агуулна. Харамсалтай нь үндсэн ашиг сонирхлын талаар өргөн хүрээний тайлбар нь олон улсын хамтын ажиллагааг сулруулдаг. Тухайлбал, хүсэлт хүлээн авч байгаа улс байгалийн баялгийн талаарх мэдээлэл ил болох магадлалтай гэх үндэслэлээр хахуулийн гэмт хэрэгт хамтран ажиллахаас татгалзах боломжтой.⁷³

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц:

46 дугаар зүйл. Эрх зүйн харилцан туслалцаа

21. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс дараах тохиолдолд татгалзаж болно:

а/ хүсэлтийг энэ зүйлийн заалтуудтай нийцүүлж гаргаагүй;

б/хүсэлт хүлээн авагч оролцогч улс хүсэлтийг гүйцэтгэснээр түүний бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, ordre public, бусад чухал ашиг сонирхлыг хөндөх магадлалтай гэж үзэж байгаа;

с/хэрэв хүссэн арга хэмжээг авахыг хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоодын хуулиар аливаа адилтгах гэмт хэрэгтэй холбогдуулан түүний эрх бүхий байгууллагуудад хориглосон бөгөөд уг гэмт хэрэгт өөрийн шүүхийн харьяаллын дагуу мөрдөн байцаах, яллах, шүүх ажиллагаа явуулах;

д/ хүсэлтийг биелүүлэх нь хүлээн авагч оролцогч улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдсон эрх зүйн тогтолцоотой нь зөрчилдөх

“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай” Монгол Улс, БНХАУ-ын ЗЗОБ Макао хоорондын хэлэлцээрийн 5 дугаар зүйлд хүсэлтийг гүйцэтгэх тухай заасан ба үүнд: “Хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг гүйцэтгэхгүй байх тухай шийдвэр, шалтгааныг хүсэлт гаргагч талд нэн даруй мэдэгдэнэ. Хүсэлт хүлээн авагч талаас шаардлагатай гэж үзсэн нөхцөл байдлын дагуу эрх зүйн туслалцаа үзүүлж болох эсэхийг хүсэлт хүлээн авагч талтай тодорхойлон зөвлөлдөнө” гэж заасан.

73 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага”: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 259 дэх тал

ОХУ-ын Эрүүгийн процессын хуулиас:

457 дугаар зүйл. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг биелүүлэх

4.Хэрэв хүсэлтийг гүйцэтгэх боломжгүй бол хүсэлтийг гүйцэтгэхэд саад болсон шалтгааныг зааж, хүлээн авсан баримтыг тухайн хүсэлт явуулсан гадаад орны эрх бүхий байгууллагад буцаана. Хүсэлтийг гүйцэтгэх нь ОХУ-ын хууль тогтоомжтой зөрчилдөж байвал, эсхүл түүнийг биелүүлэх нь улсын тусгаар тогтнол болон аюулгүй байдалд хор уршиг учруулахаар бол хүсэлтийг гүйцэтгэхгүйгээр буцаана.

Нэг гэмт хэрэгт давтан ял оногдуулахгүй зарчим болон хүсэлт хүлээн авч буй улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явж байгаа тохиолдолд

Хэргийн холбогдогч аль хэдийн эрүүгийн хариуцлага хүлээсэн эсхүл тухайн гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан, хүсэлт хүлээн авч буй улсад тухайн үйлдэлд нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа зэрэг тохиолдолд эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзах магадлалтай. Энэхүү зарчим нь эрх зүйн туслалцааны хүсэлтэд илүү хамааралтай, учир нь эрх зүйн туслалцааны хүсэлтээр өгч буй мэдээллээр хүсэлт хүлээн авч буй улсад дотоодод эрүүгийн хэрэг үүсгэхэд боломжтой. Хүсэлт хүлээн авагч тал “Та бүхний мэдээлэлд талархал илэрхийлье. Бидний зүгээс танай мэдээлэлд үндэслэн мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлсэн тул эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжгүй” гэсэн хариу өгөх боломжтой. Энэхүү асуудлыг урьдчилан тооцоолж, эрх зүйн туслалцааны хүсэлт илгээх эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй.⁷⁴

БНХАУ-ын Эрүүгийн шүүхийн чиглэлээр олон улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулиас:

14 дүгээр зүйл Доор заасан үндэслэлийн аль нэгийг баримтлан туслалцаа үзүүлэх тухай гадаад улсаас БНХАУ-д хандан гаргасан хүсэлтийг хангахаас татгалзаж болно

- (1) Тухайн хүсэлтэд дурдсан үйлдэл/эс үйлдэл нь БНХАУ-ын хуулиар гэмт хэрэгт тооцогддоггүй;
- (2) Хүсэлт хүлээн авах үед тухайн хүсэлтэд заагдсан гэмт хэрэг нь БНХАУ-ын нутаг дэвсгэр дээр мөрдөн шалгагдаж, прокурорын хяналт тавигдаж эсхүл шүүн таслах үйл ажиллагааг явагдаж буй, хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарсан, эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааг хаасан эсвэл хөөн хэлэлцэх хугацаа дууссан;
- (3) Хүсэлтэд хамаарах гэмт хэрэг нь улс төрийн хэрэг бол;
- (4) Хүсэлтэд хамаарах гэмт хэрэг нь цэвэр цэргийн гэмт хэрэг бол;
- (5) Хүсэлтийн зорилго нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах, прокурорын хяналт хийх, шүүн таслах болон шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг арьсны өнгө, яс үндэс, шашин шүтлэг, үндэс угсаа, жендер, улс төрийн үзэл бодол, бусад ялгаатай байдал зэрэгт үндэслэн хийх явдал бол эсхүл дээрх шалтгааны улмаас шударга бусаар тухайн этгээдтэй харилцахаар бол;
- (6) Хүсэлтэд заасан асуудал нь тусламж хүссэн хүсэлтэд заасан хэрэгт хамааралгүй;
- (7) Хүсэлтийг хангахаас татгалзаж болох бусад шалтгаан үндэслэл байгаа бол.

74 Мөн тэнд, 260 дахь тал

1.3.2. Гадаад улсаас эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээж авах, биелүүлэх

Олон талт гэрээг соёрхон баталсан улс орнууд нь тухайн гэрээний дагуу илгээсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүлээн авах үүрэгтэй. /Авлигын эсрэг конвенцын 46, 55 дугаар зүйл, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 18 дугаар зүйл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцын 7 дугаар зүйл/

Хүсэлт хүлээн авагч улсад байгаа нотлох баримтыг авах хүсэлт тавьж байгаа улсад туслалцаа үзүүлэх эсэх нь хүсэлт хүлээн авсан улсын шийдвэрлэх асуудал юм. Гэхдээ тухайлбал, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын гишүүн орнууд “хүсэлт хүлээн авагч оролцогч улсын холбогдох хууль тогтоомж, нэгдэн орсон гэрээ, хэлэлцээр, байгуулсан тохиролцооны дагуу бололцоотой бүхий л хэмжээнд⁷⁵ эрх зүйн харилцан туслалцаа харилцан үзүүлэх ёстой.

Гадаад улсын эрх бүхий байгууллагын эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүлээж авсан тохиолдолд уг хүсэлтийг биелүүлэх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна. Эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг үндэслэлгүйгээр хойшлуулж үл болно. Хүсэлт хүлээн авагч Тал нь хүсэлтийг биелүүлсэн тухай бичиг баримтыг Хүсэлт гаргагч Талд илгээх бөгөөд хэрэв эрх зүйн туслалцааг үзүүлж чадаагүй, биелүүлэхэд хүндрэл учирсан бол нөхцөл байдлын талаарх тайлбарыг буцаах бичиг баримтад хавсарган хүргүүлэх үүрэгтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас:

42.4 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг биелүүлэх

1. Шүүх, прокурор, мөрдөгч нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлнэ.
2. Хүсэлтийг биелүүлэхэд тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын мөрдөн шалгах ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.
3. Олон улсын гэрээнд заасан бол мөрдөн шалгах ажиллагаа явуулахад гадаад улсын холбогдох байгууллагын төлөөлөгч байлцаж болно.
4. Хүсэлтийг биелүүлэх боломжгүй дараах тохиолдолд олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Улсын ерөнхий прокурорын газраар дамжуулан хүсэлт явуулсан гадаад улсын байгууллагад биелүүлээгүй шалтгааныг зааж, хүлээн авсан баримт бичгийг буцаана:
 - 4.1. энэ хууль болон тухайн асуудалтай холбогдох олон улсын гэрээнд заасан шаардлагыг хангаагүй;
 - 4.2. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд харшлах;
 - 4.3. Монгол Улсын хуулийг зөрчиж байвал.

75 НҮБАЭК –ийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан бол татгалзсан тухай үндэслэлийг тодорхой бичиж хариуг аль болох шуурхай илгээх ёстой.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг олон улсын гэрээ хэлэлцээр, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль болон бусад хууль, холбогдох зааврын дагуу хүлээн авч хүсэлтэд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулна.Эдгээр үндэслэлээс гадна салбарын зарим хуульд эрх зүйн туслалцааны хүсэлт ирүүлсэн нөхцөлд холбогдох мэдээллээр хангах талаар тусгайлан заасан байдаг.Тухайлбал:

Хуулийн нэр	Холбогдох заалт
Банкны тухай ⁷⁶ 2010.1.28	7 дугаар зүйл. Банкинд хориглох үйл ажиллагаа 7.2.Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно: 7.2.4.Монгол Улсын хуулийг зөрчсөн нь нотлогдсон бол олон улсын хуулийн байгууллага, Монгол Улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан гадаад улсын Засгийн газар хүсэлт гаргасан
Гүйцэтгэх ажлын тухай ⁷⁷ 1997.12.19	11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл 11.2.Цагдаагийн байгууллага эрэн сурвалжлах ажлыг дор дурдсан үндэслэлийн аль нэг нь байвал гүйцэтгэнэ: 11.2.6.эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулсан гадаад улс, олон улсын байгууллагаас хүсэлт ирүүлсэн. 11.3.Тагнуулын байгууллага өөрт нь хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийн тухай мэдээлэл, эрүү үүсгэсэн хэргийг шалгахдаа энэ зүйлийн 2 дахь хэсгийн .. 6-д заасан үндэслэлээр эрэн сурвалжлах ажил явуулах эрхтэй.
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай ⁷⁸ 2021.12.17	13 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал 13.1.Хороо, түүний албан тушаалтан, ажилтан энэ хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхдээ олж авсан мэдээллийн нууцлалыг доор дурдсанаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно: 13.1.6.Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргийг биелүүлэх;

Прокурорын тухай хуулийн 27 дугаар зүйл /Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрх/-д Прокурор хүсэлтийг хүлээн авах, эрх бүхий байгууллагад уламжлах, түүнийг гүйцэтгүүлэхээр холбогдох байгууллагад шилжүүлэх, гүйцэтгэх эсэхийг хянаж, шийдвэрлэх, зөвшөөрөл олгох,

76 Төрийн мэдээлэл эмхэтгэл:2010 он,№7


77 Төрийн мэдээлэл эмхэтгэл:1998 он,№3

78 Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022,№6

хүсэлтийн гүйцэтгэлд хяналт тавих, хүсэлтийг гүйцэтгэх хугацаа тогтоох, хугацааг сунгах эрхтэй байхаар заасан.

Прокурорын тухай хуулийн 28.4 –т гадаад улсаас ирүүлсэн эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг гүйцэтгэх хугацаа, хугацааг сунгах эсэхийг прокурор шийдвэрлэхээр заасны дагуу Улсын ерөнхий прокурорын 2021 оны А/65 дугаар тушаалаар батлагдсан “Аргачилсан заавар”-ын 3 дугаар бүлэгт гадаад улсаас ирүүлсэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг хянах, гүйцэтгэх хугацаа, сунгах хугацаа зэргийг тодорхой тусгасан. Тухайлбал:

ГАДААД УЛСААС ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТИЙГ БИЕЛҮҮЛЭХ ХУГАЦАА



Дээр дурдсан аргачилсан зааварт хүсэлтэд заасан ажиллагааг мөрдөн шалгах байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагагүй бол прокурорын газар гүйцэтгэх болохоор, гадаад улсын эрх бүхий байгууллагаас эрх зүйн туслалцааны хүсэлтийг мөрдөн шалгах байгууллагад шууд хүргүүлсэн бол харьяа прокурорын газрын дээд шатны прокурор нь энэ тухай Гадаад харилцаа эрх зүйн туслалцааны хэлтэст даруй мэдэгдэхээр заасан.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц:

18 дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх

24. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс аль болох богино хугацаанд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг биелүүлэх бөгөөд хүсэлт гаргасан шалтгаан болон хүсэлт гаргагч оролцогч улсаас санал болгосон эцсийн хугацааг аль болох бүрэн харгалзан үзнэ.

Гадаад улсаас ирүүлсэн хүсэлтийн гүйцэтгэлийг дээр дурдсан аргачилсан зааварт заасны дагуу Улсын ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсээр дамжуулан тухайн улсын эрх бүхий байгууллагад илгээнэ.

Энэхүү гарын авлагын хоёрдугаар бүлэгт хөрөнгө буцаан олгох чиглэлээр, гуравдугаар бүлэгт цахим нотлох баримт олж авах чиглэлээр эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт хэрхэн гаргах талаар тодорхой дурдсан болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГӨ БУЦААХ АЖИЛЛАГАА

2.1.Хөрөнгө буцаах ажиллагааг явуулах эрх зүйн үндэслэл, арга хэлбэр, төрөл

2.1.1.Хөрөнгө буцаах ажиллагааны талаар

Хөрөнгө буцаах ажиллагааг явуулахад юуны өмнө “хөрөнгө”, түүнчлэн “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэсэн нэр томьёоны тодорхойлолтыг мөн судлан үзэх нь зүйтэй.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын заалтаас

2 дугаар зүйл. Нэр томьёог хэрэглэх

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн

эсрэг НҮБ-ийн конвенцын заалтаас

2 дугаар зүйл. Нэр томьёог хэрэглэх

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын заалтаас

1 дүгээр зүйл. Нэр томьёо

Монгол Улсын Иргэний хуулийн заалтаас⁷⁹

84 дүгээр зүйл. Эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө

Монгол Улсын Эрүүгийн хуулийн заалтаас⁸⁰

7.5 дугаар зүйл.Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ

Хөрөнгийн буцаах гэдэг ойлголт нь хууль ёсны эзэмшигчээс нь хулгайлах, залилан мэхлэх зэрэг хууль бус аргаар салгасан хөрөнгийг эргүүлэн авах процесс юм.⁸¹

Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд нэн тэргүүнд хийх алхам нь олон улсын түвшинд зохион байгуулагддаг хөрөнгө буцаан авах ажиллагаа болохыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 5 дугаар бүлгээр тодорхойлж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, олон улсын хөрөнгө буцаах ажиллагаа нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын суурь зарчмуудын нэг бөгөөд гэмт хэрэг үйлдэх замаар бий болсон, оффшор бүс, гадаад улсад нуусан хөрөнгө, орлогыг буцаан авахтай холбогдуулан улс орнуудын зүгээс гаргаж байгаа аливаа хүчин чармайлт байдгаараа хөрөнгө хураах ажиллагаанаас илүү өргөн хүрээтэй ойлголт байна.

Авлига, албан тушаалын болон татвар төлөхөөс зайлсхийх зэрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол нь тухайн улс орондоо, ялангуяа хөгжиж буй болон эдийн засгийн тогтолцоо нь шилжилтийн шатандаа байгаа улс орны хувьд нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөхүйц байгаа өнөөгийн нөхцөлд олон улсад хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай зохион байгуулах нь чухал ач холбогдолтой. Гадаад улсад байршуулсан хууль бус хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагааг явуулахдаа

79 Монгол Улсын Иргэний хууль, <https://legalinfo.mn/mn/detail/299>

80 Монгол Улсын Эрүүгийн хууль, <https://legalinfo.mn/mn/detail/11634>

81 Asset recovery, https://en.wikipedia.org/wiki/Asset_recovery

эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алийг нь сонгон хэрэгжүүлэх боломжтой болохыг урьдчилан тооцоолж, хэргийн стратегийг нэн даруй боловсруулах шаардлагатай.⁸²

Олон улсад хөрөнгө буцаах ажиллагааг явуулахад хөрөнгийг мөшгөх, битүүмжлэх, хураан авах, буцаан авах зэрэг зайлшгүй үе шаттайгаар зохион байгуулж байгаа бөгөөд тэдгээр үе шат бүрд эрх зүйн ялгаатай тогтолцоотойгоос гадна өөр өөр улс төрийн хүсэл зориг бүхий улс орнууд оролцдог, мөрдөн шалгах ажиллагааны өндөр өртөг, олон улсын идэвхтэй хамтын ажиллагаа, нууцлал, ур чадвартай мэргэжилтэн, богино цаг хугацаа шаардагддаг, учрах саад, бэрхшээл ихтэй байдгаараа хууль зүйн практикт хэрэгжүүлж байгаа “хамгийн төвөгтэй ажиллагааны нэг төрөл” болж байгаа юм.⁸³

Тиймээс, юуны өмнө хохирогч улс нь хөрөнгийг амжилттайгаар мөшгөж тогтоосон байх шаардлагатай. Хоёрдугаарт, хохирогч улс нь хураан авах хөрөнгийг байршуулсан улсын эрх бүхий байгууллагад хамтран ажиллах хүсэлтийг илгээх ёстой. Энэхүү хүсэлт нь ихэвчлэн эрх зүйн туслалцааны хүсэлт /Mutual legal assistance/, эсхүл шүүгчийн захидал /letter of rogatory/ хэлбэртэй байдаг боловч нийтийн эрх зүйн тогтолцоо бүхий зарим оронд иргэний шүүхэд хандан Маревагийн захирамж /Mareva injunction/-ийг гаргуулахыг зөвшөөрдөг. Гуравдугаарт, ихэвчлэн хүсэлтийг хүлээн авч байгаа улс нь хөрөнгө хураахтай холбогдсон хууль зүйн процесс ажиллагааг эхлүүлэх ёстой байдаг. Эцэст нь, хүсэлтийг хүлээн авсан талын эрх бүхий байгууллага хүсэлт гаргагч улсад хөрөнгийг буцаан олгох ажиллагаа хийгдэнэ.

Улс хооронд зохион байгуулах хөрөнгө буцаах процессын үе шатууд нь:⁸⁴

- хөрөнгийг мөшгөж тогтоох,
- хөрөнгийг хамгаалах буюу битүүмжлэх, түр хураан авах,
- хөрөнгийг хураан авах буюу энэ тухай шүүхийн шийдвэр гаргуулах,
- хөрөнгө хураан авах тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх,
- хөрөнгийг гадаад улсаас буцаан авах зэрэг үе шаттай.

Дээрх бүх үе шатанд олон улсын хамтын ажиллагааг ижил түвшний байгууллага хооронд буюу албан бусаар, мөн эрх зүйн туслалцааны хүсэлтээр дамжуулан албан шугамаар явуулснаар тодорхой үр дүнд хүрэх боломжтой⁸⁵ тул үе шат бүрийг товч авч үзье.

82 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 7 дугаар тал.

83 International asset recovery, https://en.wikipedia.org/wiki/International_asset_recovery

84 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 8 дугаар хуудас.

85 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 220 дугаар тал.

Хөрөнгийг мөшгөх

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг нарийвчлан явуулах замаар хөрөнгийг мөшгөн илрүүлж, байршлыг тогтоосон байх нь аль ч төрлийн хөрөнгийг буцаан авах ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай хамгийн эхний алхам юм.

Хөрөнгийг байршуулсан газраас гадна тухайн хөрөнгө ба гэмт үйлдэл хоёрын шалтгаант холбоо тогтоогдсон байх ёстой. Мөнгөний урсгал бүртгэгддэг санхүүгийн тогтолцоо хэрэгждэггүй буюу бэлэн мөнгөнд суурилсан нийгэмтэй, хөгжиж буй орнуудын хувьд хөрөнгийг мөшгөж тогтоох ажиллагаанд онцгой сорилт үүсдэг тул бусад арга техникийг ашиглах зайлшгүй шаардлагатай байдаг.

Мөнгөний урсгал нь бүртгэгддэг санхүүгийн тогтолцоотой нөхцөлд хураан авсан санхүүгийн баримтууд, сэжигтэй гүйлгээний болон сэжигтэй үйл ажиллагааны тайлангууд, аудитын дүгнэлт зэргээс гадна тагнуулын болон бусад хууль сахиулах байгууллагуудын өндөр түвшний хамтын ажиллагаа нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа хийхэд тусгайлан бэлтгэгдсэн мөрдөгчийн хувьд хөрөнгийг амжилттай мөшгөх ажиллагааг хийхэд тус болох боломжтой. Энэ үе шатанд нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, бүх төрлийн бүртгэлийн сангийн мэдээллийг цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах зэрэг нотлох баримтыг цуглуулах өргөн хүрээний арга хэмжээ авахаас гадна прокурор, эсхүл шүүхийн зөвшөөрөлтэйгөөр ажиглалт, үзлэг, нэгжлэг хийх зэргээр мөрдөн шалгах ажиллагааны тусгай арга, техникийг ашиглаж болно.

Нийтэд ил биш мэдээллийг гадаад улсаас олж авахын тулд эрх зүйн туслалцааны хүсэлт, эсхүл шүүгчийн захидлыг дипломат сувгаар дамжуулан илгээх, мөн гэм хорыг нэхэмжлэх замаар холбогдох материалтай танилцах зэрэг арга замыг хэрэглэж болно. Эдгээр арга зам амжилттай хэрэгжих нөхцөл нь хууль эрх зүйн хамтын ажиллагааг хүлээн зөвшөөрсөн, улс орнууд нэгдэн орсон олон талт, эсхүл хоёр талт гэрээ, хэлэлцээртэй байх явдал юм.

Хөрөнгө хамгаалах

Хөрөнгийн байршлаас хамааран тухайн хөрөнгийг хамгаалах ажиллагаа нь дотоодод болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдана. Гадаад улсын нутаг дэвсгэрт хууль бусаар байршуулсан хөрөнгө, орлогыг хамгаалахын тулд үндэсний хууль тогтоомжоор зохицуулагдсан процессын дагуу прокурор, шүүх зэрэг эрх бүхий байгууллагын хөрөнгө битүүмжлэх, түр хураан авах зэрэг холбогдох шийдвэрийг гаргуулах шаардлагатай.

Түүнээс гадна хөрөнгө хамгаалах шийдвэрийг гадаад улсын шүүх, прокурор зэрэг эрх бүхий ямар байгууллагаас гаргадаг, тухайн шийдвэрийг гаргуулахын тулд ямар ямар баримт, мэдээлэл шаардагддаг болохыг мөрдөн шалгах ажиллагааны явцад судлан үзэж, тэдгээрийг бүрдүүлэн, эрх зүйн туслалцааны хүсэлтийн хамт илгээснээр хөрөнгийг цаг алдалгүй шуурхай хамгаалах нөхцөл бүрдэнэ.

“Улс орнууд мөнгө угаасан өмч хөрөнгө, мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс үүдэлтэй орлого, гэмт хэрэгт ашигласан буюу ашиглахаар завдсан хэрэгсэл, дүйцэх дүнтэй өмч хөрөнгийг илрүүлэх, царцаах,

битүүмжлэх, хураан авах, гаднаас ирсэн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх эрх бүхий байгууллагатай байвал зохино.

Гэмт хэргийн замаар бий болсон хөрөнгийн үнэлгээг төрийн болон төрийн бус байгууллагаар хийлгэх, битүүмжлэгдсэн хугацаанд хадгалж хамгаалах, ингэхдээ тодорхой хувь хүн, компанитай гэрээ байгуулах, шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд худалдан борлуулах зэргээр иргэн, захиргаа, эрүүгийн эрх зүйн холимог журам үйлчилдгээрээ, уг ажиллагаанд оролцдог субъектийн өргөн хүрээтэй байдгаараа хөрөнгө хамгаалах ажиллагаа нь онцлог байна. Энэ талаар “Хөрөнгийн менежмент” бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэргийн замаар бий болсон байж болзошгүй болохыг тогтоосны дараа тэдгээр хөрөнгийг хэзээ битүүмжлэх цаг хугацаагаа оновчтой тодорхойлох нь чухал. Нэг талаас, хөрөнгийг зарим тохиолдолд яаравчлан битүүмжлэхгүй байх нь мөрдөгчид тодорхой хугацаанд мөрөөр нь мөшгөх боломжийг олгодог бол нөгөө талаас уг хөрөнгийн хөдөлгөөнийг хяналтаасаа алдах ч эрсдэл бас байж болохыг тооцоолох хэрэгтэй. Тиймээс нууцлалыг сайтар хангаж, шүүхийн шийдвэр гаргуулах хүртэл шуурхай, хойшлуулшгүйгээр авах боломжтой бусад арга хэмжээнүүдийг эрэлхийлэх нь зүйтэй.

Хөрөнгө хураан авах

Энэ үе шат нь эрүүгийн, иргэний, захиргааны аль ч процессын дагуу битүүмжлэгдсэн, түр хураагдсан хөрөнгө, орлогыг хураан авч, түүний хууль ёсны өмчлөгчид олгох талаар шүүхийн шийдвэр гарснаар хэрэгжинэ. Гэвч зарим оронд шүүхийн шийтгэх тогтоолыг заавал гаргуулсан байхыг шаардалгүйгээр тухайн хөрөнгийг улсын орлого болгох боломжтой байдгийг анхааран судлах нь зүйтэй.⁸⁶

Хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай зохион байгуулахын үндэс нь хөрөнгийг битүүмжлэх, хураан авах явдал бөгөөд үндсэн хэд хэдэн хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой. Үүнд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар, иргэний журмаар, эсхүл захиргааны журмаар зэрэг хураан авах ажиллагаа явуулах боломжтой хувилбаруудаас тохирох хувилбарыг судалж сонгох нь хөрөнгө буцаан авах ажиллагааг амжилттай зохион байгуулах эхлэл болно.

Хөрөнгө хураахад а/ хөрөнгөд суурилсан (тодорхой хөрөнгийг зааж өгдөг), эсхүл б/ үнэлгээнд суурилсан (тодорхой этгээдийн төлөх ёстой үнийн дүнг зааж өгдөг) хоёр аргачлалыг ашигладаг. Зарим улс орнууд энэ хоёр аргачлалыг аль алийг нь ашигладаг бөгөөд олж тогтоосон хөрөнгийг нь хураах, мөн холбогдогч этгээдийн хууль ёсны өмч хөрөнгөөс хохирлыг барагдуулах шийдвэр гаргуулдаг.⁸⁷

Олон улсад хэрэгжиж байгаа өнөөгийн практикаас харахад, эрх зүйн үндэслэл нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, эсхүл тэдгээр улсуудын нэгдэн орсон олон

86 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 17 дугаар тал.

87 Мөн тэнд, 194 дүгээр тал.

талт гэрээ, конвенц байгаа нөхцөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хөрөнгийг буцаан авах боломжтой байдаг.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (а)-д зааснаас харахад, мөрдөн шалгах ажиллагааны явцад хөрөнгө битүүмжлэх, эсхүл эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлах хүсэлтийг илгээж байгаа нөхцөлд тухайн хөрөнгийг зайлшгүй хураан авах шаардлагатай болох талаар хангалттай үндэслэлийг хүсэлтийг хүлээн авагч талд сайтар тайлбарлан өгөх, энэ талаар холбогдох баримтыг хавсарган хүргүүлэхийг гишүүн улсуудад зөвлөсөн байна. Энэ тохиолдолд, хүсэлтийг илгээж байгаа болон хүлээн авагч 2 талын хувьд суурь гэмт хэрэг нь гэмт хэрэгт тооцогддог байх буюу dual criminality⁸⁸ зарчмыг анхаарна уу.

Хөрөнгийг хураан авах талаар эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээх ажиллагаа нь хөрөнгө буцаах ажиллагааны чухал үе шат боловч энэ талаар ямар нэг гэрээ, хэлэлцээр байгуулагдаагүй нөхцөлд өөр улсаас ирүүлсэн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд хойрго ханддаг улс орнууд байсаар байна. Гэвч заавал тухайн хөрөнгийг хураан авах талаар шүүхээс эцсийн шийдвэр гарсан байх шаардлагагүй буюу эрх зүйн туслалцааны хүсэлтийг авлига, албан тушаалын болон мөнгө угаах зэрэг үндэстэн дамнан үйлдэгдсэн хэргүүдэд хөрөнгийг мөшгөж тогтоох, битүүмжлэх хүсэлтийг мөрдөн шалгах ажиллагааны эхний шатанд ч явуулах боломжтой байдаг.

Нөгөө талаас, хөрөнгө буцаан авах ажиллагааг зохион байгуулахад эрүүгийн хэргийн талаар шийтгэх тогтоол гарсан байхыг заавал шаардах боломжгүй нөхцөл байдлууд бас байдаг. Зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүн нь нас барсан, эсхүл оргон зайлсан байж болно. Зарим яллагдагч нь өмгөөлөгчөөрөө дамжуулан эцэс төгсгөлгүй гомдол хүсэлт гаргах, гэрчийг өөрийн талд урвуулах зэргээр мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх оролдлогууд хийх зэрэг саад бэрхшээл гарч байдгийг мөн харгалзах хэрэгтэй.

Хөрөнгө хураан авахад тухайн гэмт хэргийн замаар бий болсон хөрөнгийг шууд хураан авах, эсхүл түүний үнэлгээтэй дүйцэхүйц хэмжээний хөрөнгийг хураан авах практик олон улсад хэрэгжиж байгаа⁸⁹ тул хөрөнгө хураах талаар шүүхийн шийдвэрийг гаргуулахдаа үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах аргыг хэрэглэх тохиолдолд энэ талаар заавал тусгуулж байхыг улсын ялагч, прокурорууд анхаарвал зохино.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх⁹⁰

Хөрөнгө битүүмжлэх, түр хураан авах, эд хөрөнгийн эрхийг хязгаарлах, хураан авах тухай шүүхийн шийдвэрийг гадаад улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэхийн тулд эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээснээр хүсэлтийг хүлээн авсан зарим оронд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрч шууд гүйцэтгэх боломжтой байдаг. Харин зарим орны хувьд, шүүхээс гадаад орны шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай шийдвэрийг зайлшгүй гаргуулах шаардлагатай байдаг байна.

88 <https://www.britannica.com/topic/double-criminality>

89 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 10 дугаар тал.

90 Мөн тэнд.

Авлигын эсрэг НҮБ-ийн конвенц

54 дүгээр зүйл. Хөрөнгө хураах асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар хөрөнгийг буцаах механизм

55 дугаар зүйл.

Хөрөнгө хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагаа

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн конвенцын заалтаас

13 дугаар зүйл Хураах зорилгоор хэрэгжүүлэх олон улсын улсын хамтын ажиллагаа

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын заалтаас

5 дугаар зүйл. Хураах

Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенцын заалтаас

8 дугаар зүйл.

Хөрөнгө буцаан авах

Хөрөнгө буцаан авах талаар шүүхийн шийдвэрийг гаргуулах механизм нь: ⁹¹

- Эрүүгийн хэргийг дотооддоо яллаж, дотоодын шүүхийн шийдвэр гарсны дараа шүүхийн шийдвэрийг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтээр дамжуулан гадаад улсад гүйцэтгэх.
- Шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураан авах шийдвэр дотооддоо гаргаж, уг шийдвэрийг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтээр дамжуулан гадаад улсад гүйцэтгэх.
- Иргэний хувийн нэхэмжлэл үүсгэх (албан ёсоор дампуурлаа зарлаж, төлбөрийн чадваргүй болсонтой холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа).
- Захиргааны журмаар хөрөнгө хураан авах.
- Татвар, торгууль, эрүүгийн хэргийн шүүхээс нөхөн төлбөр гаргаж өгөх шийдвэр зэрэг бусад арга зам.

Хэрэг бүр онцлогтой байдаг бөгөөд эрх зүйн тогтолцооны ялгаатай байдал, улс бүрийн дотоодын эрх зүйн зохицуулалт болон энэ ажиллагааг хэрэгжүүлэх ажилтны ур чадвараас хамаарч хөрөнгө буцаах ажиллагаанд мөрдөгдөх нийтлэг стандарт одоогоор бүрэн тогтоогдоогүй байна.

Хулгайлагдсан буюу хууль бус хөрөнгийг буцаан авах тухай гадаад улсын хүсэлтийг биелүүлэх ажиллагаанд тодорхой зардал гаргах шаардлагатайгаас гадна хууль ёсны хөрөнгө, орлоготой холилдсон тохиолдолд гуравдагч этгээд, шударга эзэмшигчийн эрх ашиг хөндөгдөж байдаг нь хөрөнгө буцаах ажиллагааг улам нарийн төвөгтэй

⁹¹ "Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 12 дугаар тал.

болгодог. Мөн хүсэлт гаргагч улсууд нь ихэвчлэн авлигад идэгдсэн буюу хөрөнгө буцаасны дараа дахин шамшигдуулах эрсдэл хэвээр байдагтай холбоотойгоор буцаан авсан хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар НҮБ-аас баталсан конвенцуудад тусгайлан зохицуулж өгсөн байна.

Авлигын эсрэг НҮБ-ийн конвенцын заалтаас

57 дугаар зүйл. Хөрөнгө буцаах ба захиран зарцуулах

Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай ЮНЕСКО-гийн 1970 оны конвенцын заалтаас

7 дугаар зүйл.

2.1.2. Эрх зүйн үндэслэл, эх сурвалж, баримтлах зарчмууд

Хөрөнгө буцаах ажиллагааг явуулах эрх зүйн үндэслэл нь олон талт болон хоёр талт гэрээ, конвенц, тийм гэрээ, хэлэлцээр байгуулагдаагүй нөхцөлд “харилцан адил байх зарчим”/reciprocity/⁹², түүнчлэн энэ талаарх харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомж байна.

Хөрөнгө буцаах ажиллагааг иргэн, эрүү, эсхүл захиргааны журмаар буюу ямар журам, процедурыг ашиглан зохион байгуулахаасаа хамааран эрх зүйн үндэслэл, эх сурвалж, баримтлах зарчмыг тодорхойлно.

Олон талт гэрээ

Монгол Улс Авлигын эсрэг конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц зэрэг НҮБ-ын олон талт олон улсын гэрээний гишүүн орон бөгөөд тэдгээрийг хөрөнгө буцаах ажиллагааны явцад үндэсний хууль тогтоомжийн нэг адил эрх зүйн үндэслэл болгон хэрэглэж болно.⁹³

Өөрөөр хэлбэл, энэхүү ажиллагааг иргэн, эрүү, захиргааны эрх зүйн зохицуулалтуудын аль боломжит хувилбарыг сонгож, тухайн хөрөнгө буцаан авах ажиллагаа хийгдэх шаардлагатай гэмт хэрэг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн буюу гэмт хэргийг үйлдсэн хүн нь шийтгэгдсэн эсэхээс үл хамааран хэрэгжүүлэх эрх зүйн өргөн боломжийг нээж өгөх үүргийг НҮБ-ын дээрх конвенцүүдийн гишүүн орнууд хүлээсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд зааснаар олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим болон Монгол Улсын олон улсын гэрээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг бөгөөд Монгол Улс нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох “гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин

92 <https://dictionary.cambridge.org/dictionary/english/reciprocity>

93 Монгол Улсын Үндсэн хууль,

биелүүлэх” зарчмыг баримтлах талаар Үндсэн хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэгт тунхагласан.

Монгол Улсын Үндсэн хуулиас:

Аравдугаар зүйл

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

Мөн Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална” гэж заасан. Олон улсын гэрээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Монгол Улсын дээд шүүх шаардлагатай бол Монгол Улсын олон улсын гэрээг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргана” гэж тодорхойлон Улсын дээд шүүхэд олон улсын гэрээний зүйл заалтыг хэрхэн ойлгож зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрхийг өгчээ.

“Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 09 дугаартай Улсын дээд шүүхийн тогтоолд “олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж уг гэрээнд тусгайлан заагаагүй, Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй, албан ёсоор нийтлэгдсэн олон улсын гэрээний заалт Монгол Улсын нутаг дэвсгэрт шууд үйлчилнэ (өөрөө биелэгдэх шинж), Шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хүчин төгөлдөр болсноор заавал даган мөрдөх шинжийг агуулсан, албан ёсоор нийтлэгдсэн, дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан заалтгүй, Үндсэн хуульд харшлаагүй, үндэсний эрх зүйн харилцааны оролцогч этгээдүүдэд шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.” гэж заасан.

А. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 5 дугаар бүлэгт дурдсаныг үзэхэд, “Хөрөнгө буцаах” /Asset recovery/ ажиллагаа бол гадаадад шилжүүлсэн авлигын орлогыг эргүүлэн авч, хууль ёсны эзэмшигчид нь буюу хохирсон улсад нь буцаан шилжүүлэх үйл явц юм.

Хөрөнгө буцаах ажиллагааг хийхэд улс орнууд хамгийн өргөн хүрээнд хамтран ажиллаж, боломжит бүхий л дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын нэгдэн орсон олон талт гэрээ, конвенцод тусган өгчээ.

Авлигын эсрэг конвенцын заалтаас

V БҮЛЭГ ХӨРӨНГӨ БУЦААХ

51 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

53 дугаар зүйл. Хөрөнгийг шууд буцаах арга хэмжээ

Б. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенц

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенцын заалтаас

13 дугаар зүйл. Хураах зорилгоор хэрэгжүүлэх олон улсын улсын хамтын ажиллагаа

В.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцын заалтаас

5 дугаар зүйл. Хураах

Хоёр талт гэрээ

Хөрөнгө буцаах талаар эрх зүйн туслалцааны хүсэлт бичих нь уг хөрөнгийг хураан авч улсын орлого болгох, хохирогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар гаргасан шүүхийн шийдвэрийг гадаад улсад илгээж гүйцэтгүүлэх үндсэн зорилготой байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын шүүхийн шийдвэрийг гадаад улсад биелүүлэхэд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр бусад орны Засгийн газартай байгуулсан хоёр талт гэрээ, хэлэлцээрүүдийг эрх зүйн үндэслэлээ болгох боломжтой. Монгол Улс ямар орнуудтай эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулсан талаар дэлгэрүүлэн “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа” бүлгээс судлан үзнэ үү.

Монгол Улс бусад оронтой байгуулсан ихэнх иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр гэрээний “Нийтлэг үндэслэл” хэсгийн “Гэрээний үйлчлэх хүрээ”, эсхүл “Эрх зүйн туслалцааны хэмжээ”-ний талаарх заалтад тухайн улсад хөрөнгийг мөшгөх, хамгаалах, хураан авахтай холбоотой, зарим гэрээнд хөрөнгийг буцаах, мөн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх талаар тусгайлсан заасан зохицуулалт байгаа тул эдгээрийг сайтар судлан үзэж, хөрөнгө буцаах тухай эрх зүйн туслалцааны хүсэлт бичихдээ үндэслэл болгон бичиж болно. Өөрөөр хэлбэл,

- Бүгд Найрамдах Беларусь Улстай байгуулсан Гэрээ, 18 дугаар зүйл. “Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, гэмт хэрэг үйлдсэн арга, хэрэгсэл”
- Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай байгуулсан Гэрээ, 4 дүгээр зүйл, “Эрх зүйн туслалцааны хүрээ”
- Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулсан Гэрээ, 1 дүгээр зүйл, “Гэрээний үйлчлэх хүрээ”
- Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улстай байгуулсан Гэрээ, 3 дугаар зүйл. “Эрх зүйн туслалцааны хэмжээ”
- Бүгд Найрамдах Чехсловак Улстай байгуулсан Гэрээ, 3 дугаар зүйл, “Эрхийн туслалцаа үзүүлэх хэмжээ”

- Бүгд Найрамдах Унгар Улстай байгуулсан Гэрээ, 4 дүгээр зүйл, “Эрхийн туслалцаа үзүүлэх хязгаар”
- Бүгд Найрамдах Турк Улстай байгуулсан Гэрээ, 25 дугаар зүйл, “Эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх”
- Бүгд Найрамдах Румын Улстай байгуулсан Гэрээ, 4 дүгээр зүйл, “Эрхийн туслалцаа үзүүлэх хэмжээ”
- Бүгд Найрамдах Энэтхэг Улстай байгуулсан Гэрээ, 1 дүгээр зүйл, “Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх үүрэг”, 9 дүгээр зүйл “Үзлэг хийх ба хураах”, 12 дугаар зүйл “Гэмт хэргийн улмаас олсон эд хөрөнгө, ашиг”
- Бүгд Найрамдах Казахстан Улстай байгуулсан Гэрээ, 26 дугаар зүйл, “Эрх зүйн туслалцааны хэмжээ”
- Бүгд Найрамдах Киргизстан Улстай байгуулсан Гэрээ, 2 дугаар зүйл, “Эрх зүйн туслалцаа үзүүлэх”
- Оросын Холбооны Улстай байгуулсан Гэрээ, 5 дугаар зүйл, “Эрх зүйн туслалцааны хүрээ”, 13 дугаар зүйл “Эд зүйл мөнгө шилжүүлэх”
- Украин Улстай байгуулсан Гэрээ, 3 дугаар зүйл, “Эрх зүйн туслалцааны хэмжээ”
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонгконгтой байгуулсан Гэрээ, 1 дүгээр зүйл, “Туслалцааны хамрах хүрээ”.

Зарчим

Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх, олон улсын гэрээгээр зохицуулагдаагүй тохиолдолд харилцан адил байх зарчим /reciprocity/-д тулгуурлан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлж болох талаар Прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт тусгагдсан талаар өмнөх бүлэгт дурдсан бөгөөд энэ нь хөрөнгө буцаах ажиллагааг зохион байгуулахад нэг адил хамаарна.⁹⁴

Үндэсний хууль тогтоомж

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хөрөнгийг “буцаан авах” ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар нарийвчлан зохицуулсан журам байхгүй байна. Харин Монгол Улсын нэгдэн орсон олон талт болон хоёр талт гэрээ, конвенцыг үндэсний хууль тогтоомжийн нэг адил хэрэглэх замаар хөрөнгө буцаах ажиллагааг зохион байгуулах боломжтой байна.

2.1.3. Гадаад улсад илгээх эрх зүйн туслалцааны хүсэлтийн загвар

Гэмт хэрэг үйлдэх замаар бий болгож, гадаад улсад байршуулсан хөрөнгийг мөрдөн шалгах ажиллагааны явцад хураан авах, битүүмжлэх, шүүхийн шийтгэх тогтоолын дагуу буцаан авах зэрэг ажиллагааг хийхтэй холбоотойгоор эрх зүйн

⁹⁴ Прокурорын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12702>

туслалцааны хүсэлтийг боловсруулахад шаардагдах загвар, чеклист, хавсаргах материалыг бүрдүүлэхдээ одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, журамд заасан ерөнхий зохицуулалтуудыг баримтална.

Дээрх материалын жагсаалтыг Монгол Улсын ерөнхий прокурорын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/65 дугаартай тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ын Дөрөвдүгээр бүлэг /“Хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах талаар эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүргүүлэх, биелүүлэх”/-т тусган өгсөн.

Улсын ерөнхий прокурорын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/65 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-аас.

Дөрөвдүгээр бүлэг. “Хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах талаар эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүргүүлэх, биелүүлэх”

4.1 дүгээр зүйл. Хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах ажиллагааны талаар эрх зүйн туслалцааны хүсэлт хүргүүлэх

1. Мөрдөн шалгах байгууллагаас ирүүлсэн хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах ажиллагааг гадаад улсын нутаг дэвсгэрт явуулах тухай хүсэлтийг хүлээн авсан прокурор нь дараах зүйлийг хянаж, дээд шатны прокурорт танилцуулна:

1.1. мөрдөн шалгах ажиллагааны явцад гадаад улсад байршуулсан хууль бус хөрөнгө, орлого, бусад зүйлийн шилжилт хөдөлгөөн, байршил, өмчлөл зэрэг мэдээллийг тогтоосон эсэх;

1.2. Санхүүгийн мэдээллийн алба болон гадаад улсын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцож, хууль бус хөрөнгө, орлого, бусад эд зүйлийг үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан эсэх;

1.3. олон улсын гэрээнд заасан тохиолдолд хууль бус хөрөнгө, орлого, бусад эд зүйлийг иргэний эрх зүйн зохицуулалтын дагуу хураан авах, битүүмжлэх, хадгалах, хөрөнгө буцаан авах боломжтой эсэх;

1.4. хууль бус хөрөнгө, орлогыг хууль ёсны эх үүсвэрээс олж авсан эд хөрөнгөтэй холилдсон тохиолдолд хууль бус хөрөнгө, орлогын хэмжээ, үнийн дүнг тогтоосон эсэх;

1.5. хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, битүүмжлэх, хадгалах, хамгаалах, буцаан авах зардал, тээвэрлэлтийн нөхцөлийн талаарх мэдээлэл авсан эсэх;

1.6. шаардлагатай бусад.

4. Хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах тухай хүсэлтэд дараах мэдээллийг хавсаргаж болно:

4.1.хураан авах, битүүмжлэх, эсхүл буцаан авах хөрөнгийн нэр, төрөл, хэмжээ, үнэлгээ, түүнийг эзэмшигч, холбогдох бүх банкны дансны дугаар, хөрөнгө худалдаж, худалдан авсан талаарх дансны гүйлгээ хүснэгт, график, зохион байгуулалтын схем зэрэг мэдээлэл;

4.2.мөрдөн шалгах ажиллагааны явцад гарсан хөрөнгө, орлогыг хураан авах, битүүмжлэх, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах тухай шийдвэр;

4.3.хөрөнгө орлогыг хураан авч, улсын орлого болгох тухай шүүхийн шийдвэр;

4.4.эрүүгийн хэрэгт хураан авах, битүүмжлэх, улсын орлого болгох ажиллагааг хийлгэх талаар прокурорын нэхэмжлэл;

4.5.хүсэлтийг хүлээн авах улсын эрх бүхий байгууллагатай зөвшилцөн боловсруулсан бол энэ тухай мэдээлэл;

4.6.шаардлагатай бусад.

4.2 дугаар зүйл. Хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураах, битүүмжлэх, буцаан олгох ажиллагааны тухай эрх зүйн туслалцааны хүсэлтийг биелүүлэх

1. Хууль бус хөрөнгө, орлого, эд зүйл хураах, битүүмжлэх, буцаан олгох авах талаар гадаад улсаас ирүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийг биелүүлэхэд энэ зааврын Гуравдугаар бүлгийн 3.1 дүгээр зүйлд заасныг баримтална.

2. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн прокурор ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, дараах зүйлийг хянана:

2.1.эд хөрөнгийн эцсийн өмчлөгч тогтоогдсон эсэх;

2.2.хураах, битүүмжлэх ажиллагаанд гуравдагч этгээдийн эрх ашиг хөндөгдөж байгаа эсэх;

2.3.тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтын тусгай нөхцөл шаардсан эсэх.

3. Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн эзэмшлийн талаар гуравдагч этгээд маргаан гаргасан тохиолдолд Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүсэлт гаргагч улсад албан бичгээр мэдэгдэнэ.

4. Ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан прокурор, мөрдөгч нь хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг олж тогтоосон даруй хөрөнгийг бусдад арилжаалах, шилжүүлэх, устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээгүй оронд илгээх хөрөнгө буцаах хүсэлтийн загвар

ХӨРӨНГӨ БУЦААН АВАХ ТУХАЙ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ХҮСЭЛТ

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХААНААС: Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс

ХААНА:Улсын эрх бүхий байгууллагад

ХҮСЭЛТИЙГ ХҮРГҮҮЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т тусгагдсан бөгөөд олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн “харилцан адил байх зарчим/reciprocity” болон Монгол Улс, Бүгд Найрамдах Франц Улсын нэгдэн орсон “Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай ЮНЕСКО-гийн 1970 оны конвенцын 2 дугаар зүйлийн 2, 13 дугаар зүйлийн b, c-д тус тус заасныг үндэслэн дараах хэрэгт хөрөнгө буцаан авах ажиллагаа /asset recovery/-г хийх талаарх эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүргүүлж байна.

ХЭРГИЙН ТОВЧ УТГА:

Монгол Улсын иргэн Л, Х нар нь бүлэглэн Монгол Улсын Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг дэвсгэрт очиж, хууль бус малтлага хийх замаар олборлосон археологийн олдворыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн.

Тодруулбал, Л, Х нар нь 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Монгол Улсын Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг дэвсгэр Хэрмийн хөндий гэх газраас хууль бусаар малтлага хийж эсгий, торго, даавуугаар хийсэн хувцас, эд өлгийн зүйлс буюу түүх, соёлын үнэт өвд тооцогдох археологийн олдворыг хуурамч гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн байгууллагад худал мэдүүлэн Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж, Бүгд Найрамдах Хятад Улс руу гаргаж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод байршилтай “Тинхуа” компанийн нэрээр хаяглан тус улсын иргэн Вэй Гун-д хууль бусаар худалдан борлуулсан.

ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ:

Гэмт хэрэг үйлдсэн дээрх 2 этгээд нь 2020 болон 2022 онд тус тус нас барсан.

ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛ, ОНОГДУУЛАХ ЯЛ ШИЙТГЭЛ БОЛОН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ТАЛААРХ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЭЛ:

Дээрх хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлд заасан “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” болон 25.4 дүгээр зүйлд заасан “Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх” гэмт хэрэг гэж зүйлчлэн бөгөөд уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан байна. Дээрх зүйлүүд болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар Хавсралт № 01-ээс үзнэ үү.

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААГААР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

Монгол Улсын иргэн Л, Х нар нь бүлэглэн 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Монгол Улсын Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг дэвсгэр Хэрмийн хөндий гэх газраас хууль бусаар малтлага хийж эсгий, торго, даавуугаар хийсэн хувцас, эд өлгийн зүйлс буюу археологийн олдворыг хуурамч гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн байгууллагад худал мэдүүлэн Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж, Бүгд Найрамдах Хятад Улс руу гаргаж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод байршилтай “Тинхуа” компанийн нэрээр хаяглан тус улсын иргэн Вэй Гун-д хууль бусаар худалдан борлуулж, 50 сая төгрөгийг ХХБ-ны дансаараа хүлээн авсан байна.

Дээрх хууль бусаар олж авсан эд өлгийн зүйлсийг БНХАУ-ын иргэн Вэй Гун нь 2017-2019 оны хооронд Бүгд Найрамдах Итали Улсын О хотод бүртгэлтэй, БНХАУ-д хаягтай “Ф” компаниар дамжуулан худалдан борлуулж Итали Улсын хилээр нэвтрүүлсэн болох нь БНХАУ-ын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн “Эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт”-ийн хариу /Хавсралт № 2-аас үзнэ үү/ болон Итали Улсаас Монгол Улсад ирүүлсэн эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт зэрэг нотлох баримтаар тогтоогдсон. /Хавсралт № 3-аас үзнэ үү/

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн захирал Г, тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан У, болон Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч Б нар нь 2016 оны 02 дугаар сарын 18-аас 03 дугаар сарын 12-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Итали Улсын Остиа хотын музейн сан хөмрөгт биечлэн очиж шинжилгээ хийж, тухайн эд өлгийн зүйлс нь Монгол Улсын Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг дэвсгэр Хэрмийн хөндий гэх газраас ихэвчлэн олддог Монгол хатдын дээл хувцас, богтаг малгай мөн болох талаар шинжээчийн дүгнэлт гаргасан. /Хавсралт № 04-аас үзнэ үү/. Мөн Бүгд Найрамдах Итали Улсын Остиа хотын музейн захирал Руми Фонте-гийн nt гаргасан шинжээчийн дүгнэлт гарсан. /Хавсралт № 05-аас үзнэ үү/

Тухайн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэн Л нь 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Х нь 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр тус тус нас барсан болох нь нотлох баримтаар тогтоогдсон.

Иймд уг хэргийн эд мөрийн баримт болох, одоо Бүгд Найрамдах Итали Улсын Остиа хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг дэвсгэр Хэрмийн хөндий гэх газраас ихэвчлэн олддог Монгол хатдын дээл хувцас, богтаг малгай нь Монгол Улсын түүх, соёлын үнэт өв, археологийн дурсгал олдворыг Монгол Улсад буцаан авах ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

Энэхүү эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааг Монголын тал сэргээсэн бөгөөд Италийн талтай хамтран ажиллаж хууль бусаар байршуулсан Монгол Улсын хөрөнгийг буцаан авахад хамтран ажиллахыг хичээнгүйлэн хүсэж байна.

ХӨРӨНГӨ БУЦААН АВАХ АЖИЛЛАГАА ХҮССЭН ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ХҮСЭЖ БУЙ ТУСЛАЛЦААНЫ ТОВЧ АГУУЛГА:

Дээрх хэрэгт хөрөнгө буцаан авах тухай дараах эрх зүйн туслалцааг хүсэж байна:

Бүгд Найрамдах Итали Улсын Остиа хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг дэвсгэр Хэрмийн хөндий гэх газраас олдсон Монгол хатдын дээл хувцас, богтаг малгай буюу Монгол Улсын түүх, соёлын үнэт өв, археологийн дурсгал олдворыг Монгол Улсын Засгийн газарт хүлээлгэн өгч, Монгол Улс руу буцаан олгох ажиллагаанд хамтран ажиллах.

Дээрх хөрөнгийг Монгол Улсад буцаан олгоход шаардлагатай бөгөөд Бүгд Найрамдах Итали Улсын үндэсний хууль тогтоомж, бусад олон улсын холбогдох эрх зүйн зохицуулалтаар хүлээн зөвшөөрөгдсөн аливаа бусад хэлбэрийн туслалцааг үзүүлэхэд хамтран ажиллах.

ХҮСЭЛТИЙН ЗОРИЛГО:

Энэ хэрэгт эд мөрийн баримтаар тооцогдсон Монгол Улсын түүх, соёлын үнэт өв, археологийн дурсгал олдворыг Монгол Улсын Засгийн газарт буцаан авах замаар Монголын нийгэмд, эдийн засаг, нийтийн эрх ашигт учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хохиролгүй болгох зорилготой.

ХӨРӨНГӨ БУЦААХ АЖИЛЛАГААНЫ НУУЦЫГ ХАДГАЛАХ САНАМЖ:

Энэхүү хүсэлт түүнд агуулагдаж байгаа мэдээлэл болон түүнийг гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээллийг бусдад задруулахгүй нууцыг чанд хадгалж ажиллахыг хүсье.

ХУУЛЬ ЗҮЙН БАТАЛГАА:

-Энэхүү хэрэг бүртгэлтийн хэрэгт хүссэн эрх зүйн туслалцаа нь ямарваа улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид бөгөөд хүсэлтийн дагуу цугларсан нотлох баримтыг зөвхөн энэ хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүн таслах ажиллагаанд ашиглах болно.

-Хүсэлт нь хүнийг арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн гарал үүслээр ялгаварлан гадуурхах зорилго агуулаагүй болно.

ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АМЛАЛТ:

Энэхүү хүсэлтийг хүлээн авч, гүйцэтгэх байгууллагаас ижил төрлийн туслалцаа хүссэн тохиолдолд Монгол Улсын эрх бүхий байгууллага адил нөхцөлөөр эрх зүйн туслалцаа үзүүлэх болно.

ТУСГАЙ ХҮСЭЛТ:

Хүсэлтэд дурдсан ажиллагааг явуулахдаа өөрийн орны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу, шүүхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхүйц хэмжээнд бэлтгэж ирүүлэхийг хүсье.

Хүсэлтийг хэсэгчлэн гүйцэтгэсэн бол холбогдох материалыг урьдчилан ирүүлж болно.

ХҮСЭЛТИЙГ БИЕЛҮҮЛЭХ ХУГАЦАА:

Хүсэлтэд заагдсан ажиллагааг аль болох боломжит хугацаанд багтаан гүйцэтгэж ирүүлэхийг хүсье.

ХҮСЭЛТИЙГ ГҮЙЦЭТГЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ХАРИЛЦАХ АЛБАН ТУШААЛТНЫ ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ: Хүсэлтэд дурдсан мэдээллийг тодруулах, яаралтай холбогдох бол ddd@gmail.com имэйл хаягаар, 976-99998888 дугаарын утсаар /Whats App боломжтой/ Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч Б-тэй шууд харилцах боломжтой.

ХАВСРАЛТ:

1. Хавсралт №01 – Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 болон 25.4 дүгээр зүйл, Ерөнхий ангийн 1.10 дугаар зүйл.
2. Хавсралт №02- БНХАУ-ын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн “Эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт”-ийн хариуны хуулбар
3. Хавсралт №03 - Итали Улсаас Монгол Улсад ирүүлсэн эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийн хуулбар.
4. Хавсралт №04-Монголын талаас гаргасан шинжээчийн дүгнэлтийн хуулбар.
5. Хавсралт №05 – Италийн талаас гаргасан шинжээчийн дүгнэлтийн хуулбар

ХҮСЭЛТИЙГ БОЛОВСРУУЛСАН:

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ЭДИЙН
ЗАСГИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
МӨРДӨН ШАЛГАХ ХЭЛТСИЙН АХЛАХ МӨРДӨГЧ,
ЦАГДААГИЙН АХМАД

Г.Б

ТАНИЛЦСАН:

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ЭДИЙН
ЗАСГИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
МӨРДӨН ШАЛГАХ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

С.А

2.1.4. Гадаад орны хуульд заасан тусгай шаардлагууд

Сингапур:⁹⁵

Сингапур Улсын хувьд, хөрөнгө буцаах ажиллагааг “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль”-ийн Гуравдугаар бүлэгт заасны дагуу мөрдөн шалгах болон хөрөнгө буцаах гэсэн 2 үе шаттайгаар авч үздэг.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хөрөнгийг мөшгөж, хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл, санхүүгийн баримтууд, нотлох баримтуудыг цуглуулах, үүний тулд эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээх ажиллагаа хийгдэнэ. Хөрөнгө буцаах үе шатанд хөрөнгийг битүүмжлэх, хураан авах, хөрөнгийг буцаах ажиллагаа багтдаг.

Сингапур Улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийг гадаад улсын эрх бүхий байгууллагаас нэхэмжилж, иргэний журмаар шүүхэд хандах боломжтой байдаг. Тийнхүү нэхэмжлэл бичихэд Сингапур Улсын эрх бүхий байгууллагатай холбогдохыг заавал шаардахгүй боловч тухайн хэрэгт Сингапур Улсад эрүүгийн хэрэг үүсгэн шалгах ажиллагаа явагдаж байгаа нөхцөлд уг ажиллагааг түр түдгэлзүүлэх асуудал гарч болдог. Нэхэмжлэл гаргахтай холбоотой аливаа хууль зүйн зардлыг Сингапур Улс хариуцдаггүй.

Сингапур Улсад байршуулсан хууль бус хөрөнгийг буцаан авахад тавигдах ерөнхий шаардлагыг авч үзвэл,⁹⁶

- Буцаан авах ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл, процессын талаарх мэдээлэл
- Боломжит бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээ, туслалцааны хэлбэрүүд
- Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт гаргахад тавигдах шаардлага, процедурын талаар зааварчилгаа
- Хөрөнгийг буцаах үйл явцад оролцох ажилтнуудтай холбоо барих мэдээлэл
- Хүсэлт гаргагч улс орнууд хүлээн зөвшөөрч болох янз бүрийн загвар, маягтууд

Хөрөнгө буцаах ажиллагааг хийхтэй холбоотой эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхэд шаардагдах мэдээллийг Сингапур Улсын Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль⁹⁷ /Singapore Mutual Assistance in Criminal Matters Act (“MACMA”)/-иас дэлгэрүүлэн судлах боломжтой.

Бүгд Найрамдах Солонгос Улс:⁹⁸

БНСУ хөрөнгө буцаан авах ажиллагааг 2017 оноос Засгийн газрын албан ёсны тэргүүлэх чиглэлийн нэг болгон, идэвхтэй явуулах болсон байна. Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг ихээр үйлдэгдэх болсонтой холбогдуулан 2018 онд БНСУ-ын Дээд прокурорын газрын бүтцэд хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан

95 The practitioner’s guide for Asset recovery in Singapore, 2016, https://www.unodc.org/res/organized-crime/CASC/seajust_documents-and-guides_html/Practitioners_Guide_for_Asset_Recovery_in_Singapore.pdf

96 <https://www.agc.gov.sg/our-roles/international-law-advisor/mutual-Legal-assistance>

97 Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль, Сингапур, <https://sso.agc.gov.sg/Act/MACMA2000>

98 Улсын ерөнхий прокурорын газрын “Мэдээлэл”, 2021.

авч буцаан олгох олон улсын хамтын ажиллагааны талаар судалгаа хийх, Ерөнхий прокурорын чиглүүлсэн хэргүүдэд хөрөнгийг мөшгөх, буцаан авах, буцаан олгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй тусгай нэгж - Эрүүгийн хэргийн улмаас олсон хөрөнгө буцаан авах алба /Criminal Asset Recovery Division/-ыг бий болгосон байна. Тус алба нь ялангуяа Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, нуугдмал хөрөнгийг илрүүлэх зорилготой байна.

БНСУ гадаадын хэд хэдэн оронтой ялангуяа мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх өндөр эрсдэл бүхий татварын гэмт хэргүүд, залилах, авлигын хэргүүд, мөрийтэй тоглоом тоглох, завших, хэрэглэгчийг хуурч мэхлэх, бэлэн мөнгөөр болон виртуал хөрөнгийн худалдаа хийх зэрэг хэргүүд дээр хөрөнгө хураан авч буцаан авах ажиллагааг амжилттай хамтран зохион байгуулж ажилласан байна.⁹⁹

Солонгос Улс хөрөнгө буцаах ажиллагаа явуулах, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар зохицуулсан эрх зүйн хүчирхэг механизмтай бөгөөд хэргийн төрлөөс хамаарч процесс ажиллагааг зохицуулсан тус тусдаа бие даасан хуулиудыг бий болгосон байна.

Хөрөнгө буцаан авах ажиллагаатай холбоотой БНСУ-ын хууль тогтоомж:

Гэмт хэргийн замаар олсон орлогыг нуун дарагдуулахыг хориглох тухай акт;

Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой тусгай хэргүүдээс урьдчилан сэргийлэх тухай акт;

Төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө хураан авах ажиллагааны тухай акт;

Улс төрийн албан тушаалтны үйлдсэн хэргийн хөрөнгө хураах тухай акт;

Авлигын замаар олж авсан эд хөрөнгийг хураах, буцаан авах тухай Тусгай хэргүүдийн акт;

Санхүүгийн гүйлгээний тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай акт;

Эрүүгийн хэргийн талаар олон улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хууль;

“Хөрөнгө буцаан авах ажиллагааны алхмууд-2020” зааварчилгаа, БНСУ-ын Хууль зүйн яам.

БНСУ энэхүү тогтолцоогоо улам бэхжүүлэх, улс хооронд хөрөнгө хураан авч буцаах ажиллагааг хөнгөвчлөх боломжтой механизм, арга хэмжээг системтэйгээр ашиглах арга замыг боловсронгуй болгохоор судлан ажиллаж, 2020 онд БНСУ-ын Хууль зүйн

⁹⁹ Anti-money laundering and counter-terrorist financing measures in Korea – © FATF-APG | 2020

яамнаас “Хөрөнгө буцаан авах ажиллагааны алхмууд-2020” зааварчилгаа”¹⁰⁰-г эрхлэн гаргасныг дэлгэрүүлэн авч үзье.

Тухайлбал, авлигын гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг БНСУ-д байршуулсан болох нь тогтоогдсон бөгөөд түүнийг буцаан авах хүсэлтийг албан ёсоор гаргах буюу эрх зүйн туслалцааны хүсэлтийг зохих сувгаар дамжуулан илгээнэ. Тийнхүү хүсэлтийг илгээхэд тухайн хүсэлтийг илгээгч оронтой заавал 2 талт, эсхүл олон талт гэрээ байгуулсан байх шаардлагагүй бөгөөд харилцан амлалт өгч, ижил төрлийн туслалцаа үзүүлэх зарчмын дагуу илгээх боломжтой болох талаар БНСУ-ын Эрүүгийн хэргийн талаар олон улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хуульд тодорхой заасан байна.

БНСУ-д бүртгэгдсэн үл хөдлөх хөрөнгө, хөлөг онгоцны эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн талаарх холбогдох мэдээллийг ямар ч хүн дэлхийн аль ч орноос www.igos.go.kr цахим хуудаснаас шууд орж харах боломжтой байдаг. Хөрөнгө битүүмжлэхтэй холбоотой эрх зүйн туслалцааны хүсэлт илгээх бол БНСУ-ын Гэмт хэргийн замаар олсон орлогыг нуун дарагдуулахыг хориглох тухай актын 11 болон 12 дугаар зүйл, мөн Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой тусгай хэргүүдээс урьдчилан сэргийлэх тухай актын 64-78-д тус тус заасны дагуу эрх зүйн туслалцааны хүсэлтийг бичнэ.

Тухайн эрх зүйн туслалцааны хүсэлт нь мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, прокурор, шүүхийн алинаас нь ирснээс үл шалтгаалан уг хүсэлтийг биелүүлэх үндэслэлтэй эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх хянаж, хөрөнгийг хураан авах талаар шийдвэрийг гаргаснаар уг шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа эхэлнэ. Хүсэлтэд сэжигтний овог нэр, хэргийн зүйлчлэл, хэргийн факт, хөрөнгө хураах талаар зохицуулсан хуулийн заалт, хөрөнгийн эзэмшигчийн талаарх мэдээлэл, түүний эрх, хөрөнгийг эзэмших болсон цаг хугацаа зэрэг мэдээллийг тодорхой тусгасан байхыг шаарддаг. Хэрэв хөрөнгийг хураан авах талаар гадаад улсын шийдвэр гарсан бол тухайн шийдвэр нь шүүхийн эцсийн шийдвэр байхыг шаарддаг.

Гэмт хэргийн замаар олсон орлогыг нуун дарагдуулахыг хориглох тухай актын 11 дүгээр зүйлд, хөрөнгө захиран зарцуулах эрх хязгаарлах, хөрөнгө битүүмжлэх, хураан авах талаарх гадаад улсаас ирүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийг дараах тохиолдолд хүлээн авахаас татгалзаж болно:

- Солонгосын хууль тогтоомжийн дагуу хөрөнгө буцаах ажиллагаа явуулах шаардлагатай гэж тооцогддоггүй хэрэг, эсхүл мөнгө угаах гэмт хэргийн замаар бий болоогүй буюу гэмт хэргийн замаар бий болоогүй тохиолдолд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт бичигдсэн тохиолдолд;
- Хүсэлт гаргагч улс нь БНСУ-д ижил төрлийн туслалцаа үзүүлэх талаар баталгаа гаргаагүй;

100 Step by step guide for asset recovery, Ministry of Justice, Republic of Korea, 2020 <https://star.worldbank.org/sites/default/files/2020-12/2020%20G20%20Asset%20Recovery%20Guide%20South%20Korea.pdf>

- Хүсэлтэд дурдсан хэрэг нь БНСУ-ын хуулиар гэмт хэрэгт тооцогддоггүй буюу шийтгэгдэхгүй бол;
- Хүсэлтэд заасан хэрэг нь шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа, эсхүл шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж хөрөнгийг хураах талаар шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл тухайн хүсэлтийн дагуу уг хөрөнгийг хураан авах зорилгоор битүүмжилсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан бол;
- Тухайн хөрөнгийг хураан авах ажиллагааг явуулах шаардлагагүй гэж шүүх үзсэн;
- Ипотек зэрэг шалтгаанаар тухайн хөрөнгийн талаар нэхэмжлэх эрх нь үүсээгүй гуравдагч этгээдийн эрх хөндөгдсөн гэж үзэх үндэслэл бүхий тохиолдолд.

Түүнчлэн “Авлигын замаар олж авсан эд хөрөнгийг хураах, буцаан авах тухай Тусгай хэргүүдийн акт”-д заасны дагуу авлигын гэмт хэрэгтэй холбогдуулан хүссэн дараах эрх зүйн туслалцааны хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж болно.

- Хүсэлтэд дурдсан хэрэг нь БНСУ-ын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бөгөөд Солонгосын хуулийн дагуу авлигын гэмт хэрэгт тооцогддоггүй,
- Хүсэлтийн дагуу хураан авсан хөрөнгийг жинхэнэ эцсийн өмчлөгч, хохирогч зэрэг хууль ёсны эрхтэй бусад этгээдэд хүлээлгэн өгөх талаар хүсэлт гаргагч орны зүгээс баталгаа гаргаагүй,
- Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой тусгай хэргүүдээс урьдчилан сэргийлэх тухай актын 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хураан авах шийдвэр гаргаснаас бусад хэргийн хувьд.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 1976 онд Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын Холбооны конвенцын гишүүн орон болж, 1994 онд Эрүүгийн хэрэгт олон улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Актыг,¹⁰¹ 2015 онд “Германы хууль тогтоомжийн дагуу хөрөнгө буцаах-Практик ажилтнуудад зөвлөмж”-ийг тус тус баталсан бөгөөд хөрөнгө буцаахтай холбогдсон бүхий л асуудлыг зохицуулж өгсөн байна ¹⁰².

2015 онд батлагдсан дээрх зөвлөмжид Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай хөрөнгө буцаах асуудлаар харилцах, хүсэлт гаргахын тулд Герман Улсын үндэсний хууль тогтоомжоос гадна түүний нэгдэн орсон бүхий л олон талт гэрээг эрх зүйн үндэслэлээ болгож болох талаар заасан байна.¹⁰³

Улс хооронд хөрөнгө буцаах асуудлаар хүсэлт гаргаж хамтран ажиллахад, ХБНГУ гишүүн нь болсон Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын Холбооны

101 Act on International Mutual Legal Assistance in Criminal Matters, Germany, https://www.gesetze-im-internet.de/englisch_irg/

102 <https://cifar.eu/wp-content/uploads/2019/06/1.-English-Report-2019-Asset-recovery-Germany.pdf>

103 Asset Recovery under German Law - Pointers for Practitioners - <https://star.worldbank.org/sites/star/files/asset-recovery-in-german-law-english.pdf>

конвенц, түүний нэмэлт протоколууд, Европын Консулын Гэмт хэргийн ашиг орлогыг угаах, илрүүлэх, царцаах, хураан авах тухай конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенц, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын заалтыг эх сурвалжаа болгож болно.

ХБНГУ-ын Эрүүгийн хэрэгт олон улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Актад хөрөнгө хураах тухай гадаад улсын шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх талаар тусгаж өгсөн. Тухайн шүүхийн шийдвэр нь хүсэлтийг илгээсэн улсын дотоодын хуульд заасны дагуу хуулийн хүчин төгөлдөр болсон байх, хөрөнгө буцаах хэрэг нь хүсэлтийг илгээсэн болон хүлээн авагч улсын хуулиар гэмт хэрэгт тооцогдох зэрэг шаардлагыг юуны түрүүнд тавьсан байна.¹⁰⁴

2.1.5. Виртуал хөрөнгийг буцаах ажиллагаанд анхаарах асуудал

Виртуал хөрөнгийг буцаан авах ажиллагааг хийхэд виртуал хөрөнгө гэж юу болох, хэрхэн бий болгодог, ямар шинж чанартай болох, түүний төрлүүд, түүнчлэн уг хөрөнгийг ашиглан үйлдэгдэх эрсдэлтэй гэмт хэргүүдийн онцлогийг сайтар судлан ойлгох нь чухал юм.

“Виртуал хөрөнгө” гэж аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монгол банкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэний дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг хэлдэг.¹⁰⁵ Албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаас зэрэг ФАТФ-ын бусад зөвлөмжөөр хамруулсан бусад санхүүгийн хөрөнгө нь виртуал хөрөнгөд хамаарахгүй.¹⁰⁶

Мөн виртуал хөрөнгө нь “Төв банк, эсхүл төрийн байгууллагаас гаргаагүй, баталгаажуулаагүй, хууль ёсоор тогтоогдсон мөнгөн тэмдэгттэй заавал холбоогүй, мөнгө тэмдэгт, мөнгөний эрх зүйн статусгүй боловч үнэ цэний дижитал дүрслэл” гэж тодорхойлсон байдаг. Хувь хүн, хуулийн этгээд солилцооны хэрэгсэл болгон хүлээн зөвшөөрсөн бөгөөд цахим хэлбэрээр шилжүүлэх, хадгалах, арилжаалах боломжтой байна.¹⁰⁷

Виртуал хөрөнгийн онцлог шинж чанараас хамааран мөнгө угаах, татвараас зайлсхийх, терроризм болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх зэрэг гэмт хэрэг үйлдэгдэх өндөр эрсдэлийг дагуулдаг гэж үздэг бөгөөд 2020 оны байдлаар дэлхий нийтэд үйлдэгдсэн гэмт хэргүүдийг авч үзэхэд, цахим орчныг ашигласан залилах гэмт хэрэг бүх хэлбэрээр үйлдэгдэх болсон байна.¹⁰⁸

¹⁰⁴ Act on International Mutual Legal Assistance in Criminal Matters, Germany, [section 49 (1) no. 3, section 66 (2) no. 1 IRG].

¹⁰⁵ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, 2021, 4 дүгээр зүйлийн 4.1.1, <https://legalinfo.mn/mn/detail?lawld=16390242606091>

¹⁰⁶ Виртуал хөрөнгийн ерөнхий ойлголт, зах зээл ба зохицуулалтын нөхцөл байдал, 2021, 5-р хуудас.

¹⁰⁷ “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 122 дугаар тал.

¹⁰⁸ Виртуал хөрөнгийн ерөнхий ойлголт, зах зээл ба зохицуулалтын нөхцөл байдал, 2021, 16-21 дүгээр тал.

Виртуал хөрөнгийг дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой байдагтай холбоотойгоор түүнийг хураах, битүүмжлэх, буцаах ажиллагаа нь ердийн үл хөдлөх хөрөнгө, аль нэг банкны дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг хураах, битүүмжлэх, буцаах ажиллагаанаас илүү нарийн төвөгтэй.

Одоогийн байдлаар гэмт хэргийн замаар бий болсон виртуал хөрөнгийг буцаах ажиллагааг хийх журмыг Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын үндэсний хууль тогтоомжоор тусгайлан зохицуулаагүй боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ерөнхий зохицуулалтын хүрээнд холбогдох ажиллагааг хийнэ.

Биткойн зэрэг криптовалютыг хураан авч, найдвартай хадгалахын тулд хууль сахиулах байгууллагууд криптовалютын хэтэвчийг бэлэн байлгахад анхаарах, ингэснээр мөрдөн шалгах ажиллагааны явцад битүүмжилсэн, царцаасан виртуал хөрөнгийг тухайн хэтэвчид шилжүүлэх боломж бүрдэх боломжтой болохыг олон улсын судлаачид анхааруулдаг.¹⁰⁹

Тухайн хөрөнгө гэмт хэрэгтний анхны хэтэвчид байгаа тохиолдолд гэмт хэрэгтэн тухайн хэтэвчний нууц үг, хувийн түлхүүрийг сэргээх үгсийг олж авах боломжтой учраас хөрөнгийг шилжүүлэх эрсдэл хэвээр байдгаас гадна криптовалютын үнийн тогтворгүй байдлын улмаас шүүх ажиллагааны явцад арилжаа хийхэд хүндрэлтэй байдгийг анхаарах хэрэгтэй.¹¹⁰

2.1.6. Хөрөнгө буцаах талаар гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэх

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг биелүүлэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Дөчин хоёрдугаар бүлгийн 42.4 дүгээр зүйлд заасан байна.¹¹¹

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн

42.4 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг биелүүлэх

Прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1¹¹²-д заасны дагуу эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллага нь прокурорын төв байгууллага буюу Улсын ерөнхий прокурорын газар байна.

Монгол Улсын ерөнхий прокурорын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/65 дугаартай тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ын Гуравдугаар бүлэг

109 Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020, 12 дугаар тал.

110 Мөн тэнд.

111 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/12694>

112 Прокурорын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12702>

/“Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг биелүүлэх”/-т Улсын ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс энэ асуудлыг хариуцан зохион байгуулах талаар тусган өгсөн байна.

Монгол Улс тухайн гадаад улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээнд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх асуудал тусгагдсан бол уг гэрээний заалт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт заасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай эрх бүхий этгээдийн хүсэлтээр шийдвэрлэнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 194 дүгээр зүйлд “гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр тодорхойлогдох” талаар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 116 дугаар зүйлд “Монгол улсын нутаг дэвсгэр дээр гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх журмыг Монгол Улсын үндэсний хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлох” тухай тус тус заасан.

Гадаад улсын шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрч албадан биелүүлэх тухай хүсэлтийг холбогдох этгээдээс хариуцагч этгээдийн оршин суугаа хаягийн харьяа шүүхэд шууд, эсхүл хэргийг хянан шийдвэрлэсэн гадаад улсын анхан шатны шүүхээр дамжуулан гаргаж болно. Хэрэв хэргийг хянан шийдвэрлэсэн гадаад улсын анхан шатны шүүхэд хүсэлт гаргасан бол тухайн шүүх уг хүсэлтийг олон улсын гэрээнд заасан журмын дагуу хоёр улсын “эрх бүхий төв байгууллага”-уудаар дамжуулан Монгол Улсын холбогдох шүүхэд ирүүлнэ. Шүүх уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх тухай шийдвэр гаргахдаа зохигчдоос болон шийдвэр гаргасан шүүхээс нэмэлт тайлбар шаардаж болно.

Хүсэлт хүлээн авсан улсын шүүх гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх буюу уг шийдвэрийг биелүүлэх талаар шийдвэр гаргахдаа зөвхөн олон улсын гэрээнд заасан нөхцөл шаардлага биелэгдсэн эсэхийг хянана.

Шийдвэрийг биелүүлэх тухай хүсэлтийг хэлэлцэх эрх бүхий байгууллага нь дараах асуудлыг хэлэлцсэнээр хязгаарлагдана:

- Албадан гүйцэтгүүлэх шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон,
- Шийдвэрийн үнэн зөв байдал нь түүнийг гаргасан шүүхээр баталгаажсан /хүсэлт гаргагч байгууллагын эрх бүхий байгууллагаас шийдвэр хүчин төгөлдөр болсныг баталсан мэдэгдэл буюу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсныг нотлох зохих ёсоор гэрчлэгдсэн баримт бичиг байхыг/,
- Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхийг шийдвэр гаргасан шүүх зөвшөөрөн дэмжиж байгаа,

- Хүсэлт хүлээн авсан шүүхийн нутаг дэвсгэрт тухайн зохигчдын хоорондох хэрэгт гаргасан гуравдагч улсын шүүхийн шийдвэр хүлээн зөвшөөрөгдөөгүй ба гүйцэтгээгүй байх;
- Хүсэлт хүлээн авсан шүүх урьд нь тухайн зохигчдын хооронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулаагүй, шийдвэр гаргаж байгаагүй байх;
- Хүсэлт хүлээн авсан улсын эрх зүйн үндсэн зарчим болон нийгмийн хэв журамд харшлах зүйл агуулаагүй байх;
- Хүсэлт хүлээн авсан улсын хуулийн дагуу шийдвэр гаргасан шүүх эрх бүхий байх;
- Тухайн зохигчид нь өөрийн эрхийг хамгаалах боломжоо алдаагүй байх. Тухайлбал, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхэд оролцоогүй зохигчид шүүхийн мэдэгдэх дуудах хуудсыг хүргүүлсэн байх;
- Олон улсын гэрээнд заасан бусад нөхцөл;
- Шийдвэрийн эх албан ёсоор орчуулагдсан, зохих журмын дагуу ирүүлсэн эсэх.

Өөрөөр хэлбэл, тухайн улсын нутаг дэвсгэр дээр гадаад улсын шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх шаардлагатай бол эхлээд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөх шаардлага үүсэж байна. Зарим улсад шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудас бичигдсэн нь уг шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсний нотолгоо болно. Мөн гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн тухай шийдвэр гаргах тохиолдолд шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай гүйцэтгэх хуудас бичигдэнэ.

2023 оны байдлаар гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлж хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай гүйцэтгэсэн нэг хэргийн жишээг энд дурдъя.¹¹³

2011 оны 7 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос Улсын Дээд прокурорын газраас БНСУ-д “Мөнгө угаах” гэмт хэрэгт ял шийтгэгдсэн БНСУ-ын иргэн А нь 2005-2008 онд хууль бусаар олсон нийт 70 гаруй удаагийн гүйлгээгээр шилжүүлсэн мөнгөө ашиглан өөрийн нагац ахын нэр дээр Монгол Улсад компани байгуулж, зочид буудал бариулсан 1,6 сая ам.доллартой тэнцэх хууль бус хөрөнгийг хураан Солонгосын талд буцаан шилжүүлэх хүсэлтийг Монгол Улсын Ерөнхий прокурорын газарт ирүүлсэн.

Уг Солонгосын шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд Монгол Улсын ерөнхий прокурорын газар төлөөлөн оролцох итгэмжлэлийг олгосон.

БНСУ-ын шүүхийн шийдвэрийг Монгол Улсад гүйцэтгэх тухай Монголын шүүхийн шийдвэрийг Улсын Дээд шүүхээс харьяалал тогтоосон шүүхээс гарган, уг шийдвэрийг гүйцэтгэх хуудас бичигдсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаар дамжуулан зочид буудлыг битүүмжилсэн.

Зочид буудлыг бусдад дамжуулан худалдсан байсан тул тэдгээр шударга эзэмшигчид нь иргэний нэхэмжлэлийг шүүхэд гаргасан.

113 Улсын ерөнхий прокурорын газрын архивын материал, 2012 он.

Давж заалдах шатны шүүхээс 2012 оны 03 дугаар сард шийдвэр гарч, шударга эзэмшигчдэд битүүмжлэгдсэн хөрөнгийн 65% оногдож байгаа талаарх шийдвэрийг гаргасан.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа үргэлжилж, битүүмжлэгдсэн хөрөнгийг дуудлага худалдаанд оруулан худалдсан

Шүүхийн шийдвэрт заасан хэмжээний мөнгийг хураан авч, шүүхийн шийдвэрт заагдсаны дагуу БНСУ-ын Дээд прокурорын газраас ирүүлсэн данс руу 2012 оны 12 дугаар сард Солонгосын талд шилжүүлснээр БНСУ, Монгол Улсын хооронд “Мөнгө угаах” гэмт хэрэгт 1,6 сая ам.долларын хөрөнгийг буцаан олгох ажиллагаа амжилттай явагдсан.

Монгол Улсын шүүхийн шийдвэрийг гадаад улсын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрөх, биелүүлэхийг хүссэн хүсэлтийг хувьд, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх сонирхол бүхий этгээд олон улсын гэрээнд заасны дагуу тухайн шийдвэрийг нутаг дэвсгэртээ гүйцэтгэх улсын шүүхэд шууд, эсхүл тухайн шийдвэрийг гаргасан анхан шатны шүүхэд хүсэлт гаргаж болно.

Тухайлбал, Украин, Польш улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд “өргөдөл гаргагч шийдвэрийг биелүүлэх ёстой хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт оршин суудаг, оршин байгаа бол өргөдлийг хэлэлцэн тохирогч энэ талын шүүхэд шууд гаргаж болно.” гэж тусгагдсанаас гадна талууд харилцан шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх үүрэгтэй болохыг баталгаажуулжээ.

Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улстай 1998 онд байгуулсан “Иргэн, гэр бүл, хөдөлмөр, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай гэрээ”-нээс

3 дугаар зүйл,

16 дугаар зүйл,

28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2.

Монгол Улс, Украин Улстай 1995 онд байгуулсан “Иргэний болон Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”

3 дугаар зүйл,

5 дугаар зүйл,

17-21 дүгээр зүйл.

Тодруулбал, тухайн этгээд хүсэлтээ гадаад улсын холбогдох шүүхэд хаяглан Монгол Улсын шүүхийн шийдвэрийг өөрийн улсын нутаг дэвсгэртээ хүлээн зөвшөөрч, албадан биелүүлэхийг хүсэж байгаагаа дурдаж, хэзээ, хаана, хэний гаргасан шийдвэр болох, өөрийн болон хариуцагч этгээдийн овог, нэр, хаягийг зааж өгнө. Мөн мөнгөн

хөрөнгө нэхэмжилсэн тохиолдолд хүсэлтдээ мөнгө хүлээн авах банкны мэдээллийг дэлгэрэнгүй тусгана.

Монгол Улсын шүүх сонирхогч этгээдээс ийм хүсэлт хүлээн авсан тохиолдолд хүсэлтийг гадаад улсын шүүхэд илгээх бөгөөд шүүхийн шийдвэрийн баталгаат хуулбар, тухайн шийдвэр хүчин төгөлдөр болсон тухай лавлагаа, хариуцагч этгээдэд зохих ёсоор нэхэмжлэлийг гардуулсан, шүүх хуралдааны товыг цаг тухайд нь мэдэгдсэн талаар лавлагаа болон хүсэлт гаргах үед тухайн шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг биелүүлсэн бол энэ тухай лавлагааг хавсаргаж, бүх баримт бичгийг олон улсын гэрээнд заасан хэлээр, эсхүл хүсэлт хүлээн авах улсын хэлээр үйлдсэн орчуулгын хамт илгээнэ.

Гадаад улсын холбогдох шүүх эхлээд тухайн шийдвэрийг хүлээн зөвшөөрч өөрийн улсын нутаг дэвсгэрт биелүүлэх тухай шийдвэр (экзекватур) гаргаж дараа нь тухайн улсын хуулийн дагуу уг шийдвэр (экзекватур)-ийг гүйцэтгэх ажиллагааг эхлүүлнэ.

2.2.Хөрөнгө буцаах талаар хүсэлтийг илгээхээс өмнөх ажиллагаа

Хөрөнгө буцаах талаар хүсэлтийг гадаад улсад илгээхээс өмнө тухайн хууль бус хөрөнгийг илрүүлж тогтоон, хамгаалах буюу битүүмжлэх процесс явагдсан байх талаар өмнө дурдсан.

“Гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгийг буцаан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах талаар зөвлөмж”-д¹¹⁴ улс орнууд шаардлагатай мэдээллийг цуглуулан тодорхой үр дүнтэй шуурхай ажиллахад чиглэгдсэн урьдчилсан дүн шинжилгээ хийх алхмуудын талаар тусгасан байдаг. Тодруулбал,

- гэмт хэрэгт холбогдсон хүн, тэдгээрийн хамаарал бүхий этгээд болон хөрөнгөтэй холбоотой бүхий л анхдагч мэдээллийг боломжит эх сурвалжийг ашиглан, цуглуулж, бэхжүүлэх,
- хөрөнгийн байршлыг олж тогтоох, битүүмжлэх зэргээр хамгаалах,
- хөрөнгийг буцаан авах улс орны үндэсний хууль тогтоомжийг судлах,
- хийгдэх шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөөг гаргах, хугацааг тооцох, нууцлалыг хамгаалах,
- хөрөнгийг буцаан авах талаар эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхтэй холбоотой бэлтгэл ажлыг хийх, харилцагч нөгөө улсын эрх бүхий байгууллагатай холбоо тогтоох, хүсэлттэй холбоотой зөвлөгөө мэдээлэл авах шууд холбоо, сүлжээ үүсгэн шуурхай харилцах зэрэг шаардлагатай бүх алхмуудыг тодорхойлсон байгааг мөрдөгч, прокурор анхааран судлах нь зүйтэй.

Дээрх мэдээллийг цуглуулахдаа хууль сахиулах байгууллагуудын албан бус хамтын ажиллагааны сувгуудыг өргөнөөр ашиглах, олон улсын хамтын ажиллагааны бусад

114 Guidelines for the efficient recovery of stolen assets, https://learn.baselgovernance.org/pluginfile.php/6239/mod_resource/content/4/Asset%20recovery%20guidelines.pdf

хэлбэрүүдийг хэрэглэх, бүс нутгийн түвшинд ажилладаг сүлжээ байгууллагуудтай хамтран ажиллах талаар энэхүү бүлгийн дараагийн хэсгүүдэд дэлгэрүүлэн авч үзэх юм.

2.2.1. Хүсэлтийг илгээхээс өмнө бүрдүүлэх мэдээлэл

Хөрөнгө буцаах талаарх хүсэлтийг илгээхээс өмнө цуглуулах шаардлагатай мэдээллийн чеклистийг дээр дурдсан Монгол Улсын ерөнхий прокурорын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/65 дугаартай тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааны аргачилсан заавар”-ын Дөрөвдүгээр бүлэг /“Хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах талаар эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүргүүлэх, биелүүлэх”/-ийн 4.1 дүгээр зүйл /Хууль бус хөрөнгө, орлого, эд зүйлийг хураан авах, битүүмжлэх, буцаан авах ажиллагааны талаар эрх зүйн туслалцааны хүсэлт хүргүүлэх/-ээс тодруулан харах боломжтой.

Түүнчлэн хөрөнгө буцаах хүсэлтийг илгээх орны дотоодын хууль тогтоомжоор зайлшгүй шаарддаг мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэр зэргийг прокурор, мөрдөгч шалгаж үзсэний эцэст хүсэлтийг илгээх нь зүйтэй байдаг. Энэ талаар тус бүлгийн 2.1 дүгээр хэсгийн 2.1.3-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

2.2.2. Нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах

Гадаад улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийг буцаан авах ажиллагаа нь процессын хувьд тухай хөрөнгийг буцаан авах хүсэлтийг илгээхээс өмнөх, хүсэлтийг илгээх, тийнхүү илгээсний дараа хийгдэх ажиллагаа гэсэн үндсэн үе шатуудад хуваагдаж болно.

Хүсэлтийг илгээхээс өмнө тухайн хууль бусаар байршуулсан хөрөнгийн мэдээллийг боломжит бүх хувилбараар буюу интернэт, төлбөртэй цахим хуудас, хувь хүн, байгууллагын цахим хуудас зэрэг нийтэд ил байгаа мэдээллээс авах боломж байдаг. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу мөрдөн шалгах ажиллагааны явцад мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах тухай прокурорын зөвшөөрлийг үндэслэн энэхүү ажиллагааг хийх боломжтой байна.

Түүнчлэн эдгээр мэдээллийг хамтран ажилладаг бусад олон улсын байгууллага, сүлжээгээр дамжуулан авах боломжтой болох талаар 2.2.3 дахь хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

2.2.3. Олон улсын байгууллага, сүлжээ

Хөрөнгө буцаах ажиллагааг хэрэгжүүлэхэд албан болон албан бус хамтын ажиллагааны хүрээнд олон улсын түвшинд хамтран ажиллаж, мэдээлэл солилцох ажиллагааг тухайн улсын хууль сахиулах байгууллагын түвшинд болон тэдгээр байгууллагууд оролцон байгуулсан сүлжээнд бүртгүүлсэн “харилцах хүн”-ээр дамжуулан мэдээлэл солилцох зэргээр хамтран ажиллах өргөн боломжтой. Мөн эрх

зүйн туслалцааны хүсэлт илгээсний дараа “эрх бүхий төв байгууллага”-уудын сүлжээг өргөнөөр ашиглах нь зүйтэй.

Ямар төрлийн мэдээллийг ямар сувгуудаар дамжуулан олж авах боломжтой болохыг “Хөрөнгө буцаах ажиллагааны тухай гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж”-ийн Хавсралт Н, J¹¹⁵-д тус тус дэлгэрэнгүй жагсаан үзүүлсэн байна.

а/ Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга¹¹⁶ - СтАР /StAR - the Stolen Asset Recovery initiative/ бол авлигын гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг хамгаалах чиглэлээр олон улсын хүчин чармайлтуудад дэмжлэг үзүүлж ажилладаг. Дэлхийн банкны групп болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны /UNODC-United Nations Office on Drugs and Crime/ хамтарсан хөтөлбөр юм. СтАР нь хөгжиж байгаа орнууд болон санхүүгийн төвүүдтэй авлигын гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг хувиргахаас сэргийлэх талаар хамтран ажиллаж, хууль бус хөрөнгийг илүү системтэйгээр, цаг тухайд нь буцаан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг.

Түүнчлэн СтАР нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын /UNCAC-United Nations Convention against Corruption/ Гишүүн орнуудын чуулган /COSP-Conference of the States Parties/, Их 8 /G-8/, Их 20 /G-20/-ын бүлэг болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /FATF-Financial Action Task Force/, бусад олон улсын байгууллагууд, бодлого тодорхойлогч нартай олон улсын хөрөнгө буцаах ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах, хөгжүүлэхэд хамтран ажилладаг.

б/ Хууль бус хөрөнгийг буцаан олгох Ази Номхон далайн орнуудын сүлжээ¹¹⁷ – АРИН-АП /ARIN-AP-Asset recovery interagency network-Asia Pacific/ нь 2013 онд байгуулагдсан, гэмт хэргийн замаар бий болсон хөрөнгийг буцаан авахад холбогдох харилцан мэдээлэл солилцох, сургалт семинар зохион байгуулах, техникийн бусад төрлийн туслалцаа үзүүлэх, хөрөнгийг мөшгөх, битүүмжлэх, хураан авах, буцаах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах замаар гэмт хэрэгтэй тэмцэх тухайн орны эрх бүхий байгууллагуудын буюу голдуу прокурор, хууль сахиулах байгууллагуудын мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн албан бус сүлжээ юм.

АРИН-АП нь Камден хөрөнгө буцаах байгууллагуудын сүлжээ /Camden Assets Recovery Interagency Network (CARIN)/ байгуулагдсаны дараа түүний нэг адил загварчлалаар байгуулагдсан бөгөөд Нарийн бичгийн дарга нарын газар нь БНСУ-ын Дээд Прокурорын газарт байдаг.¹¹⁸

АРИН-АП нь зөвхөн бүс нутгийн орнуудаар хязгаарлагдахгүйгээр бусад байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд дараах олон улсын байгууллагууд ажиглагчийн статустайгаар хамтран ажилладаг. АРИН-АП байгууллагаар дамжуулан

115 “Хөрөнгө буцаах ажиллагааны тухай гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж”, 2021, <https://star.worldbank.org/publications/asset-recovery-handbook-guide-practitioners-second-edition>

116 <https://star.worldbank.org/about-star>

117 <http://www.arin-ap.org/about/mission>

118 https://en.wikipedia.org/wiki/Asset_Recovery_Interagency_Network_Asia_Pacific

бусад бүс нутгийн албан бус сүлжээ болох ARIN-CARIB, ARINSA, ARIN-WCA, Camden Assets Recovery Interagency Network (CARIN) зэргээс гадна Интерпол, Дэлхийн банк, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албатай хамтран ажиллах боломжтой.

АРИН-АП-ын гишүүн орнууд нь тухайн орны эрх бүхий байгууллагуудын “харилцах хүн”-ээр дамжуулан харилцдаг бөгөөд тэдгээр хүмүүсийн мэдээллийг АРИН-АП-ын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлдэг. “Харилцах хүн” нь бусад гишүүн орнуудтай харилцах бол заавал Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан харилцана. Удирдах зөвлөлийн 15 улсын бүрэлдэхүүнд Монгол Улс багтдаг бөгөөд үүнд Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газраас тус бүр 1, нийт 3 “харилцах хүн/contact point” бүртгэлтэй ажиллаж байна.

в/ Хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай зохион байгуулахад олон улсын түвшинд энэ талаар дагнан үйл ажиллагаа явуулж байгаа сүлжээ, байгууллагуудтай хамтран ажиллаж, тухайн хөрөнгийг буцаан авах ажиллагаатай холбоотойгоор улс төрийн болон нийтийн дунд хэлэлцүүлэх, техникийн туслалцаа авах, судалгаа хийх, мэдээлэл солилцох, хөгжиж байгаа орнуудын хувьд чадавхыг бэхжүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах боломжтой. Тухайлбал,

- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба/United Nations Office on Drugs and Crime (UNODC)
- Хөрөнгө буцаах олон улсын төв/International Centre for Asset Recovery (ICAR)
- Хөрөнгө буцаах олон улсын холбоо/The International Association for Asset Recovery (IAAR)
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/Organization for Economic Co-operation and Development (OECD)
- Транспаренси Интернэшнл/Transparency International (TI)
- Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага/Financial Action Task Force (FATF)
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага/Organization for Security and Co-operation in Europe (OSCE)
- Авлигын эсрэг U4 төв/U4 Anti-Corruption Resource Center[19] (U4)
- Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын гишүүн орнуудын чуулган/UNCAC Conference of States Parties[20] (UNCAC COSP)

г/ Олон Улсын Прокуроруудын Холбоо /IAP/ нь 1995 онд байгуулагдсан, 177 орны прокурорын байгууллага гишүүнчлэлтэй байдгийн нэг нь Монгол Улсын прокурорын байгууллага юм. Уг холбоогоор дамжуулан прокурорууд олон улсын эрүүгийн эрх зүйн салбарт шинэ тутам гарч буй мэдээ, мэдээллийг шуурхай солилцох, бусад улсын прокурорын байгууллагатай харилцан уулзалт зохион байгуулах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, прокурорын чадавхыг бэхжүүлэх зэрэг чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулах боломжтой.¹¹⁹

119 Улсын ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн 2023 оны тайлан.

д/ Зүүн Өмнөд Азийн хуулийн байгууллагуудын албан бус сүлжээ-“SEAJust network”/South East Asia Justice Network/ нь эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудал хариуцсан эрх бүхий төв байгууллагууд шууд холбоо тогтоон хамтран ажиллах, техникийн туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагааг дэмжих зорилготой 2020 онд байгуулагдсан.

Монгол Улсын ерөнхий прокурорын газар 2023 онд SEAJust сүлжээнд нэгдэн орсон. Уг сүлжээгээр дамжуулан НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас байгуулагдсан бусад бүс нутгийн эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх эрх бүхий байгууллагуудын сүлжээ болох Баруун Африкийн эрх бүхий төв байгууллага, прокуроруудын сүлжээ /WACAP/, Төв Ази, Өмнөд Кавказын хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааны сүлжээ /CASC/, Европын Холбооны Эрүүгийн хэргийн хамтын ажиллагааны агентлаг/EUROJUST/, Дэлхийн авлигатай тэмцэх хууль сахиулах байгууллагуудын сүлжээ /GLOBE NETWORK/-ний гишүүн орнуудын эрх бүхий байгууллагуудтай харилцах, харилцан мэдээлэл солилцох боломжтой болсон.¹²⁰

2.3.Хөрөнгө буцаах ажиллагааны төрлүүд

2.3.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хөрөнгө буцаах

Хөрөнгө буцаах ажиллагааг хийхэд улс орнууд хамгийн өргөн хүрээнд хамтран ажиллаж, боломжит бүхий л дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Авлигын эсрэг конвенцын 5 дугаар бүлэг /Хөрөнгө буцаах/-ийн 51 дүгээр зүйлд¹²¹ тусган өгсөн талаар өмнө дурдсан. Өөрөөр хэлбэл, энэхүү ажиллагааг эрүүгийн процессыг ашиглан явуулах нь хөрөнгө буцаан авах ажиллагаа хийгдэх зөвхөн нэг боломжит хувилбар юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас¹²²

37.2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

37.3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын дотоодын хууль тогтоомжид тусгагдсан байдлыг авч үзэхэд, эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцааны хүсэлт бичих замаар гадаад улсад байршуулсан хууль бус хөрөнгийг буцаан авах боломжтой байна. Үүний тулд тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн тогтоол гарсан байх, уг шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасны дагуу “гүйцэтгэх хуудас” бичигдсэн байх шаардлагатай.

Түүнчлэн прокурор иргэний нэхэмжлэл бичих замаар тухайн хөрөнгийг буцаан авах эрх зүйн боломжтой байна. Тодруулбал, гэмт хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг

120 Мөн тэнд.

121 Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532179926501&showType=1>

122 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/12694>

конвенцын 53 дугаар зүйл, 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3, Прокурорын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.5 дугаар зүйлийн 6, 34.7 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн прокурор гадаад улсын шүүхэд нэхэмжлэл гаргах, түүнтэй холбоотойгоор эрх зүйн туслалцааны хүсэлт бичих замаар гадаад улсад хууль бусаар байршуулсан хөрөнгийг хураан авах, битүүмжлэх, улсын орлого болгох ажиллагааг хийлгэж болно.

Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын заалтаас

53 дугаар зүйл, 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3.

Прокурорын тухай хуулиас

41 дүгээр зүйл. Прокурорын нэхэмжлэл, тайлбар, гомдол

Эрүүгийн хуулиас

2.5 дугаар зүйл. Гэмт хэргийн хохирол, хор уршиг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас

34.7 дугаар зүйл. Прокурор шүүх хуралдаанд оролцох

Монгол Улс Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц, Авлигын эсрэг конвенц зэрэг НҮБ-ын олон талт олон улсын гэрээний гишүүн орон бөгөөд тэдгээрийг хөрөнгө буцаах ажиллагааны явцад үндэсний хууль тогтоомжийн нэг адил эрх зүйн үндэслэл болгон хэрэглэнэ.¹²³

2.3.2 Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хөрөнгө буцаан авах

Хөрөнгө буцаах ажиллагааг хийхэд хамгийн өргөн хүрээнд хамтран ажиллаж, боломжит бүхий л дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Авлигын эсрэг конвенцын 5 дугаар бүлэг /Хөрөнгө буцаах/-ийн 51 дүгээр зүйлээр¹²⁴ гишүүн орнуудад үүрэг болгосон байна.

Хөрөнгө буцаах ажиллагааг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд явуулах замыг дараах тохиолдлуудад сонгож болно. Үүнд: эрүүгийн хэрэгт шийтгэх тогтоол гаргуулах боломжгүй тохиолдол, шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураан авах тохиолдол, эсхүл хөрөнгө хураах тухай тогтоолыг биелүүлэхэд эрх зүйн харилцан туслалцаа хүсэх тохиолдол орно.¹²⁵

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хөрөнгө буцаах ажиллагаа гүйцэтгэхэд давуу болон сул талуудтай бөгөөд нэхэмжлэлийн шаардлага, бүрдүүлбэр, нотлох баримт, хэргийг хэлэлцэх процесс, нууцлалыг хангах, хөрөнгийн

123 Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль, 2016, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12340>

124 Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532179926501&showType=1>

125 “Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020.

хамгаалалт, өмгөөлөгч хөлслөх зэрэг үйл ажиллагаанд шаардагдах зардлын талаар тухайн орны холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, журмыг нарийвчлан судлах шаардлага үүснэ.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас

17 дугаар зүйл. Хоорондоо холбоотой хэд хэдэн хэргийн шүүхийн харьяалал

17.1. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс үүссэн хохирлын талаарх нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэнэ.

17.2. Хэрэв эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлээгүй бол уг нэхэмжлэлийг хуульд заасан журам, харьяаллын дагуу гаргана.

17.3. Эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхтэй холбогдсон маргааныг эрүүгийн хэрэг нь шийдвэрлэгдээгүй байхад иргэний журмаар хэлэлцэхгүй.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд гадаад улсаас ирүүлсэн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт болон шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд олон улсын олон талт гэрээ, улсууд хоорондын хоёр талт гэрээнүүд хэрэглэгддэг.

Энэ хүрээнд хэрэглэгддэг олон талт гэрээг дурдвал,

- Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлаас баталсан Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай 1954 оны конвенц,
- Шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийн гадаад гардуулан өгөх тухай 1970 оны конвенц,
- Гадаадад нотлох баримт цуглуулах тухай 1980 оны конвенц,
- Иргэний болон худалдааны асуудлаарх гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх тухай 2019 оны конвенц,
- Гадаад орны албан баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай 1961 оны конвенц

Монгол Улс одоогоор Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц болон Гадаад орны албан баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенцод нэгдэж орсон бөгөөд 18 улстай иргэний хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хоёр талт гэрээ байгуулсан.

Хоёр улсын хооронд байгуулсан гэрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүрээг хязгаарыг харилцан адилгүй тусгасан байдаг ч туслалцаа хүсэх, үзүүлэх үндсэн хэлбэр нь шүүхийн болон шүүхийн бус баримт бичиг гардуулан өгөх (нэхэмжлэл, тов мэдэгдэх хуудас, захирамж гэх мэт), нотлох баримт (баримт сэлт гаргуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээчийн дүгнэлт гаргуулах гэх мэт) цуглуулах, шүүхийн шийдвэрийн хүлээн зөвшөөрч биелүүлэх гэсэн хэлбэрээр харилцан туслалцаа үзүүлэхээр тусгасан байна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенцод шүүхийн болон шүүхийн бус баримт бичиг гардуулах, нотлох баримт цуглуулахтай холбоотой шүүхийн даалгавар

гүйцэтгэх, шүүхийн зардал төлүүлэх, үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлэх хэмжээнд эрх зүйн туслалцааны хүрээг тодорхойлсон байна. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгүй, иргэний хэрэг хянан шийдвэрлэх конвенцод нэгдэн ороогүй улсаас эрх туслалцаа хүсэх, тухайн орноос ирүүлсэн хүсэлт шийдвэрлэхэд талууд харилцан тохиролцох байдлаар эрх зүйн туслалцааны хүрээг тодорхойлох боломжтой.¹²⁶

Иргэний хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт буюу шүүхийн даалгавар нь бүхэлдээ, хүсэлт гаргагч шүүхээс, хүсэлт хүлээн авагч шүүхэд чухам ямар асуудлаар туслалцаа хүсэж байгааг илэрхийлэх гол эх сурвалж болох тул агуулга, хэлбэрийн хувьд гэрээнд заасан шаардлагыг хангасан, дагалдах материалыг бүрэн бүрдүүлсэн, хүсэж буй эрх зүйн туслалцааг тодорхой илэрхийлсэн, шаардагдах мэдээллийг бүрэн тусгасан байх шаардлагатайг анхаарах хэрэгтэй.

2.4. Хөрөнгийн менежмент, түүний хамгаалалт

2.4.1. Хөрөнгийн менежментийн талаарх ойлголт, хэлбэр, анхаарах асуудал

Гэмт хэргийн замаар бий болсон хууль бус хөрөнгийг битүүмжлэх, хураан авах эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан үеэс тухайн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, засвар үйлчилгээ зэрэг асуудлууд үүсдэг бөгөөд тэдгээрийг удирдан зохион байгуулах ажиллагааг бүхэлдээ хөрөнгийн менежмент гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл, тухайн хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулахгүйгээр шүүхийн шийдвэр эцэслэн гарах хүртэл хадгалж, хохирогчийн хохирлыг барагдуулах, нөхөн төлөх, хуваарилах, зарцуулах зэрэг зорилгод чиглэгдсэн үйл ажиллагаа нь хөрөнгийн менежмент юм.

Гэмт хэргийн замаар олж авсан бэлэн ба бэлэн бус мөнгө, хөдлөх үл хөдлөх хөрөнгө, үнэт эдлэл, хувьцаа, бизнес зэрэг хөрөнгийг үнэлэх, хадгалж хамгаалах, худалдан борлуулах талаарх менежменттэй холбогдох асуудлууд нь улс орнуудын хувьд, захиргаа, эрүү, иргэний процессын болон эрүү-иргэний холимог журмын дагуу шүүх, прокурор, мөрдөгч, хөрөнгийн менежер нарын удирдлага дор хийгдэж байна.

Шүүхээс гаргасан хураан авах шийдвэрийн дагуу уг хөрөнгөд хяналт тавих эрх үүрэг олгох тохиолдолд тухайн алба (эсхүл менежер) шаардлагатай чиг үүргийг хэрэгжүүлэх хууль ёсны эрх мэдэлтэй байх ёстой. Ерөнхийдөө, эдгээр эрх мэдлийг хөрөнгийг хураан авах асуудлыг зохицуулсан хууль, эсхүл хөрөнгийн удирдлагын болон мөнгө угаахтай тэмцэх тухай хууль тогтоомжид тусгагдсаны дагуу шүүхийн шийдвэрээр олгодог бөгөөд дараах хэлбэрээр хэрэгжих боломжтой.¹²⁷ Үүнд:

- Хөрөнгийн удирдлагыг эрх бүхий хувь хүн, аж ахуйн нэгжид шилжүүлэх, даалгах,
- Хөрөнгийг удирдахтай холбоотой өдөр тутмын шийдвэрийг гаргахаас гадна хөрөнгийг хязгаарлах, хураан авах, удирдахтай холбоотой гарсан шаардлагатай бүх зардлыг төлөх, зарцуулах,

¹²⁶ Иргэний хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гарын авлага, 2020, Улаанбаатар.

¹²⁷ Хөрөнгө буцаах ажиллагааны гарын авлага: Салбарын мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж, Хоёр дахь хэвлэл, Жан-Пьер Бран нар, 2020.

- Хувьцаа, үнэт цаас, бусад хөрөнгө оруулалтын хэлбэртэй байгаа хураан авсан эсвэл хязгаарласан хөрөнгийг худалдах,
- Хяналтад байгаа хөрөнгийг даатгуулах,
- Бизнесийн үйл ажиллагааны хүрээнд хүмүүсийг ажилдавах (ажлаас чөлөөлөх), шаардлагатай тохиолдолд бизнесийн менежер хөлсөлж ажиллуулах, бизнесийн үйл ажиллагааг зохистой удирдаж явуулахад шаардлагатай шийдвэрүүдийг гаргах зэргээр үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,
- Компанийн хувьцаанаас бүрдсэн хөрөнгийн хувьд хөрөнгийн менежер нь хувьцааны бүртгэлтэй эзэмшигчийн хувиар тухайн хувьцаатай холбоотой саналын болон бусад эрхийг хэрэгжүүлэх,
- Тодорхой журам, хуваарь эсвэл шүүхийн шийдвэрийн дагуу дэлгэрэнгүй тодруулга хийх, заавал аудитад хамруулах шаардлагын хүрээнд хөрөнгийн менежер болон хөрөнгийг удирдахад оролцсон хүмүүст нөхөн төлбөр олгох.

Хөрөнгийн менежментийг хийхэд анхаарах нийтлэг асуудал¹²⁸ нь:

- Гэмт хэргийн улмаас ямар хөрөнгө, орлого бий болсныг тогтоох
- Тухайн тогтоогдсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх, хураан авах, хадгалж хамгаалах, хохирол худалдан борлуулах, буцаан авчрах, олгох зэргээр ямар процесс ажиллагаа хийх, түүнийг захиргаа, эрүү, иргэний ямар журмаар хэрэгжүүлбэл амжилттай шийдвэрлэгдэх боломжтой болохыг тодорхойлох.
- Процесс ажиллагаанд оролцох эрх бүхий этгээдүүдийг тогтоон, үүрэг хариуцлагыг тодорхой болгох.
- Дээрх процесс ажиллагааг хэрэгжүүлэхэд үндэсний болон олон улсын ямар эрх зүйн орчин байгааг тодорхойлох.
- Уг ажиллагаанд гарах зардлыг тооцоолж, хэн хариуцахыг тооцоолох.
- Хөрөнгийг олж тогтоох, хадгалж хамгаалахтай холбоотой гарсан зардлыг хөрөнгө буцаан олгох үед суутгах эрх зүйн боломжтой эсэх зэрэг байна.

2.4.2. Хөрөнгийн менежментийн талаарх үндэсний эрх зүйн орчин, практик хэрэглээ

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөрдөгч нь:

- Прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах;
- Мөрдөгч эд зүйл, баримт бичиг хураан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулна.

128 Олон улсын Хурлын материал, Asset Recovery Interagency Network – Asia Pacific (ARIN-AP), 7-9 May 2018 Yogyakarta, Indonesia.

ЭХХШТХ 26.1 дүгээр зүйл.Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах

1.Мөрдөгч гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр дараах ажиллагаа явуулна:

1.1.үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах;

/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

1.2.үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах.

/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

2.Энэ зүйлийн 1.1-д заасан ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулж болно.

Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээг Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Хорин нэгдүгээр бүлгээр тусгайлан зохицуулсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтаас

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХУРААН АВСАН ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЭД МӨРИЙН БАРИМТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

21.1 дүгээр зүйл.Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах

21.2 дугаар зүйл.Эд хөрөнгө битүүмжлэх

21.3 дугаар зүйл.Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах хугацаа

21.4 дүгээр зүйл.Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүргүүлэх

21.5 дугаар зүйл.Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шийдвэрлэх

Мөн хуулийн 21.5 дугаар зүйлийн 6-д “Хавтаст хэргийн материал, хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх, хууль ёсны эзэмшигчид нь буцаан олгох, улсын орлого болгох болон энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4-т заасан ажиллагааны журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор хамтран батална” гэж заасны дагуу дараах журам батлагдан хэрэгжиж байна.

- “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам” тус тус Улсын Дээд Шүүх, Улсын ерөнхий прокурорын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан 246, А/80 дугаартай тушаалаар батлагдсан.
- “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хадгалах хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”, “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын бүртгэлийн загвар” тус тус Улсын ерөнхий прокурорын тушаал 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/69 дугаартай тушаалаар батлагдсан.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт”¹²⁹

Зөвлөмж 38 /Эрх зүйн харилцан туслалцаа: Хөрөнгө царцаах, хураах/

“Улс орнууд мөнгө угаасан өмч хөрөнгө, мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс үүдэлтэй орлого, гэмт хэрэгт ашигласан буюу ашиглахаар завдсан хэрэгсэл, дүйцэх дүнтэй өмч хөрөнгийг илрүүлэх, царцаах, битүүмжлэх, хураан авах, гаднаас ирсэн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх эрх бүхий байгууллагатай байвал зохино. Үүнд бусад улс орноос эрүүгийн шийтгэлгүй хөрөнгө хураах /non conviction based/-аар тавьсан хүсэлтийг дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлаагүй тохиолдолд хэрэгжүүлэх орно.

Ийм хөрөнгө, хэрэгсэл, дүйцэхүйц үнэтэй өмчийг битүүмжлэх, хураан авах зорилгоор үйл ажиллагааг чиглүүлэх, удирдах, хураасан хөрөнгийг хуваарилах үр дүнтэй тогтолцоотой байвал зохино”

Монгол Улсын шүүхээр шийдвэрлэгдсэн бөгөөд хөрөнгө буцаах ажиллагаа амжилттай зохион байгуулагдсан эрүүгийн хэргийн жишээн дээр тухайн хөрөнгийг хэрхэн удирдсан талаар олон улсын сурах бичигт тусгагдсаныг энд орчуулан тусгав.¹³⁰

129 <https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/20180531F2.pdf>

130 Managing Seized and Confiscated Assets, A guide for practitioners, Lisa Bostwick, Nigel Bartlett, Hermione Cronje, T.J.Abernathy III, 2023, p148, <https://star.worldbank.org/publications/managing-seized-and-confiscated-assets-guide-practitioners>

Авлигатай тэмцэх газраас 2019 онд Монгол Улсын иргэн Г, Д нарт холбогдох хэргийг шалгаж эхэлсэн. Г, Д нар нь төрийн өмчит үйлдвэрийн газар /ТӨҮГ/-т ажиллаж байсан албан тушаалтнууд бөгөөд тэднийг албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, мөнгө угаах гэмт хэрэгт холбогдуулан шалгасан.

Албан болон албан бус хамтын ажиллагааны сувгийг ашиглан хамтран ажилласнаар Д нь хууль бусаар гэрээ байгуулсан, хахууль авсныг, Г нь оффшор дансаар дамжуулан мөнгө шилжүүлсэн нь тогтоогдсон. Тэрээр 570,000 фунт стерлингийн үнэ бүхий Их Британи дахь 110 метр квадрат талбайтай үл хөдлөх хөрөнгө худалдан авсан байна. Г нь мөнгө угаасан, албан тушаалаа урвуулан ашигласан хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн бол Д-г мөн адил гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь тогтоогдсон. Г-тэй хийсэн гэм буруугийн тохиролцооны хүрээнд шүүгдэгч нарын ажиллаж байсан ТӨҮГ-т Их Британи дахь өмчийг шилжүүлэх замаар Монгол Улсад хөрөнгийг буцаан олгохоор шийдвэрлэгдсэн.

Сангийн яамаар ахлуулсан АТГ, прокурор болон бусад яамдыг оролцуулсан ажлын хэсэг уг өмчийг түрээслүүлж, орлогыг нь бүтэн өнчин хүүхдийн төвд хүмүүжиж байгаа хүүхдүүдийн боловсролд зарцуулахаар шийдвэрлэсэн байна. ТӨҮГ -нь түрээслүүлсэн үл хөдлөх хөрөнгийн асуудлыг мэргэжлийн хөрөнгийн компаниар удирдуулахаар гэрээ байгуулсан боловч өмчлөлийг шилжүүлэх; улсын болон орон нутгийн, мөн зөвлөлийн гэх мэт татвар төлөх; машины зогсоол; үл хөдлөх хөрөнгө; үл хөдлөх хөрөнгийн нөөцийн сан; нягтлан бодох бүртгэл; ашиглалтын төлбөр, түүнчлэн түрээсийн зуучлалын үйлчилгээний төлбөр – зэрэг хоёр жилийн хугацаанд гаргасан зардлууд нь хэт их буюу жилд орсон түрээсийн орлого ойролцоогоор 60,000 фунт стерлингээсээ хэтэрсэн байна. Үл хөдлөх хөрөнгийн менежерүүдтэй харилцахад бэрхшээлтэй, зах зээлийн ирээдүйн үнэ тодорхойгүй, үл хөдлөх хөрөнгийн засвар хийх хэрэгцээ зэрэг сөрөг үр нөлөөтэй байдал нь ТӨҮГ-ыг худалдан борлуулахад хүргэсэн. Уг борлуулалтаас олсон мөнгийг асрамжийн газрын үйл ажиллагааг дэмжихэд шууд зарцуулахаар болсон байна.

Дээрх гэмт хэргийг үйлдсэн Г, Д нарт шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 1 болон 22.1 дүгээр зүйлийн 2-д заасны дагуу тус тус ял оногдуулсан бөгөөд Г-г дээрхээс гадна Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 6-д заасны дагуу шийтгэсэн байна. Гэмт хэрэг үйлдэх замаар гадаад улсад байршуулсан 1,5 сая ам.доллар буюу 4 тэрбум төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Монгол Улс буцаан авсан.¹³¹

131 <https://www.24tsag.mn/a/197084>

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАДААД УЛСААС ЦАХИМ НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ АЖИЛЛАГАА

3.1. Цахим нотлох баримтын талаар ерөнхий ойлголт

Өнөө үед шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжихийн зэрэгцээ мэдээлэл дамжуулах арга техник улам сайжирч байна. Гэмт хэрэг үйлдэхэд хамгийн сүүлийн үеийн технологиуд ашиглагдаж байгаа нь тэдгээрийг илрүүлэх, мөрдөн шалгах шинэ арга замыг шаардаж байгаа бөгөөд энэ үйл явц нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт цахим нотлох баримт гэх ойлголтыг бий болгосон¹³².

Энэхүү бүлэгт цахим нотлох баримт гэх ойлголтод уламжлалт нотлох баримт (бичгийн болон эд мөрийн баримт)-ыг бэхжүүлэх цахим арга хэрэгсэл болон цахим хэлбэрээр оршиж буй мэдээллийг хамааруулан эдгээр ойлголттой холбоотой нийтлэг зохицуулалт, тэдгээрийг гадаад улсад цуглуулах боломжуудын талаар тусгасан болно.

Уламжлалт нотлох баримттай холбоотой мэдээллийг бэхжүүлэх цахим арга хэрэгсэл болон цахим хэлбэрээр оршиж буй нотлох баримт гэсэн ойлголтуудыг ялгаж ойлгох нь зүйтэй.

Цахим арга хэрэгслээр бэхжүүлсэн нотлох баримт нь орчин үеийн техник хэрэгслээр уламжлалт гэмт хэргийн далд ул мөрийг илрүүлэх бичлэг эсхүл мөрдөн шалгах ажиллагааны үед хийсэн гэрэл зураг, дуу, видео бичлэг нь дижитал (тоон) зөөвөрлөгч дээр (hard disk, flash disk) хадгалагдсан тодорхой дижитал файл хэлбэртэй мэдээлэл юм. Зарим улсад хэрэгт холбогдох этгээдийн мэдүүлэг, мөрдөн шалгах болон шүүхийн бусад ажиллагааны явцад олж авсан мэдээллийг цахим тэмдэглэл хөтөлж, ерөнхийд нь цахим хэлбэрээр бэхжүүлэх, эрүүгийн хэргийг бүхэлд нь цахим хэлбэрээр хөтлөх аргад бүрэн болон хэсэгчлэн шилжсэн (тухайлбал: Америкийн Нэгдсэн Улс, Европын зарим улс)¹³³.

Харин цахим хэлбэрээр оршиж буй нотлох баримт нь “шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үйл баримтыг нотлох, үгүйсгэхэд хэрэг болохуйц цахим хэлбэрээр үүсгэсэн, хадгалсан, дамжуулсан аливаа мэдээлэл” юм¹³⁴. Үүнд цахим төхөөрөмжөөс (компьютерын хатуу диск эсхүл гар утас гэх мэт), шууд интернэт сүлжээнээс (цахим шуудангийн хаяг эсхүл үүлэн хадгалах хаягаас алсаас авсан мэдээлэл гэх мэт), эсхүл цахим мэдээлэл хадгалах үйлчилгээ эрхлэгчээс¹³⁵ авсан мэдээлэл багтаж болно¹³⁶.

Цахим нотлох баримт гэдэгт өргөн утгаараа тухайн хэрэгт ач холбогдол бүхий хуульд заасан арга, хэрэгслээр олж авсан цахим төхөөрөмж, хэрэгсэлд хадгалагдаж

132 PILON Mutual Legal Assistance Handbook: Cybercrime & Electronic Evidence

133 Мөн тэнд.

134 CoE Electronic Evidence Guide, 2020, p12

135 интернэтийн үйлчилгээ эрхлэгч, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, суурин холбооны үйлчилгээ эрхлэгч /цаашид “үйлчилгээ эрхлэгч” гэх/ болон контентын үйлчилгээ эрхлэгч нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

136 PILON Mutual Legal Assistance Handbook: Cybercrime & Electronic Evidence

буй цахим баримт, мэдээлэл, харин явцуу утгаараа гэмт хэрэг хэрхэн үйлдэгдсэнийг компьютер ашиглан батлах, эсвэл няцаах, тухайн гэмт хэрэг нь санаатайгаар үйлдэгдсэн, эсвэл хэрэгт холбогдолгүй болохыг батлах хадгалагдаж, эсхүл дамжуулж буй аливаа өгөгдлийг” ойлгоно¹³⁷.

Цахим нотлох баримт гэсэн ойлголт нь цахим гэмт хэргийн ойлголттой салшгүй холбоотой бөгөөд цахим гэмт хэргийн талаар олон тодорхойлолт байдаг. Компьютер болон цахим сүлжээ ашиглаж бусдын эд хөрөнгө, алдар нэр, хувийн нууц, аюулгүй байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд нь хууль бусаар халдаж буй өөр өөр төрлийн гэмт хэргийн нийлбэр гэж энгийнээр тайлбарлаж болно¹³⁸. Мөн цахим гэмт хэрэг гэж компьютерын технологийг гэмт хэргийн үйл ажиллагааны хэрэгсэл, бай, туслах хэрэгсэл болгон ашигладаг өргөн хүрээний үйлдлийг агуулсан гэмт хэргийн үйл ажиллагаа гэж тодорхойлсон байдаг¹³⁹.

Цахим гэмт хэргийг өргөн хүрээнд хоёр төрөлд хувааж болно:

- уламжлалт гэмт хэрэг үйлдэх боломжийг бүрдүүлэхийн тулд цахим технологийг ашиглан үйлдсэн гэмт хэрэг;
- зөвхөн цахим технологийн тусламжтайгаар үйлдэх боломжтой гэмт хэрэг¹⁴⁰.

Цахим технологи ашиглан үйлдэх гэмт хэрэг нь интернэт болон мэдээллийн технологийг хүч нэмэгдүүлэгч болгон ашигладаг. Эдгээр гэмт хэрэгт компьютер, компьютерын сүлжээ эсхүл бусад мэдээллийн технологийг хэрэглэж хохирогчдын цар хүрээ, тоог нэмэгдүүлэх зорилгоор интернэтийг ашигладаг. Технологи хэрэглэн үйлдэх гэмт хэргийн жишээнд залилан, хулгай, бэлгийн мөлжлөг гэх мэт гэмт хэрэг багтана¹⁴¹.

Харин зөвхөн цахим технологийн тусламжтайгаар үйлдэх боломжтой гэмт хэрэг нь компьютер, мэдээллийн системийн эсрэг гэмт хэрэг бөгөөд зорилго нь төхөөрөмжид зөвшөөрөлгүй нэвтрэх эсхүл хууль ёсны хэрэглэгч нэвтрэхэд саад учруулах зорилготой (ихэвчлэн WannaCry, Industroyer гэх зэрэг хорлох ажиллагааны программ хангамжтай). Мөн гэмт хэргийн зорилгоор цахим мэдээлэл, хэрэгсэлд гэмтэл учруулдаг, хорлох ажиллагаатай программыг үйлдвэрлэх, түгээх зорилготой байдаг (Botnets and Phishing)¹⁴².

Цахим нотлох баримт нь хүний хувийн мэдээллийг агуулж байдаг тул “мэдээлэлд нэвтрэх үйл ажиллагаа нь тухайн мэдээллийг хайж олох зорилгодоо нийцсэн байх” зарчим баримтлах шаардлагатай. Уг зарчмын дагуу мөрдөн шалгах ажиллагаанд нэг талаас “хувийн халдашгүй байдлыг хангах” буюу хүний хувийн мэдээллийг хамгаалах, нөгөө талаас “нийгмийн аюулгүй байдлыг хангах” буюу гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн

137 Л.Галбаатар. Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь. УБ., 2015, 26 дахь тал

138 <https://gia.gov.mn/49/item/643>

139 PILON Mutual Legal Assistance Handbook: Cybercrime & Electronic Evidence

140 Мөн тэнд.

141 Мөн тэнд.

142 Мөн тэнд.

шалгах, үндэсний аюулгүй байдлыг хангах гэсэн хоёр ашиг сонирхлыг харилцан тэнцвэртэй байдлыг нь хангана¹⁴³.

Тухайн нотлох баримтад хандах эрхийн зохицуулалт улс орон бүрд харилцан адилгүй байдаг хэдий ч хүний хувийн халдашгүй байдалд халдах болон түүнийг хадгалах үйл ажиллагааны түвшинд үндэслэн цахим нотлох баримтыг төрлүүдэд ангилж болно¹⁴⁴.

Цахим мэдээллийг контентын өгөгдөл (Content data) болон контентын бус өгөгдөл (Non-content data) гэж ангилж болно¹⁴⁵.

Контентын бус өгөгдөлд мэдээлэл хэнээс хэнд илгээгдсэн, мэдээлэл дамжуулсан цаг, дамжуулсан мэдээллийн үргэлжилсэн хугацаа, хэмжээ зэрэг харилцаа холбооны мэдээлэл орно. Контентын бус өгөгдөлд хэрэглэгчийн нэр, хаяг, төлбөрийн нэхэмжлэлийн мэдээлэл зэрэг хэрэглэгчийн мэдээлэл болон цахим хаяг, IP хаяг зэрэг хэрэглэгчийг таних мэдээлэл орно (Subscriber information, Traffic data).

Контентын¹⁴⁶ өгөгдөлд харилцаа холбоогоор дамжсан агуулга, эсхүл дамжуулж буй мэдээллийн агуулгыг харуулах мэдээлэл буюу и-мэйл, нийтлэл, сэтгэгдэл, хаягийн дэвтэр, гэрэл зургийн хадгалагдсан мэдээлэл орно.

Цахим нотлох баримтыг мөн хадгалагдсан мэдээлэл (Stored e-evidence) болон одоо цагт цуглуулж авах мэдээлэл (Real-time collection of e-evidence) гэж ангилж болно¹⁴⁷.

Хадгалагдсан мэдээлэл (Stored e-evidence)

Хэрэглэгчийн мэдээлэл (Basic subscriber information)	Тодорхой үйлчилгээ авч буй хэрэглэгчийг тодорхойлоход ач холбогдолтой мэдээлэл. Хэрэглэгч бүртгүүлэх болон түүнд тодорхой үйлчилгээ үзүүлэх үед цуглуулсан мэдээлэл байна ¹⁴⁸ . Тухайлбал: хэрэглэгчийн нэр, хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар, тодорхой үйлчилгээ болон IP хаягийг анхны нэвтрэлтээс хойш хэдий хугацаанд хэрэглэсэн тухай мэдээлэл.
--	--

143 Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа, Нээлттэй нийгэм форум, 2022

144 Мөн тэнд.

145 PILON Mutual Legal Assistance Handbook: Cybercrime & Electronic Evidence

146 Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь хэсэгт зааснаар “Контент” гэж харилцаа холбооны сүлжээгээр дамжиж байгаа үг, дуу, тэдэг, дохио, текст, зураг, график, хөдөлгөөнт дүрс бүхий бүх төрлийн мэдээ, мэдээллийн электрон хэлбэрт хувиргасныг” ойлгоно.

<https://legalinfo.mn/mn/detail/15067>

147 UNODC guide (vii) UNODC Practical Guide for Requesting Electronic Evidence Across Borders, 2019

148 Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа, Нээлттэй нийгэм форум, 2022

Хандалт/хөдөлгөөн/ шилжүүлгийн өгөгдөл - Контентын бус өгөгдөл (Traffic data - non-content data)	Хэрэглэгч хоорондын харилцсан мэдээлэл, холбоос, газар зүйн байршлын мэдээлэл, тодорхой үйлчилгээнд авсан мэдээлэл, харилцааны үүсэл, үргэлжилсэн хугацаа, огнооны талаарх мэдээлэл (Metadata); Хандалтын бүртгэл буюу үйлчилгээнд хандсан огноо, цаг, IP хаяг; Шилжүүлгийн бүртгэл буюу үйлчилгээ эрхлэгчээс эсхүл гуравдагч этгээдээс авсан бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлох мэдээлэл (Үүлэн хадгалах зай худалдаж авсан гэх мэт).
Контент өгөгдөл (Content data)	Цахим захидлын эх эсхүл хэсэг, мэссэж, блог эсхүл нийтлэл, видео, зураг, тоон форматаар хадгалагдсан дуу авиа (хэрэглэгчийн мэдээлэл болон мета өгөгдлөөс өөр)
Одоо цагт цуглуулж авах мэдээлэл (Real-time collection of e-evidence)	
Хандалтын өгөгдөл (Traffic data)	Хэрэглэгч хэнтэй, хаанаас холбогдож байгаа талаар олж авсан мэдээлэл (тухайлбал: тогтмол болон өөрчлөгдөж буй IP хаяг)
Контент өгөгдөл (Content data)	Цахим захидлын эх эсхүл хэсэг, мэссэж, блог эсхүл нийтлэл, видео, зураг, тоон форматаар хадгалагдсан дуу авиа (хэрэглэгчийн мэдээлэл болон мета-өгөгдлөөс өөр)-ны талаар олж авсан мэдээлэл

3.2. Цахим нотлох баримтын талаар эрх зүйн зохицуулалт

3.2.1. Дотоодын эрх зүйн орчин

Цахим нотлох баримтын тодорхойлолтыг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нарийвчлан заагаагүй боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээлэл гэж тодорхойлсон бөгөөд эд мөрийн баримтад цахим нотлох баримтыг тооцохоор заасан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас:¹⁴⁹

16.1 дүгээр зүйлд. Нотлох баримт

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.

16.4 дүгээр зүйл. Эд мөрийн баримт

1. Эд мөрийн баримтад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, уналга, зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, үнэ бүхий зүйл, бусад эд зүйлс, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан түүнчлэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг үгүйсгэх, эсхүл хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий бичмэл болон цахим баримт, бусад эд зүйлийг тооцно.

Монгол Улсын Дээд шүүхээс “Цахим төхөөрөмжид үүсгэсэн, боловсруулсан, хадгалсан, өөрчилсөн, илгээсэн, дамжуулсан, хүлээн авсан бүх хэлбэрийн мэдээлэл нь гэмт хэрэг үйлдэхэд, эсхүл гэмт хэрэгт бэлтгэх, завдахад ашигласан, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан тохиолдолд эд мөрийн баримт болно.” гэж тайлбарласан.¹⁵⁰

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар бүлэгт заасан үндэслэл, журмыг хангасан бөгөөд мөн хуулийн 42 дугаар бүлэгт заасан журмын дагуу гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцох боломжтой.

Өөрөөр хэлбэл, цахим нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, хураан авах зэрэг ажиллагаа нь бусад нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, хураан авахад баримталдаг ерөнхий журмаар явагдана гэж ойлгоно.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эд мөрийн баримт хураан авах тухай зохицуулалт цахим нотлох баримтын хувьд нэгэн адил хамаарна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас:

24.4 дүгээр зүйл. Эд мөрийн баримт хураан авах

9. Хэрэгт ач холбогдолтой цахим баримтыг хуулбарлан авах, эсхүл түүнийг устгах, нэвтрэх боломжийг хязгаарлах боломжгүй бол цахим төхөөрөмжийг хураан авч болно.

Уламжлалт нотлох баримттай холбоотой мэдээллийг бэхжүүлэх цахим арга хэрэгслийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 28.1 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааны явцад бичгээр тэмдэглэл үйлдэж бэхжүүлнэ. Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлийг

¹⁴⁹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

¹⁵⁰ Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар”-ын 5.2 https://www.supremecourt.mn/files/202311/0_1702965618.pdf

гараар бичиж эсхүл техник хэрэгслээр гаргаж мөрдөн шалгах ажиллагааны явцад хийгдсэн бүх гэрэл зураг, кино, видео материал, мэдүүлэг авалтын фонограмм, зураг, төлөвлөгөө, схем, мөрийн хэвлэмэл материал, түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны явцад бусад цахим хэрэгслээс хүлээн авсан буюу хуулбарласан мэдээллийн цахим хэрэгслийг тэмдэглэл үйлдэж эрүүгийн хэрэгт хавсаргана.

Үүнтэй нэгэн адилаар цахим мэдээлэл олж авах, ашиглах ижил төстэй журам эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад шүүхийн шатанд ч хэрэглэгдэнэ. Шүүх хуралдааны явцыг аудио бичлэг хийх, нотлох баримт болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад зорилгыг бүртгэх, судлахад цахим төхөөрөмж ашигласан бол хүлээн авсан бүх мэдээллийг тэмдэглэлд хавсарган зохих цахим мэдээллийн хэрэгслээр хадгална.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас:

11.7 дугаар зүйл. Шүүх хуралдааны тэмдэглэл

1.Энэ хуульд заасан шүүх хуралдааны явцыг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж, дууны, эсхүл дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулна.

Ийнхүү мөрдөн шалгах ажиллагааны явцад болон эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд шалгагдсан нотлох баримтын эх сурвалж нь мөрдөгчийн үйлдсэн болон шүүх хуралдааны явцад хөтөлсөн бичгийн тэмдэглэл хэвээр байна.

3.2.2. Гадаад улсуудын болон олон улсын эрх зүйн орчин

Гадаадын олон улсад цахим нотлох баримтыг практикт өргөнөөр хэрэглэж, эрүүгийн хэрэг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны практикт ашиглаж байгаа боловч цахим нотлох баримтын талаар тодорхойлолт Америкийн Нэгдсэн Улсын хууль тогтоомжид тусгагдсан байна. Бусад улсын хууль тогтоомжид энэхүү нэр томьёо хэрэглэгдэж байгаа боловч тухайлсан тодорхойлолт байхгүй байна¹⁵¹.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын хууль тогтоомжид цахим нотлох баримтын тухай ойлголтыг өргөн хүрээнд цахим хэлбэрээр хадгалагдаж, дамжуулагдсан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж болох мэдээлэл гэж тодорхойлсон¹⁵². Цахим нотлох баримтын гол шинж чанарт цахим хэлбэр, дамжуулалт болон хадгалалт орох бөгөөд цахим нотлох баримтад файл, дүрс бичлэгийн хуулбар, зураг, цахим хэлбэрийн ярианы аудио бичлэг, мэдээллийн хөдөлгөөний өгөгдлийн (traffic data) судалгаа болон цахим хэлбэрийн бусад мэдээллийг дурдаж болно. Цахим нотлох баримтыг контент буюу файл, регистр, бичвэр гэх мэт эх сурвалж, мета-өгөгдөл буюу контентын талаарх мэдээлэл гэж хуваадаг. Ийм мэдээллийг сайн дурын үндсэн

151 Замураева, И. О. Актуальные вопросы цифровизации уголовного судопроизводства и использования электронных доказательств в зарубежных странах. / И. О. Замураева // Молодой ученый. — 2022. — № 20 (415). — С. 286-289. — URL: <https://moluch.ru/archive/415/91616/> (дата обращения: 24.10.2023).

152 Сергеев М. С. Электронные доказательства в уголовном судопроизводстве. Опыт США / М. С. Сергеев // Вестник экономики, права и социологии. — 2016. — № 2. — х. 48-49.

дээр болон албадан эрэн сурвалжлах, шалгалт хийх, саатуулах замаар олж авахыг зөвшөөрдөг.

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ)-д цахим нотлох баримтын арай өөр зохицуулалттай. Цахим нотлох баримт бүрдүүлэх нь цагдаагийн алба хаагчийн бүрэн эрхэд хамаарах бөгөөд тэрээр нотлох баримтыг цахим хэлбэрээр бэхжүүлэх боломжоор хангагдсан байна. Өөрөөр хэлбэл хохирогч болон гэрчийн мэдүүлэг, үзлэгийн дүн, хэрэгт нотлох баримтын ач холбогдолтой бусад үр дүнг цахим төхөөрөмж, түүний дотор хөдөлгөөнт төхөөрөмж ашиглан бүртгэх бэхжүүлэх боломжтой байна. Үүний зэрэгцээ нотлох баримтыг бэхжүүлэхэд цаасан баримт ашигладаггүй, эрүүгийн хэргийг цахим хэлбэрээр үүсгэж, холбогдох ажиллагаа дууссаны дараа хэргийг шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлдэг байна¹⁵³.

Ром-Германы эрх зүйн тогтолцоотой улс орнуудад цахим нотлох баримтыг ашиглахад уламжлалт нотлох баримтад хэрэглэгддэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн заалтууд хамаарна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-д харилцаа холбооны хэрэгсэлд хяналт тавих, ярианы бичлэгийг сонсох замаар мэдээлэл олж авах, тэдгээрийг цааш нь судлах замаар нотлох баримт олж авах, бэхжүүлэх боломжтой. ХБНГУ-ын эрүүгийн процессын нэгэн сонирхолтой зохицуулалт байдаг нь гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэх шаардлагагүй хүмүүсийг тогтоох зорилгоор гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж буй этгээдийг тодорхойлж болох, мөрдөн шалгах ажиллагаанд чухал ач холбогдолтой шинж чанартай хүмүүсийн зарим хувийн мэдээллийг автомат таних системийг ашиглан автоматаар харьцуулах, дамжуулах боломжтой байдаг байна¹⁵⁴.

Бүгд Найрамдах Австри Улс мөн хиймэл оюун ухааны системд суурилсан автомат таних системийг ашигладаг бөгөөд энэ нь тандалтын мэдээллийн сан болон архивлагдсан эрүүгийн хэргийн мэдээллийн санг харьцуулдаг байна¹⁵⁵.

Швейцарын Холбооны Улсын хууль тогтоомж нь урьдчилсан мөрдөн шалгах шатанд дижитал технологийг өргөнөөр ашиглах боломжийг олгодог бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг бэхжүүлэх хэрэгсэл болгон видео бичлэг хийхийг зөвшөөрөхөөс гадна мэдүүлэг өгөх хүнтэй холбоо тогтоох, мэдүүлгийн үр дүнг бэхжүүлэх зорилгоор видео хурлын хэрэгсэл ашиглахыг зөвшөөрдөг¹⁵⁶.

153 Зайцев О. А. Особенности использования электронной информации в качестве доказательств по уголовному делу: сравнительно-правовой анализ зарубежного законодательства / О. А. Зайцев // Журнал зарубежного законодательства и сравнительного правоведения. — 2019. — № 4 (77). — с. 42–57.

154 Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн процессийн хуулийн 98а дугаар зүйл. https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html

155 IT Applications in the Austrian Justice System file: ///Users/user1/Downloads/IT%20Applications%20in%20the%20Austrian%20Justice%20System%20Stand%202007.09.2023.pdf

156 Замураева, И. О. Актуальные вопросы цифровизации уголовного судопроизводства и использования электронных доказательств в зарубежных странах. / И. О. Замураева // Молодой ученый. — 2022. — № 20 (415). — С. 286-289. — URL: <https://moluch.ru/archive/415/91616/> (дата обращения: 24.10.2023).

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад видео бичлэгийг мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг бэхжүүлэхэд хэрэг бөгөөд эрүүгийн процессын баримт бичгийг солилцох дижитал үүлэн мэдээллийн санг бий болгоход ашигладаг байна.

Бүгд Найрамдах Сингапур Улс (Сингапур)-ын хувьд Нотлох баримтын тухай хуульдаа “цахим бүртгэл гэж мэдээллийн системд цахим, соронзон, оптик болон бусад хэрэгслээр үүсгэсэн, мэдээлсэн, хүлээн авсан, хадгалсан, эсхүл нэг мэдээллийн системээс нөгөөд шилжүүлсэн бичлэгийг ойлгоно” гэж тодорхойлсон. Мөн аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарим тохиолдолд шууд видео, телевизийн шууд линкээр мэдүүлэг өгч болох бөгөөд “шууд видео эсхүл телевизийн шууд холбоос” гэж цахим харилцааны технологийг ашиглан бүтээсэн холбоосыг хэлнэ. Шүүхэд их хэмжээтэй, нарийн төвөгтэй материалыг шүүх үнэлэхэд хүндрэлтэй тохиолдолд нотлох баримтыг цахим болон бусад хэрэгслээр шүүхэд өгөх боломжтой¹⁵⁷.

Ром-Германы болон Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хууль тогтоомжийг харьцуулж үзвэл Англи-Саксоны эрх зүйн тогтолцоонд хамаарах улс орнуудын хууль тогтоомж нь цахим нотлох баримтын ойлголтыг илүү өргөн хүрээнд тусгасан бөгөөд уламжлалт болон цахим хэлбэрээр олж авсан нотлох баримтыг ялгахгүйгээр цахим технологитой холбоотой аргаар олж авсан, бэхжүүлсэн нотлох баримт гэж тодорхойлсон байна.

Цахим нотлох баримтыг тодорхойлсон эх сурвалжуудыг үзэхэд тодорхой шаардлага тавихаасаа илүү нийтлэг шинжүүдийг тодорхойлсон байдаг байна. Тухайлбал, онцлог шинжээс нь хамаарч цахим нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, хураан авах процесс ажиллагааны онцлогууд тодорхойлогдож байна.

Олон улсын эрх зүйн хүрээнд цахим нотлох баримтыг цуглуулах бэхжүүлэх талаар эрх зүйн үндэслэл болох баримт бичгийн нэг нь Цахим гэмт хэргийн тухай 2001 оны Будапештын конвенц юм. Монгол Улс тус конвенцод одоогоор нэгдэж ороогүй байна.

Будапештийн конвенц нь компьютерын систем, сүлжээ, өгөгдлийн нууцлал, бүрэн бүтэн байдал, ашиглалтын эсрэг чиглэсэн халдлагыг таслан зогсоох, энэ төрлийн халдлагыг гэмт хэрэг болгон хуульчлах, түүнийг дотоодод болон олон улсын түвшинд илрүүлэх, мөрдөх, яллах, тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоомж батлах, олон улсын хамтын ажиллагааг шуурхай зохион байгуулах зэрэг асуудлыг зохицуулсан.¹⁵⁸ Мөн конвенц нь хүний эрхийг хүндэтгэн цахим ертөнцтэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, зүйлчлэх, яллах үйл ажиллагааг хөнгөвчлөх арга замыг тогтоох зорилготой¹⁵⁹.

Энэхүү конвенц нь интернэт болон бусад компьютерын сүлжээгээр үйлдэгдсэн гэмт хэрэг, ялангуяа зохиогчийн эрхийн зөрчил, компьютерын луйвар, бэлгийн

157 Сингапурын Нотлох баримтын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулга.
<https://sso.agc.gov.sg/Act/EA1893>

158 Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа, Нээлттэй нийгэм форум, 2022

159 Цахим гэмт хэргийн тухай 2001 оны Будапештын конвенц. <https://rm.coe.int/1680081561>

мөлжлөг, сүлжээний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай анхны олон улсын олон талт гэрээ юм. Тус конвенцын хоёрдугаар бүлгийн хоёрдугаар хэсэгт цахим нотлох баримттай холбоотой процессын ажиллагаа хамарсан зохицуулалтууд орсон. Тухайлбал, тус Конвенцын 14 дүгээр зүйлд зааснаар конвенцын гишүүн улсууд нь мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд цахим нотлох баримттай холбоотой дараах гэмт хэрэг, ажиллагааг хамааруулж үзэхээр заасан байна¹⁶⁰. Үүнд:

- компьютерын мэдээлэл, сүлжээгээр үйлдэгдсэн гэмт хэрэг (тухайлбал, зохиогчийн эрхийн зөрчил, компьютерын луйвар, бэлгийн мөлжлөг, сүлжээний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг);
- компьютер, компьютерын сүлжээг ашиглан үйлдсэн бусад гэмт хэрэг;
- гэмт хэргийн цахим нотлох баримт цуглуулах зэрэг юм.

3.3. Гадаадаас цахим нотлох баримтыг олж авах практик алхмууд

Цахим хэлбэрээр хадгалагдаж буй мэдээллийн биет бус шинж чанар нь цахим нотлох баримтыг уламжлалт нотлох баримттай харьцуулахад хэврэг болгодог. Компьютерын санах ой, төхөөрөмж дээр хадгалагдаж буй цахим нотлох баримт нь энергийн эх үүсвэрээс хамааралтай бөгөөд тогтворгүй байдаг, учир нь үүнийг зориудаар эсхүл ердийн хэрэглээний явцад амархан өөрчлөх, дарж бичих, эвдэх эсхүл устгах боломжтой¹⁶¹.

Энэ нь мөрдөн шалгах ажиллагаанд тодорхой хүндрэл бэрхшээлийг бий болгодог бөгөөд цахим нотлох баримтыг шүүх шинжилгээний бусад төрлийн нотлох баримтын нэгэн адил олж авах, хэрэглэх ажиллагааг зөв тогтоох нь чухал ач холбогдолтой. Үүнд цахим нотлох баримтыг үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу олж авах, шүүхэд нотлох баримтын хэмжээнд ашиглах баталгааг хангах үүднээс зохих нарийвчилсан журам, арга хэрэгсэл болон арга техник нь чухал ач холбогдолтой юм.

Цахим нотлох баримт нь олон талаараа уламжлалт нотлох баримттай (баримт бичиг, зураг, гэрчийн мэдүүлэг, ДНХ-ийн шинжилгээ гэх мэт) адил бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “нотлох баримт”-ын хэмжээнд ашиглах тохиолдолд уг нотлох баримтыг анх олж авсан цагаас хойш өөрчлөгдөөгүй гэдгийг шүүхэд нотлох шаардлага гардаг.

Шүүхэд цахим нотлох баримтыг ерөнхийд нь бусад төрлийн нотлох баримтын нэгэн адил авч үзэх бөгөөд ихэнх тохиолдолд бичгийн нотлох баримтын уламжлалт хэлбэрт хамаарах хууль тогтоомжоор зохицуулна.

Тухайлбал, өмгөөлөх талын зүгээс цахим нотлох баримттай холбоотой гаргадаг нийтлэг эсэргүүцэл нь хураан авсан цахим төхөөрөмжид үзлэг, нэгжлэг хийсэн байдлыг эсэргүүцэх (жишээ нь, эрэн сурвалжлах зөвшөөрлийг зохих ёсоор олж

¹⁶⁰ Мөн тэнд.

¹⁶¹ PILON Mutual Legal Assistance Handbook: Cybercrime & Electronic Evidence

аваагүй эсхүл гүйцэтгээгүй), нотлох баримтын бүрэн бүтэн байдлыг эсэргүүцэх зэрэг ордог байна.

Нотлох баримтыг цуглуулах, шалгах, бэхжүүлэх талаар Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ердийн журам нь цахим нотлох баримтыг цуглуулах, шалгах, бэхжүүлэхэд мөн хамааралтай болохыг өмнө дурдсан. Иймд мөрдөн шалгах ажиллагааны явцад гадаад улсад эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээх замаар аливаа нотлох баримтыг, түүний дотор цахим нотлох баримттай холбоотой ажиллагааг хийх боломжтой байна.

Улс орнууд үндэсний хууль тогтоомждоо тусгаж, зохицуулсан байдлаар нь ерөнхийд нь цахим нотлох баримтыг олж авахад чиглэсэн дараах алхмуудыг тодорхойлж болох ба цахим нотлох баримтын онцлогоос хамааран тэдгээр алхмуудын хүрээнд авах арга хэмжээ, холбогдох хүсэлтүүдэд тавигдах шаардлагууд нь өөр өөр байна.

- цахим нотлох баримтыг хамгаалах, хадгалах арга хэмжээ авах;
- эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнөх ажиллагаа;
- эрх зүйн туслалцааны хүсэлт илгээх зэрэг болно.

Цахим нотлох баримтыг мэдээллийн төрөл бүрийн сангууд, тэдгээртэй холбоотой үйлчилгээ эрхлэгчдээс олж авах боломжтой. Үйлчилгээ эрхлэгчээс өгөх мэдээлэл нь тодорхой хязгаарлалттай байж болох бөгөөд мэдээллийн сангуудаас шууд авах боломжтой мэдээллээс бусад мэдээллийг эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах замаар олж авдаг байна¹⁶².

3.3.1 Цахим нотлох баримтыг хамгаалах, хадгалах арга хэмжээ авах

Цагдаагийн байгууллагын зүгээс цахим гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах, цахим нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх чадамжид интернэт үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ажиллах нь чухал юм. Ихэнх үйлчилгээ эрхлэгч хууль сахиулах байгууллагууд харилцан хандсан контентын бус мэдээллийг өгөхөд бэлэн байдаг. Жишээ нь, захиалагч, хөдөлгөөний өгөгдлийн (traffic data) мэдээлэл зэрэг. Харин ихэнх үйлчилгээ эрхлэгч нь контентын өгөгдөл өгөхийн тулд албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлт ирүүлэхийг шаарддаг бөгөөд зарим нь ямар ч мэдээлэл өгөхөөс өмнө албан ёсны эрх зүйн туслалцааны ирүүлэхийг хүсэлт шаарддаг¹⁶³.

Ихэнх үйлчилгээ эрхлэгчид АНУ-д байрладаг тул тэдгээр үйлчилгээ үзүүлэгчдээс интернэт бичлэг (контентын болон контентын бус) авахыг хүсэхдээ АНУ-ын хуулийн шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Цахим нотлох баримт нь хэврэг, тогтворгүй шинж чанартай учраас өгөгдлийг хамгаалах, хадгалах ажиллагааг эхний ээлжид гүйцэтгэх шаардлагатай. Хамгаалах

162 UNODC guide (vii) UNODC Practical Guide for Requesting Electronic Evidence Across Borders, 2019

163 PILON Mutual Legal Assistance Handbook: Cybercrime & Electronic Evidence

буюу аюулгүй байдлыг хангах нь хэрэглэгчийн хүсэлтийг хүлээн авч, боловсруулах үед хадгалагдах ёстой хэрэглэгчийн бүртгэлийн “Snapshot” (зураг) үүсгэх явдал юм. Хэрэглэгч мэдээллээ устгах, хэлбэрийг нь өөрчлөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд ихэнх үйлчилгээ эрхлэгчид хууль сахиулах байгууллагуудад цахим нотлох баримтыг хамгаалах, хадгалах асуудлаар шууд холбогдох боломжийг олгодог¹⁶⁴.

Цахим нотлох баримтыг хамгаалах, хадгалах арга хэмжээ авах шатанд дараах асуудлыг дэс дараатай гүйцэтгэнэ¹⁶⁵:

1. Үйлчилгээ эрхлэгчийн өгөгдлийн мэдээллээ удирддаг, хадгалдаг газрыг тодорхойлох:

Үйлчилгээ эрхлэгчийн өгөгдлийн мэдээллээ хадгалдаг газраас илүүтэйгээр өгөгдлийн мэдээллээ удирддаг, хадгалдаг газрыг тодорхойлох нь зүйтэй бөгөөд энэ талаар үйлчилгээ эрхлэгчтэй шууд холбогдон тодруулах шаардлагатай.

2. Цахим нотлох баримт байгаа эсэхийг тогтоох:

Хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээг харгалзан зарим үйлчилгээ эрхлэгчид зөвхөн хязгаарлагдмал хэмжээний өгөгдлийг тодорхой хугацаанд хадгалдаг. Тухайлбал, WhatsApp мессеж илгээж, нээсний дараа болон мэдээллийн хөдөлгөөний өгөгдлийг (traffic data) хадгалдаггүй. WhatsApp хүргэгдээгүй мессежийг серверээс 30 хоногийн дараа устгадаг.

3. Цахим нотлох баримтын аюулгүй байдлыг хангаж хамгаалах тухай хүсэлт илгээх:

Энэхүү ажиллагааг гүйцэтгэхдээ цагдаа болон шүүхийн байгууллага нь:

- үйлчилгээ эрхлэгчтэй шууд холбогдож болно;
- үйлчилгээ эрхлэгчтэй шууд холбогдох боломжгүй тохиолдолд цагдаагийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны сувгуудаар, эсхүл Европын зөвлөлийн 24/7, G7-ийн 24/7, ИНТЕРПОЛ-ын i24/7 гэх зэрэг сувгуудаар холбогдож болно;
- үйлчилгээ эрхлэгчийн улсын хуулиар үйлчилгээ эрхлэгчтэй шууд холбогдохыг хориглодог ба цагдаагийн хамтын ажиллагааны хүрээнд хандах боломжгүй тохиолдолд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай албан ёсны хүсэлт илгээж болно.

АНУ болон Канадын томоохон үйлчилгээ эрхлэгчид аюулгүй байдлыг хангах тухай хүсэлтийг гадаадын эрх бүхий хууль сахиулах байгууллагын албан ёсны цахим шуудангийн хаягаас шууд хүлээн авдаг (өөрөөр хэлбэл, Yahoo, Gmail-ийн бүртгэлээс хүлээн авдаггүй).

4. Хугацаа сунгах:

¹⁶⁴ Мөн тэнд.

¹⁶⁵ UNODC guide (vii) UNODC Practical Guide for Requesting Electronic Evidence Across Borders, 2019

АНУ, Канадын ихэнх үйлчилгээ эрхлэгчид цахим нотлох баримтыг 90 хоног хадгалдаг. Хадгалах тухай хүсэлт хүлээн авсны дагуу хадгалах хугацааг тогтоох бөгөөд бичгээр нэмэлт хүсэлт гаргасан нөхцөлд тухай хугацааг 90 хүртэлх хоногоор сунгаж болно. Аюулгүй байдлыг хангах хүсэлт илгээсний дараа хууль сахиулах байгууллага, прокурор, шүүхийн ажилтнууд цахим нотлох баримтыг олж авах аргуудын нэгийг (шууд хүсэлт илгээх, эсхүл эрх зүйн туслалцааны хүсэлт илгээх) сонгож хүсэлтээ илгээх бэлтгэл ажлыг хангана.

3.3.2. Эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнөх ажиллагаа

Үйлчилгээ эрхлэгчээс зарим төрлийн цахим нотлох баримтыг гаргуулж авахад улс орнууд заавал албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлт ирүүлэхийг шаарддаггүй. Иймд цахим нотлох баримтыг хурдан аргаар авах боломжуудыг оролдож үзэж болно. Тухайлбал:

- нээлттэй эх сурвалжаас хайх;
- үйлчилгээ эрхлэгчид шууд хандан хүсэлт гаргах;
- бүртгэлийн (account) хэрэглэгчтэй шууд холбогдож түүний татан авч хадгалсан нотлох баримтыг гаргаж өгөхийг хүсэх;
- үйлчилгээ эрхлэгч бүртгэл (account) хэрэглэгчийн зөвшөөрлөөр цахим нотлох баримтыг бүртгэлийн мэдээллээс гаргаж өгөх;
- шүүхийн захирамжид үндэслэн, эсхүл сайн дурын үндсэн дээр мэдээлэл гаргуулах хэлбэрээр явагдах цагдаагийн хамтын ажиллагааны хүрээнд болно.

1.Нээлттэй эх сурвалжаас хайх

Цахим нотлох баримтыг гаргуулж авахаар гадаад улсад хандахаас өмнө дотоодын бүх арга хэрэгслээ хэрэглэсэн эсэхийг нягтлах хэрэгтэй. Үүнд нээлттэй мэдээллийн эх сурвалжаас хайлт хийх орно (IP хаяг зэрэг онлайн – хэрэгсэл ашиглан хэрэглэгчийн байрлалыг тогтоох, домейн нэрний эзэмшигчийг тогтоох, олон нийтэд нээлттэй нийгмийн сүлжээний бүртгэлээр (account) гэмт хэрэг үйлдэгдсэнийг нотлох гэх мэт).

2.Үйлчилгээ эрхлэгчид шууд хандан хүсэлт гаргах:

Үйлчилгээ эрхлэгчид зарим яаралтай биш тохиолдолд хууль сахиулах, прокурор болон шүүхийн байгууллагын шууд хандсан хүсэлтийн дагуу цахим нотлох баримтыг гаргаж өгөх боломжтой байдаг. Тухайлбал:

- хэрэглэгч зөвшөөрсөн тохиолдолд;
- хэрэглэгч нас барсан тохиолдолд ойрын садан төрлийн хүнд зөвшөөрч холбогдох шүүхийн захирамж гарсан бол;
- гадаад улсын хууль сахиулах, прокурор болон шүүхийн байгууллагаас мэдээллийн хөдөлгөөний өгөгдлийн талаар шууд хандан хүсэлт гаргасан бол.

Үйлчилгээ эрхлэгчид хууль сахиулах байгууллагаас шууд гаргасан хүсэлтийн дагуу агуулгын талаарх мэдээллийг сайн дурын үндсэн дээр гаргаж өгөхгүй. Хэрэглэгч зөвшөөрснөөс бусад тохиолдолд агуулгын талаарх мэдээллийг албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлт илгээж авах боломжтой.

3. Цагдаагийн байгууллага хоорондын гадаад хамтын ажиллагаа:

Цагдаагийн албадын гадаад хамтын ажиллагааг зохион байгуулах, цагдаагийн байгууллагад бэлэн байгаа мэдээлэл болон мөрдөн шалгах ажиллагааны талаар мэдээлэл солилцоход зориулсан хэд хэдэн суваг байдаг бөгөөд тэдгээрийн үндэсний хэмжээнд үйлчлэх эрх бүхий байгууллага, холбоо барих төвүүд байдаг. Тухайлбал, ИНТЕРПОЛ болон 24/7 сүлжээний Үндэсний төв товчоо, ЕВРОПОЛ, EuroMed Police гэх зэрэг.

3.4. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт илгээх

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай албан ёсны хүсэлтийг дараах тохиолдолд гаргана.

Үүнд:

- цахим нотлох баримтыг нээлттэй мэдээллийн эх сурвалжаас олж авч чадаагүй;
- үйлчилгээ эрхлэгч шууд хандан гаргасан хүсэлтийн дагуу цахим нотлох баримтыг гаргаж өгөөгүй;
- контентын мэдээлэл хэрэгтэй байгаа;
- өгөгдлийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах боломжгүй бөгөөд устгах эрсдэлээс сэргийлж яаралтай олж авах шаардлагатай байгаа;
- сайн дурын үндсэн дээр гаргаж өгсөн нотлох баримт шаардлага хангахгүй байх зэрэг болно.

Нотлох баримтыг шуурхай олж авахын тулд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтэд шаардлагатай байгаа тусламж болон яагаад холбогдох цахим нотлох баримтыг авах шаардлага байгааг хүсэлт хүлээн авах улсын хуулийн шаардлагад (стандартад) үндэслэн тодорхой заасан байна.

Хадгалагдсан нотлох баримт болон хөдөлгөөний өгөгдлийн (traffic data) мэдээлэл авах тухай эрх зүйн туслалцааны хүсэлт гаргахад тавигддаг зарчим, шаардлагын талаар АНУ-ын жишээн дээр тайлбарлая.

Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт боловсруулах хэл

Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт нь албан ёсны, хуулийн үр дагавартай баримт бичиг учраас хүсэлт хүлээн авч буй улсад ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл хүсэлт хүлээн авсан улсад хүсэлтийг биелүүлэх болон яаж биелүүлэх талаар шийдвэр гаргахад шаардлагатай бүх мэдээллийг ойлгомжтой байдлаар тусгасан байна.

Хүсэлт боловсруулахдаа албан ёсны нэр томьёо ашиглах бөгөөд товчлол хэрэглэхдээ эхлээд заавал тайллыг дурдана. Ярианы үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй хэдий ч, нотлох баримтын төрөлд тохирсон хэллэгийг ашиглаж болно. Тухайлбал, Snapchat дээрх мессежийг “Snaps” гэж нэрлэх.

Гол зорилго нь шүүхээс аливаа шийдвэр гаргахад шаардлагатай тодорхой байдлыг хангаж, уншиж буй хүнд агуулгыг шууд хүргэх, уншихад хялбар баримт бичгийг боловсруулахад оршино.

Яаралтай байдал

Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтэд “яаралтай” гэсэн тэмдэглэгээг онцгой тохиолдлоос бусад тохиолдолд хэрэглэхгүй байх нь зүйтэй. Мөн цахим нотлох баримт гаргаж өгөх хүсэлтэд тодорхой үйл баримтаас (урьдчилан хорих хугацаа дуусах г.м.) хамаарахаас бусад тохиолдолд хүсэлтийг биелүүлэх хугацаа тавихаас зайлсхийх нь зүйтэй гэж зөвлөдөг¹⁶⁶. Энэхүү хугацаа дууссан тохиолдолд хүсэлт хүлээн авагч улс мэдээлэл цуглуулах ажиллагааг зогсоогоод хүсэлтийг архивд шилжүүлэх эрсдэл бий болдог байна. Мөн энэхүү хугацааг бодит биш гэж үзвэл анхнаасаа хүсэлтийг биелүүлэх боломжгүйд тооцох магадлалтай анхаарах шаардлагатай. “Яаралтай” гэсэн тэмдэглэгээг хэрэглэх тохиолдолд яагаад гэсэн шалтгааныг заавал зааж өгнө.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхдээ хугацаа хожих зорилгоор холбогдох олон улсын гэрээг судалж хүсэлтийг дипломат суваг ашиглахгүйгээр шууд эрх бүхий төв байгууллагад хүргүүлэх боломжтой эсэх, цахим шуудан ашиглаж болох эсэхийг тогтооно.

Эрх зүйн үндэслэл

Зарим улсууд зөвхөн олон улсын гэрээний үндсэн дээр эрх зүйн туслалцаа үзүүлдэг бол зарим нь холбогдох гэрээ хэлэлцээр байхгүй ч харилцан адил байх зарчим, эсхүл үндэсний хууль тогтоомжийн заалтыг үндэслэн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлдэг байна.

Эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээн авсан улс нь олон улсын гэрээг үндэслэл болгохыг шаарддаг бол хүсэлтийг хоёр талт эсхүл олон талт (тухайлбал, бүс нутгийн, дэд бүс нутгийн) олон улсын гэрээнд үндэслэж болно. Зарим олон улсын олон талт гэрээ нь эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалтыг тусгайлан тусгасан байдаг бол зарим нь тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг зохицуулж, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудлыг ерөнхийд нь тусгасан байдаг.

166 UNODC guide (vii) UNODC Practical Guide for Requesting Electronic Evidence Across Borders, 2019

Хэдийгээр олон улсын гэрээнүүдийн ихэнх нь цахим нотлох баримтыг эрх зүйн харилцан туслалцааны хүрээнд авах асуудлыг тусгайлан дурдаагүй ч тухайн гэрээнд заасан нотлох баримттай холбоотой заалт нь эрх зүйн үндэслэл болох боломжтой.

Дараах бүс нутгийн болон дэд бүсийн баримт бичиг, конвенцод олон улсын хамтын ажиллагаа, цахим нотлох баримт болон цахим гэмт хэрэгтэй тэмцэх талаар тодорхой дурдсан байдаг. Үүнд:

Конвенцын нэр	Конвенцын нэр англи хэлээр	Баталсан он
Цахим гэмт хэргийн тухай Европын зөвлөлийн конвенц (Будапештын конвенц)	The Council of Europe Convention on Cybercrime	2001 он
Цахим гэмт хэрэг болон хувийн мэдээлэл хамгаалах тухай Африкийн холбооны конвенц	The African Union Convention on Cybersecurity and Personal Data Protection	2014 он
Мэдээллийн технологийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай Арабын конвенц	The Arab Convention on Combating Information Technology Offences	2010 он
Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн улсууд хооронд компьютерын мэдээллийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтран ажиллах тухай гэрээ	Agreement on cooperation among the States Members of the Commonwealth of Independent States in combating offences relating to computer information	2001 он
Хамтын нөхөрлөлийн орнуудын эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх шинэчилсэн төлөвлөгөө	The Revised Scheme relating to Mutual Assistance in Criminal Matters within the Commonwealth	2011

Монгол Улсын хувьд одоогоор эдгээр конвенцод нэгдэж ороогүй байгаа.

Хүсэлтийн зорилго

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн эхэнд дараах мэдээллийг дурдана:

хэрэгт холбогдогч (сэжигтэн, яллагдагч) бүрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд: бүтэн овог, нэр, төрсөн он сар өдөр, иргэншил, хаяг, паспортын дугаар болон бусад. Мөн хэргийн шийдвэрлэлтийн үе шатыг дурдах нь зүйтэй;

шаардлагатай байгаа нотлох баримт, мөрдөн шалгах ажиллагааны арга, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт илгээхээс өмнө (шууд хүсэлт явуулах замаар) авсан цахим нотлох баримтын талаар мэдээлэл.

Тухайн хэрэгт холбогдох хуулийн заалт

Энэ хэсэгт холбогдох хууль тогтоомжийн хураангуйг дурдах шаардлагатай (өөрөөр хэлбэл шалгагдаж буй гэмт хэргийн зүйлчлэлийн мэдээлэл).

Зарим улсууд тухайн гэмт хэрэг хүсэлт илгээгч болон хүлээн авагч талын аль алинд нь гэмт хэрэгт тооцогддог тохиолдолд л туслалцаа үзүүлдэг. Мөн тухайн гэмт хэрэгт оногдуулж болох ял шийтгэлийн мэдээллийг анхаарах хэрэгтэй.

НҮБ-ын "UNODC Sherloc" мэдээллийн сан, НҮБ-ын МБГХТА-ны "Crime Repository" мэдээллийн сан, Европын зөвлөлийн "Europe website"-аас улс, орнуудын хууль тогтоомжийн мэдээллийг авах боломжтой.

Мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон нөхцөл байдал

Энэ хэсэгт ямар цахим нотлох баримтыг авахыг хүсэж байгаа, эдгээр цахим нотлох баримт нь яагаад хүсэлт гаргагч улсад хэрэгтэй байгаа, холбогдох үйл баримт нь хүсэлт хүлээн авагч улсын хуулийн болон бусад зохицуулалтад хэрхэн нийцэж байгаа талаар мэдээллийг тусгана. Эдгээр мэдээллийг товч, тодорхой, ойлгомжтой байдлаар илэрхийлж бичнэ.

Үйл баримтууд нь эрүүгийн хэрэг үүсгэхэд хангалттай эсэх, тухайн хүн дурдсан гэмт хэргийг үйлдсэн, эсхүл тухайн гэмт хэргийн үйлдсэн хүн нь тодорхойгүй нөхцөлд тухайн гэмт хэрэг гарсан болохыг боломжоороо тодорхойл оруулсан байна. Мөн эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтэд хүсэлт хүлээн авагч улсад "хувийн халдашгүй байдал"-д халдаж аливаа албадлагын арга хэмжээ авахад хангалттай итгэл үнэмшил төрүүлэхээр мэдээлэл, баримт бичгийг хавсаргаж өгөх нь зүйтэй.

Apple, Google, Microsoft, Facebook, Yahoo!, Twiter, Ebay гэх зэрэг ихэнх томоохон үйлчилгээ эрхлэгчид АНУ-д байрладаг тул эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийн агуулгад тавигддаг шаардлагыг АНУ-ын жишээн дээр товч танилцуулъя¹⁶⁷:

167 UNODC guide (vii) UNODC Practical Guide for Requesting Electronic Evidence Across Borders, 2019

Хүсэлтийн агуулгад тавигдах шаардлага:**1. Хэрэглэгчийн мэдээлэл (Basic subscriber information)***Хуулийн шаардлага (стандарт)*

Хэрэглэгчийн мэдээллийг авахад хүссэн цахим нотлох баримт нь эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд хамааралтай, ач холбогдолтой болохыг тогтоох ёстой. Сэжигтэн, яллагдагч нь цахим шуудан эсхүл нийгмийн сүлжээнд ямарваа нэг хаягтай гэдгийг харуулах нь хангалтгүй, харин тэдгээр нь шалгагдаж буй гэмт хэрэгтэй холбоотой болохыг нотолно. Энэ нь мөрдөн шалгах бүх ажиллагаанд тавигддаг хуулийн хамгийн эхний шаардлага (стандарт) юм.

Хэрэглэгчийн талаар авах боломжтой мэдээлэл:

- Хэрэглэгчийн /user or subscriber's/ бүртгэл эсхүл бүртгэлийн нэр;
- Хэрэглэгчийн /user's / нэр болон хаяг;
- Хэрэглэгчийн /user's / утасны дугаар;
- Хэрэглэгчийн /user's / цахим шуудангийн хаяг;
- Анх бүртгүүлсэн огноо, цаг, бүртгэлийн төрөл, гэрээний хуулбар, бүртгүүлэх үеийн биеийн байцаалт, хэрэглэгчийн өгсөн баримт бичгийн хуулбар;
- Хэрэглэгчийн /user or subscriber's/ хувийн байдалтай холбоотой бусад чухал мэдээлэл;
- Үйлчилгээний төрөл, үүнд баталгаажуулагч орно (утасны дугаар, интернэт-протоколын хаяг (IP хаяг), "SIM" картын дугаар, "Mac"- хаяг) болон холбогдох төхөөрөмж(үүд);
- "Profile" мэдээлэл (хэрэглэгчийн нэр);
- Хэрэглэгчээс өгсөн нэмэлт и-мэйл хаяг зэрэг үйлчилгээ ашигласныг шалгах/ баталгаажуулах мэдээлэл;
- Дебит эсхүл кредит картын мэдээлэл (хэрэглэгчээс нэхэмжлэл гаргах зорилгоор өгсөн), үүнд төлбөрийн хэрэгсэл орно;
- Хэрэглэгч цахим бүртгэл бүртгүүлэхэд, эсхүл үйлчилгээг өөр хэлбэрээр ашиглаж эхлэхдээ хэрэглэсэн IP хаяг;
- Өөрийн цахим бүртгэлдээ нэвтрэхдээ хэрэглэсэн бүх IP хаягууд;
- Бүх нэвтрэлтийн цаг, огноо, үргэлжилсэн хугацаа;
- Хэрэглэгчийн хувийн байдалтай холбоотой бусад мэдээлэл, үүнд нэхэмжлэл гаргах мэдээлэл орно (кредит картын төрөл болон дугаар, оюутны бүртгэлийн дугаар болон бусад таньж тогтоох мэдээлэл).

2. Мэдээллийн хөдөлгөөний өгөгдөл (Traffic data)

Хуулийн шаардлага (стандарт)

Ихэнх төрлийн “Traffic data” мэдээллийг авахын тулд тухайн бичилт мэдээлэл нь мөрдөн шалгах ажиллагаанд чухал ач холбогдолтой болохыг харуулсан тодорхой үйл баримтыг өгөх шаардлагатай. АНУ-д мэдээллийн хөдөлгөөний өгөгдлийн (traffic data) талаарх сангаас мэдээлэл авахад тавигддаг шаардлага бол хуулийн дагуу авсан лавлагаа байдаг. Үүнийг нийт улсын хэмжээний мэдээллийг хадгалдаг “Үүлэн мэдээллийн сан”-д тусгай эрх нээлгэн авах боломжтой бөгөөд тухайн авах баримт нь хэрэгт авагдсан бусад баримттай хэрхэн уялдаж байгааг тайлбарласан байхыг шаарддаг. Энэ нь АНУ-ын прокурорууд тухайн авах баримт нь хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд ямар ач холбогдолтойг нотлох зорилгоор мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон нөхцөл байдлын талаарх мэдээллийг шүүхэд заавал өгөх шаардлагатай байдагтай мөн холбоотой. Ийнхүү нотлох баримтыг мэдээллийн сангаас авахыг зөвшөөрч байгаа шүүхийн шийдвэрийг “Д-захирамж” (D-order) гэж нэрлэдэг.¹⁶⁸

Авах боломжтой Мэдээллийн хөдөлгөөний өгөгдөл (Traffic data)-ийн төрөл:

Интернэтийн үйлчилгээ эрхлэгчдээс:

- Холбогдох цэг буюу холболтын эх үүсвэр
- Холболтын цаг, огноо
- Холболтоос салсан цаг, огноо
- Системд холбогдсон арга (тухайлбал, telnet, ftp, http)
- Дамжуулсан өгөгдлийн хэмжээ (тухайлбал, хэдэн байт)
- Маршрутын мэдээлэл (Эх үүсвэрийн IP хаяг, очих газрын IP хаяг, порт /portal/-ын дугаар, браузер, и-мэйлийн гарчгаас авсан мэдээлэл, мессэжийн-ID)
- Таних зорилгоор авах IP холболтын бүртгэлийн мэдээлэл
- Бүртгэлд бичигдсэн аливаа дүрс, бусад баримт бичгийн мэдээлэл, үүнд хандалт хийсэн хугацаа, огноо болон файлын хэмжээ орно /гэхдээ файлын агуулга орохгүй/
- Тодорхой дүрсэд/файлд/вэб хуудаст заасан цаг, хугацаанд хандалт хийсэн хүмүүсийн нэрс болон бусад хувийн байдлыг тогтоох мэдээлэл
- Өгөгдлийн хэмжээ

168 Шүүгчийн захирамжийн талаар АНУ-ын Цахим харилцаа холбооны мэдээллийг хамгаалах тухай хуулийн 2807(d)-д заасан байдаг тул “D захирамж” гэж нэрлэдэг.

Вэб байршуулах (Web hosting) үйлчилгээ эрхлэгчдээс:

- бүртгэлийн файл
- үйл явдал
- худалдан авалтын түүх
- урьдчилгаа төлбөрийн зарцуулалтын түүх
 - ххх бүртгэлийн хэрэглэгч (шууд хүсэлтээр мэдээлэл ирүүлсэн тохиолдолд)
- “Мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдсон”, “магадлалтай байна” гэх мэт үг хэрэглэхгүй байх. Харин яг ямар ажиллагаа хэрэгжүүлсэн, үүнийг нотлох баримтаар хэзээ, хэрхэн харуулж байгаа талаар;
- Хэрэгт холбогдох тодорхой хүний талаар мэдээлэл өгөх: тухайн хүн уг гэмт хэргийн зохиогч нь эсэх? Ямар үйл баримтаар нотлогдож байгаа талаар.

Хангалттай үндэслэлтэй байх гэсэн шаардлагад үйл баримтууд нийцэж байх

Энэ нь хэрэгт цугларсан нотлох баримт болон авах шаардлагатай байгаа нотлох баримтын тухайн гэмт хэрэгт холбогдох шалтгаант холбоог хэрхэн харуулахаас хамаарна

.Зарим тохиолдолд хэрэгт цугларсан нотлох баримт нь хангалттай үндэслэлтэй байх шаардлагад нийцдэггүй. Энэ тохиолдолд эхлээд хэрэглэгчийн мэдээллийн (Subscriber information) талаар эсхүл хөдөлгөөний өгөгдлийн талаар эрх зүйн туслалцааны хүсэлт боловсруулахыг зөвлөдөг. Энэхүү арга нь контентын талаар мэдээлэл авахад шаардлагатай үндэслэлийг шат дараатайгаар бүрдүүлэхэд тусална. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд контентын талаар мэдээлэл авах тухай эрх зүйн туслалцааны хүсэлтийг биелүүлэхэд хэрэгт цугларсан материал хангалтгүй гэсэн шийдвэрт хүргэх магадлалтай.

Контентын талаар мэдээлэл хүсэхэд уг мэдээлэл нь хэт хуучраагүй, сүүлийн үеийн байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл эрх зүйн туслалцааны хүсэлтийн үндэслэл болж буй үйл баримтын ядаж зарим нь сүүлийн үеийн байх буюу тухайн цахим нотлох баримт нь үзлэг, нэгжлэг хийх газарт байгаа магадлалыг харуулж байх шаардлагатай.

Үндэслэл нь найдвартай/баталгаатай мэдээлэл дээр тулгуурласан байх шаардлагатай. АНУ-ын хуулиар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглагдах бүх нотлох баримт нь найдвартай/баталгаатай буюу эх болон шалгаж болох, өндөр итгэл хүлээлгэсэн эх сурвалжаас гаралтай байх шаардлагатай.

Контентын талаар дараах төрлийн мэдээллийг авах боломжтой:

- хэрэглэгчийн бүртгэлд байгаа и-мэйл/мессэжийн аливаа агуулга, хэрэглэгч, түүний дотор и-мэйл/мессеж илгээхэд ашигласан компьютерын IP хаяг;
- аливаа хавсралт, гэрэл зураг, видео болон аудио бичлэг;
- холбоо барих жагсаалт;
- аливаа и-мэйлийн ноорог;
- сэргээх боломжтой аливаа устгагдсан и-мэйл;
- и-мэйлийн хогийн хайрцаг;
- онлайн агуулахын (хэрэглэгчийн үүсгэсэн өгөгдөл) хогийн хайрцаг;
- хуудасны хогийн хайрцаг;
- бүртгэлийн журнал/мессэжний нөөц хуулбар;

- серверийн агуулга/контент;
- аливаа нөөц хуулбар;
- хүсэлтэд заасан бүртгэлийн бичилт болон сервертэй холбоотой холбоотой бусад бичилт болон нотлох баримт. Тухайлбал, ийм бүртгэл эсхүл сервертэй холбоотой аливаа хүн эсхүл аж ахуйн нэгжийн захидал харилцаа болон холбоо барих мэдээлэл.

4.Одоо цагт мэдээллийн хөдөлгөөний өгөгдөл (Traffic data) цуглуулах

Хуулийн шаардлага

Одоо цагт мэдээллийн хөдөлгөөний өгөгдөл (Traffic data) цуглуулах гэдэг нь мэдээ/мэдээлэл хүрэх газартаа очоогүй явж байхад нь IP хаягийг өгч хөдөлгөөний (traffic) [жишээлбэл, и-мэйл илгээх эсхүл үйлчилгээ эрхлэгчид холбогдож буй хүнийг тодорхойлох боломжийг олгодог өгөгдөл] талаар мэдээллийг одоо цагийн горимд цуглуулах гэсэн үг.

Одоо цагт мэдээллийн хөдөлгөөний өгөгдөл (Traffic data) цуглуулахын тулд эрх зүйн туслалцааны хүсэлтэд бүртгэлийн болон бусад мэдээлэл нь гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хэрхэн ач холбогдолтой болохыг харуулах тодорхой үйл баримтуудыг заасан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл шардагдаж буй мэдээлэл нь мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэрэгтэй ямар шалтгаант холбоотой болохыг тайлбарлана. Шүүхээс холбогдох захирамжийг гаргасны дараа АНУ-ын хууль сахиулах байгууллага тухайн мэдээллийг бодит одоо цагийн горимд 60 хоногийн хугацаанд цуглуулж болох бөгөөд шаардлагатай бол (шүүх зөвшөөрсөн тохиолдолд) 60 хоногоор сунгуулж болно.

Цаг хугацааны хязгаар

Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтэд контентын өгөгдөл (content data) авахыг хүссэн бол хүсэлтэд дурдсан хамрах хугацаа нь бүхэлдээ хуулийн шаардлагад нийцсэн байна. Өөрөөр хэлбэл эрх зүйн туслалцааны хүсэлтэд сэжигтэн, яллагдагч нь гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэлийг агуулахаас гадна үйлчилгээ эрхлэгчээс авах материалд тухайн цаг хугацаанд тухайн гэмт хэрэг үйлдэгдсэнийг нотлох, эсхүл тухайн гэмт хэргийг үйлдэхэд цахим шуудангийн бүртгэлийн мэдээлэл, нийгмийн сүлжээний мессеж солилцох систем, цахим хуудсыг хэрэглэснийг нотлох баримт байгааг харуулах шаардлагатай.

АНУ-д цахим нотлох баримт авах хүсэлт илгээхдээ хэт урт цаг хугацааг хамруулбал хангалттай үндэслэл байх гэсэн шаардлага хангагдахгүй байх магадлалтай. Хамрах хугацаа бүрээр тус тусад нь хангалттай үндэслэл байгааг батлах нь илүү найдвартай. Тухайлбал, гэмт хэрэг 2015 оны 11 дүгээр сард үйлдэгдсэн байхад энэ хугацаанаас нэг жилийн өмнөх үеийн сэжигтний Facebook-ийн бүртгэлийн мэдээллийг авах шаардлагатай эсэх, шаардлагатай бол энэхүү мэдээлэл жилийн дараа үйлдэгдсэн гэмт хэргийг яаж нотлохыг харуулах шаардлагатай.

Хүсэж буй туслалцаа

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийн энэ хэсэгт шаардлагатай байгаа тодорхой цахим нотлох баримтын талаар бичих бөгөөд бүртгэл тус бүрээр ямар туслалцаа (холбогдох шүүхийн захирамж) шаардлагатай байгааг зааж өгнө.

Хүсэлтийг салаа утгагүй, тодорхой ойлгогдохоор боловсруулна. Хүсэлтэд дурсан туслалцаа тус бүрийн үндэслэл, товч мэдээллийг уншихад шууд ойлгогдож байх, хайлт хийхэд амар байхаар тус бүрийг нь дугаарлана.

Цахим нотлох баримт авах хүсэлт боловсруулахдаа цахим шуудангийн хаяг (aaaa@bbbb.com), IP хаяг (81.42,103,84), цахим хуудасны URL (<http://www.youtube.com/user/>), домейн нэр, сервер эзэмшигчийн нэрийг дурдана.

Нотлох баримтын хэлбэр

Нотлох баримтын хэлбэрийн талаарх мэдээллийг хүсэлтийн товч агуулгын тухай хэсэгт оруулах, мөн шаардлагатай бол хүсэж буй нотлох баримтын хэлбэрийн загварыг хүсэлтэд хавсаргах нь зүйтэй.

Хүлээн авсан нотлох баримтыг ашиглах

Эрх зүйн туслалцааны хүсэлтэд тухайн хүсэлтийн зорилгыг буюу нотлох баримтыг хэрэглэж болох зорилгыг зааж өгөх нь чухал. Хэргийн нөхцөл байдлыг харгалзан энэ хэсэгт “Хэрэв та бүхэн өөрөөр заагаагүй бол энэхүү хүсэлтийн дагуу хүлээн авсан нотлох баримтыг дээр дурдсан мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой эрүүгийн хэрэг болон бусад туслах ажиллагааны зорилгоор хэрэглэнэ” гэж тусгаж өгөх нь зүйтэй.

Цахим нотлох баримтыг хүлээн авсны дараа хүсэлт гаргагч улс тухайн нотлох баримтыг анх гаргасан эрх зүйн туслалцааны хүсэлтэд зааснаас өөр зорилгоор хэрэглэх бол хүсэлт хүлээн авагч улсын зөвшөөрлийг авах шаардлагатай байдаг. Энэхүү шаардлагыг биелүүлэхгүй байх нь шүүхэд тухайн нотлох баримтыг хэрэглэх боломжгүй болох эрсдэлтэй. Мөн цахим нотлох баримтыг хүсэлт хүлээн авагч улсын зөвшөөрөлгүйгээр өөр зорилгоор хэрэглэх нь ирээдүйд хүсэлт гаргагч болон хүлээн авагч улсуудын хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Өмнө нь хүлээн авсан байгаа цахим нотлох баримтыг өөр зорилгоор хэрэглэх зөвшөөрөл авахад дахин эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлт явуулах шаардлагагүй, хүлээн авагч улсын зөвшөөрсөн харилцаа холбооны хэрэгслийг ашиглаж, энэ тухай холбогдох бүртгэлийг хөтөлнө.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэж дууссаны дараа нотлох баримтыг хэрхэх талаар тодорхой мэдээлэл өгөх үүднээс эрх зүйн туслалцааны хүсэлтэд дараах агуулга бүхий хэсгийг оруулна: “Хэрэв Та бүхэн өөрөөр заагаагүй бол бид шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссаны дараа хүлээн авсан нотлох баримтыг хадгалахыг зөвшөөрсөн гэж ойлгоно”.

Нууцлал

Мөрдөн шалгах ажиллагааны нууц болон мэдээллийн эх үүсвэрийг хамгаалах зорилгоор шаардлагатай тохиолдолд эрх зүйн туслалцааны хүсэлтэд нууцлалыг хангах талаар болон холбогдох үндэслэл, шалтгааныг (хангалттай, итгэл төрүүлэхүйц) тодорхой дурдана. Тухайлбал, мэдээлэл задруулснаар дараах үр дагавар үүсэж болзошгүйг дурдах:

- хэн нэгэн этгээдийн амь нас, аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй;

- сэжигтэн оргон зайлах;
- нотлох баримтыг устгах, гуйвуулах;
- байж болох гэрчийг айлгах;
- мөрдөн шалгах ажиллагаанд ноцтой хохирол учруулах;
- шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үндэслэлгүйгээр саад учруулах болон бусад үр дагавар.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч байгаа тохиолдолд АНУ-д мэдээлэл задруулахгүй байх тухай захирамж тодорхой хугацаатай байдгийг анхаарах нь зүйтэй. Ийм тохиолдолд захирамжийн хугацааг байнга нягталж, дуусахаас нь өмнө түүнийг сунгуулах талаар АНУ-ын эрх бүхий төв байгууллагад хандаж хугацааг сунгуулахад дэмжлэг хүсэх шаардлагатай.

Эрх зүйн туслалцааны хүсэлтэд нууцлал хангах эсэх талаар (мэдээлэл задруулахгүй байх, хэргийн материалыг битүүмжлэх гэх мэт) заавал тусгаж байх шаардлагатай.

Нотлох баримтыг дамжуулах суваг

Цахим нотлох баримтыг эрх бүхий төв байгууллагаар дамжуулна. Нууцлалтай баримт бичгийг хүлээн авахдаа гарын үсэг зуруулж хүлээлгэн өгөхийг анхааруулах нь зүйтэй. Шаардлагатай тохиолдолд цахим нотлох баримтыг хамгаалах зорилгоор кодолсон хэрэгслээр дамжуулахыг хүсэж болно. Аль ч тохиолдолд хүсэлт хүлээн авагч улсаас цахим шуудангаар хүсэлтийн биелэлтийн талаар мэдээлэл ирүүлэх тул мэдээлэл хүлээн авах цахим шуудангийн хаягийг эрх зүйн туслалцааны хүсэлтэд тусгана.

Харилцан адил байх зарчим

Зарим улс эрх зүйн туслалцааны хүсэлтэд дурдсан мэдээллийг хүсэлт гаргагч улс өөрөө хууль тогтоомжийнхоо хүрээнд цуглуулах чадамжтай тохиолдолд эрх зүйн харилцан туслалцааг үзүүлдэг. Ийм тохиолдолд эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлтэд холбогдох баталгаагаа илэрхийлэх шаардлагатай.

Хэрвээ хүсэлт гаргагч улс ийм баталгааг өгөх боломжгүй бол тухайн улсын эрх төв бүхий байгууллага нь хүсэлт хүлээн авагч улсын эрх бүхий төв байгууллагатай холбогдон ийм хүсэлтийг биелүүлэх боломж байгаа эсэх талаар лавлах нь зүйтэй. Үүнийг хамгийн түрүүнд эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхээс өмнө цаг хугацаа, нөөц бололцоо алдахгүй байх зорилгоор гүйцэтгэх нь зүйтэй.

Энэхүү асуудлыг эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг цахим нотлох баримт авах талаар тусгагдаагүй олон улсын гэрээнд үндэслэн гаргаж байгаа тохиолдолд анхаарах хэрэгтэй. Хүсэлт гаргагч улс нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтэд түүний хууль тогтоомжид харилцан адил байх зарчмыг зохицуулсан тухай тусгах шаардлагатай.

Холбоо барих мэдээлэл

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг биелүүлэхтэй холбогдуулан аливаа асуулт, эсхүл баталгаажуулах нэмэлт мэдээлэл шаардлагатай болсон тохиолдолд тухайн хүсэлтийг

боловсруулсан алба хаагч болон мөрдөгчийн холбоо барих мэдээллийг хүсэлтэд тусгана. Үүнд: цахим шуудангийн хаяг, утас, болон харилцах хэлний талаар мэдээлэл байж болно.

Орчуулга

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулж дуусмагц түүнийг хүсэлт хүлээн авах улсын албан ёсны хэл рүү оруулна. Улс орнуудын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлт хүлээн авах хэлний талаарх мэдээллийг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргадаг эрх бүхий төв байгууллагуудын лавлахаас авах боломжтой.¹⁶⁹

Орчуулгыг зохих мэргэшсэн орчуулагчаар хийлгэх нь чухал байдаг. Чанаргүй орчуулга нь эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг биелүүлэхэд хүндрэл үүсгэж болзошгүй.

Нотлох баримтыг хойшлуулшгүй үед олж авах

Бодит (imminent) аюул заналхийлэл учрахаар тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт илгээхгүйгээр нэн даруй интернэтийн үйлчилгээ эрхлэгчид шууд хандаж цахим нотлох баримтыг ирүүлэхийг хүсэж болно. Энэхүү ажиллагаа нь хойшлуулшгүй яаралтай тохиолдолд хэрэглэх онгой ажиллагаа юм.

Энэхүү ажиллагааны хүрээнд үйлчилгээ эрхлэгч нь АНУ-ын биш төрийн байгууллагад:

- хэрэглэгчийн мэдээлэл (subscriber information),
- хэрэглэгчийн ойрын хугацаанд нэвтэрсэн мэдээлэл (recent login data)
- бусад хадгалагдсан мэдээллийг өгдөг¹⁷⁰.

Харин харилцааны контентын мэдээллийг зөвхөн АНУ-ын хууль сахиулах байгууллагад гаргаж өгдөг. Иймд цаг алдалгүй АНУ-ын Хууль зүйн департаментын эрх бүхий нэгжтэй холбоо барьж хүсэлт тавих арга хэмжээ авах шаардлагатай.

Энэхүү ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана:

1. Яаралтай байдал – хойшлуулшгүйгээр мэдээллийг олж авах шаардлага.

Хүсэлтэд яагаад уламжлалт ажиллагааг хэрэглэхгүй байгаа талаар тайлбарлана. Тухайлбал, террорист халдлагыг яаралтай зогсоох шаардлагатай байгаа бөгөөд уламжлалт ажиллагааг гүйцэтгэхэд хугацаа их шаардагдана. Ихэнх үйлчилгээ эрхлэгчид бодит (imminent) гэсэн тохиолдол биш бол мэдээлэл өгөхөөс татгалзах магадлалтай байдаг.

2. Бодит аюул заналхийлэл.

169 <https://www.unodc.org/unodc/en/legal-tools/directories-of-competent-national-authorities.html>

170 UNODC guide (vii) UNODC Practical Guide for Requesting Electronic Evidence Across Borders, 2019

Хүсэлтэд яагаад аюул заналхийлэл нь бодитойгоор учрахаар байгааг тайлбарлана. Тухайлбал, сэжигтний халдага үйлдэхээр шийдсэнийг итгэж болох гэрч мэдээлэл өгсөн.

3. Биет халдашгүй байдал.

Аливаа хүний амь нас хохирох, бие мах бодид ноцтой гэмтэл учрах эрсдэлтэй тохиолдолд итгэл үнэмшил төрүүлэхээр аль болох их мэдээлэл өгснөөр үйлчилгээ эрхлэгчдээс туслалцаа авах магадлал өснө.

АНУ-ын хуульд заасны дагуу дараах шаардлагыг цахим нотлох баримтыг хойшлуулшгүйгээр олж авах үндэслэлд тооцно¹⁷¹:

- хүний амь нас, эрүүл мэнд, бие махбодод болон байгууллагын үйл ажиллагаанд ноцтой гэмтэл, аюул занал учруулах эрсдэл үүссэн;
- цаг алдалгүй олж авах, эсхүл ил болгох шаардлагатай үндэслэл бүхий шалтгаан тогтоогдсон бол.

Хэрвээ үйлчилгээ эрхлэгч энэхүү ажиллагааны хүрээнд шаардлагатай мэдээлэл, дата гаргаж өгөхөөс татгалзсан бол АНУ-ын Хууль зүйн департаментын эрх бүхий нэгжтэй холбоо барьж хүсэлт гаргаж үзнэ, эсхүл ердийн журмаар холбогдох ажиллагааг эхлүүлнэ.

Хойшлуулшгүй тохиолдлын дараах жишээг дурдаж болно:

- хэн нэгэн хүн тэсрэх бодис байршуулж, идэвхжүүлсэн тухайгаа вэбсайт дээр мэдээлсэн;
- тагнуулын алба террорист бүлэглэлийн зарим харилцаа холбоог чагнаж тэсрэх бөмбөг дэлбэрэх магадлалтай болохыг мэдсэн;
- хүн хулгайлсан этгээд ар гэрийнхэнтэй утсаар холбогдож заналхийлсэн
- хүүхэд алга болсон;
- дэд бүтцийн байгууламжийн аюулгүй байдалд эрсдэл бий болсон гэх мэт.

Зарим интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн мэдээлэл:

Facebook	Online: Law Enforcement Online System Шуудангийн хаяг: 1601 Willow Road - Menlo Park, CA 94025 Зааварчилгаа: https://www.facebook.com/safety/groups/law/guidelines
Snapchat	И-мэйл хаяг: lawenforcement@snapchat.com Шуудангийн хаяг: Custodian of Records, Snap Inc. 63 Market Street - Venice, CA 90291 Яаралтай үед холбоо барих утас: +1 310-684-3062 Зааварчилгаа: https://storage.googleapis.com/snap-inc/privacy/lawenforcement.pdf

171 АНУ-ын хууль, 18 US Code § 2702 - Voluntary disclosure of customer communications or records, (b) (8) and (c) (4)

Whatsapp	Online: Emergency Disclosure Request И-мэйл хаяг: records@whatsapp.com Шуудангийн хаяг: WhatsApp Inc. 1601 Willow Road - Menlo Park, California 94025 Зааварчилгаа: https://faq.whatsapp.com/en/general/260000050
Instagram	Online: Law Enforcement Online Request System Шуудангийн хаяг: Attn: Law Enforcement Response Team 1601 Willow Road - Menlo Park, CA 94025 И-мэйл хаяг: lawenforcement@instagram.com Зааварчилгаа: https://help.instagram.com/494561080557017
Apple	АНУ-аас бусад Америкийн улсуудын засгийн газар болон эрх бүхий байгууллагууд: lawenforcement@apple.com Ази-Номхон далайн улсуудын засгийн газар болон эрх бүхий байгууллагууд: aras_police_requests@apple.com Европын, Газар дундын тэнгисийн болон Африкийн улсууд, Энэтхэгийн засгийн газар болон эрх бүхий байгууллагууд: law.enf.emeia@apple.com Яаралтай хүсэлтүүд: Засгийн газар болон хууль сахиулах байгууллагын яаралтай хүсэлтийн маягтыг exigent@apple.com хаягт илгээнэ. Зааварчилгаа: https://images.apple.com/legal/privacy/law-enforcement-guidelines-outside-us.pdf
Twitter	Online: Legal Request Submissions site Шуудангийн хаяг: Twitter, Inc. c/o Trust & Safety - Legal Policy 1355 Market Street, Suite 900 San Francisco, CA 94103 Факс: +1-415-222-9958 Зааварчилгаа: https://help.twitter.com/en/rules-and-policies/twitter-law-enforcement-support

